



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-76

1.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэх	6-38
2.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	38-52
3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/	52-76

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 07-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 42 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Саранчулуун;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, М.Нарантуяа-Нара, Д.Үүрийнтуяа.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, мөн яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Нарангарав, Цалин хөлсний бодлого, төлөвлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хариуцсан ахлах шинжээч Ш.Гэрэлцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Асуултын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Ганхүлэг, Ц.Идэрбат, Х.Булгантуяа, Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Уг асуудлыг 16 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, мөн газрын ахлах референт Д.Отгон, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Х.Тамир, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн, Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Мөнгөнтуул, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга Р.Гантуяа, мөн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, Хуулийн хэлтсийн дарга Б.Одгэрэл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Н.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын референт Б.Энхмаа нар байлцав.

Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Чинбүрэн, Л.Энх-Амгалан, Б.Бейсен, М.Ганхүлэг, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Х.Мөнхзул, мөн Комиссын Хүний эрхийн боловсрол хариуцсан ахлах референт Э.Мөнхзул, Төсөл хөтөлбөр, дотоод хамтын ажиллагаа хариуцсан референт Л.Мөнхтулга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга Р.Гантуяа, мөн газрын шинжээч Б.Пүрэвжав, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Одгэрэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Г.Анхболд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Ж.Отгонбаатар, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчний хэлтсийн дарга Б.Оролзодмаа, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн захирал М.Отгонгэрэл, мөн төвийн дэргэдэх Хүүхдийн түр хамгаалах байрны дарга Б.Отгонцэцэг, Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн Д.Энхжаргал, Э.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Б.Бейсен, М.Ганхүлэг, Х.Булгантуяа, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Х.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар, Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн Д.Энхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 18 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 13 минут үргэлжилж, 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 14 цаг 43 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулъя аа.

Аюушийн Ариунзаяа гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн, 3 дугаар тойрог Буланы Бейсен гишүүн, 10 дугаар тойрог Хөхөөгийн Болормаа гишүүн, 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн 6 дугаар тойрог, Сархадын Зулпхар гишүүн 6 дугаар тойрог, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, 8 дугаар тойрог Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нар ирсэн байна аа.

Өнөөдрийн хуралд Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн чөлөө авсан байна. Мөн 4 дүгээр тойргийн Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн чөлөөтэй байна аа. Мөн Отгоны Саранчулуун гишүүн гадаадад томилолттой байна аа. Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 61.9 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэх.

Хоёрдугаарт, Хууль тогтоолоор үүрэг чиглэл болсон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан сонсох.

Гуравдугаарт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлийг сонсоно. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Саналтай гишүүд байхгүй учраас асуудал руугаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгэм, хамгааллын сайдад хандан

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцье ээ. Ажлын хэсгийг танилцуулъя. Энх-Амгалан сайд Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Тамир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Нарангарав Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харьцаа цалин хөлсний хэлтсийн дарга, Гэрэлцэцэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Цалин хөлсний бодлого төлөвлөлт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хариуцсан ахлах шинжээч, Батжаргал НДЕГ-ын дарга, Буянжаргал МҮЭХ-ны ЕНБД. Зарим нь ирээгүй хүмүүсээ дуудаарай сайд аа.

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Энх-Амгалан танилцуулга хийнэ ээ.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар ирүүлсэн 3 асуулт ирүүлсэн. Энэ 3 асуултын хариултыг бид бэлдсэн байгаа.

Асуулт 1.

Үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн 660 мянган төгрөг байхаар тогтоосон байхад, 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 жилд нэг удаа тогтоох 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан хугацааг зөрчсөн эсэх талаар.

Бид нэг ийм хариулт бэлдлээ. Цалингийн түвшин хамгийн доогуур буюу бага орлоготой иргэдийг хамгаалах гол бодлогын нэг хэрэгсэл нь бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох явдал байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн орны 91 орчим хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өнөөдөр тогтоож байна. 91 орчим хувь нь. Өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг улс орнуудаар авч үзэхэд Австрали нэг цагт 18 Америк доллар, Шинэ Зеланд нэг цагт 16 доллар, Англи, Люксембург, Герман, Аргентин зэрэг улсуудад нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэлээн өндөр байдаг. Азийн хөгжиж буй улс орнуудын хувьд нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг авч үзэхэд Филиппин нэг доллар 64 цент, Индонез нэг доллар 18 цент зэрэг улсуудад нэг доллароос дээш байгаа бол Бангладеш, Киргизстан, Тажикстан зэрэг улсуудад нэг доллароос бага байна аа.

Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг цагт 3929 төгрөг буюу нэг доллар 10 цент байсан бол сая 4 сарын 1-ээс энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бид нар нэмснээр 2025 оны 4 сарын 1-ээс хойш хөдөлмөрийн хөлсний нэг цагийн хөдөлмөрийн хөлсний хэмжээ өнөөдөр 4715 төгрөг буюу 1.3 доллар болж өссөн байна аа. Энийг би яагаад дахин дахин ингэж хэлээд байгаа юм бэ гэхээр ер нь бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэг цагийн хөлсийг тооцож олгож байгаа. Яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цагийн ажил хийж байгаа маш их олон хүмүүс байдаг. Тэр тусмаа манай энэ оюутан залуучууд байна.

Өнөөдрийн бид нарт байгаа мэдээллээр авсан мэдээллээр бол нийт 134 мянган хүн бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлдөг. 176 мянган албан журмынхан буюу ажил хийгээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж байгаа 176 мянган иргэд байна. Энэ бол нөгөө нийгмийн даатгалд шинэ шимтгэл төлж байгаа 1.2 сая иргэдтэй харьцуулахад бол 25 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байна аа. Энэний цаана яг юу байна вэ гэхээр ер нь яагаад энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бид нар нэмэгдүүлэх ёстой юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Мэдээж ер нь манай улс бол яг өнөөдрийн энэ хөдөлмөрийн хомсдолын хөдөлмөрийн зах зээлийн хомсдолын гол асуудал бол энэ хөдөлмөрийн бүтээмж хөдөлмөрийн үнэлгээний асуудал байгаад байгаа. Нэг талдаа хөдөлмөрийн зах зээл дээр өнөөдөр 40-өөс 5 мянган ажлын байр бодитой ажлын байр байна. Гэтэл нөгөө талдаа 70-аас 80 мянган ажилгүйчүүд байгаад байдаг нэг ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад бид нар ер нь нэг Монгол хүний нэг цагийн хөдөлмөрийн бүтээмж нэг цагийн хөдөлмөрийн бүтээмж дээр үндэслэсэн энэ цалин хөлсний тогтолцоогоо бид нар нэг эргэж харахгүй бол энэ цаг үеийн шаардлага ерөөсөө хангахаа больсон байна гэж харж байгаа юм. Ер нь хамгийн бага цалинтай гэж ойлгож болно. Тэгэхээр яах вэ Ариунзаяа сайд маань өөрөө энэ салбарын сайд байсан учраас өөрийнх нь асуулт мэргэжлийн сайдын асуулт.

Тэгэхээр ерөнхийдөө бол миний өгөх гэж байгаа хариулт бол Ариунзаяа сайдын асууж байгаа асуулт дээр яг хууль зөрччихсөн үү гэхээр зөрчөөгүй. Яг ингээд яг одоо байгаа хуулийн зохицуулалтаар явах ёстой шүү дээ гэвэл яг тийм болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ өнөөдрийн нөгөө Хөдөлмөрийн тухай хууль манай Ариунзаяа сайд байхдаа өөрөө сайд байхдаа батлуулсан энэ Хөдөлмөрийн тухай хууль. Ингээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулах тусдаа хуультай. Тэгэхээр энэ 2 хууль маань хоорондоо хоорондын энэ уялдааг хангах ийм зайлшгүй цаг хугацааны ийм нөхцөл байдал үүссэн байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр Хөдөлмөрийн тухай хууль маань шинэчлэгдээд батлагдчихсан. Энийгээ дагаад бид нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх энэ асуудлуудыг зохицуулдаг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиа зайлшгүй өөрчлөх ёстой. Би Ариунзаяа сайдын өнөөдрийн энэ асуулт тавьж байгаа хандлага өнцөг чиг бол ерөөсөө энэ хөдөлмөрийн хөлснийхөө доод хэмжээний хуульд л цөмөөрөө өөрчлөлт оруулах ёстой юм байна л гэж манай Ариунзаяа сайд маань ийм асуултыг логиктой тавьж байна л гэж би хараад байгаа шүү дээ тиймээ. Тэгэхээр энийгээ хамтдаа ингээд өөрчилъе өө. Яах вэ би ингээд энэ юуны хууль зөрччихсэн, зөрчөөд нэмчихсэн гээд одоо тэр талаасаа хариулт өгөхөөсөө илүү зөрчөөгүй юм бас ингээд энэ хууль үнэхээр зөрчөөгүй юм шүү гэдэг нэг жаахан тайлбар бас хэлчихье гэж бодож байна.

Яагаад гэвэл Монгол Улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх тухай асуудлыг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиар зохицуулж байгаа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооноос 2 жилд нэг удаа тогтоохоор заачихсан байгаа. 2 жилд нэг удаа. Энэ хуулийн 5.4-д заасны дагуу Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны төлөөлөл бүхий аль нэг тал эс үгүй бол талууд

хамтран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх саналыг гаргаж болох бөгөөд уг саналын дагуу 2 жилээс бага хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож болно гэж ойлгож болно бид нар. Түүнчлэн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт 2023-аас 2025 оны Улсын хэлэлцээрийн цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого үйл ажиллагаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоох гэж мөн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны 2023 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох 12 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 5 сарын 1-ний дотор шинэчлэн тогтооно гэж тус тус энэ хорооны шийдвэр гарсан, шийдвэрлэгдсэн.

Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны төлөөлөл буюу МҮЭХ-ноос хэрэглээний үнийн өсөлт, хүн амын амьжиргааны доод түвшин зэрэгтэй уялдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний дундаж доод хэмжээг дундаж цалингийн 50 хувьд хүрэх буюу 1 сая төгрөгт хүргэх ёстой.

Дээр дурдсан тогтоол улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллаач гэдэг шаардлагыг удаа дараа энэ 3 талт энэ хэлэлцээрийн үеэр илэрхийлсэн. Олон удаа бичгээр илэрхийлсэн. Олон удаа хурал дээр энэ саналыг илэрхийлсэн. Ингээд дээрх саналыг судалж үзээд улсын хэлэлцээр болон тогтоолд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлаар тооцоолол хийгээд санал боловсруулаад 3 талын хамтарсан ажлын хэсэг бас энэ дээр ингээд сууж ажилласан юм байгаа юм. Тус ажлын хэсгээс танилцуулсан холбогдох хүчин зүйлс болон талуудын саналуудыг харгалзан Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны 2024 оны 10 сарын 7-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3929 төгрөг буюу сард 660 мянган төгрөг байсныг 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлж өнөөдөр Монгол Улсад нэг цагийн хөдөлмөрийн хөлс 4715 төгрөг буюу сард 792 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоогоод энэ маань мөрдөгдөөд явж байна аа.

Тэгээд энэ дээр бас би энийг тогтоохын өмнө манай Ариунзаяа сайд чинь Улсын Их Хурлын чуулган дээр хэд удаа байр сууриа илэрхийлж байсан. Төсвийн үеэр бас байр сууриа илэрхийлж байсан. Ингээд энэ ер нь яг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмснээр хэн хожих вэ гэдэг асуудал хэн хожих вэ? Монгол Улсад хэн хохирох вэ? Хэн дээр ачаалал ирэх вэ гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэхэд бол олон мянган хүн өнөөдөр маш том боломжууд өрхийн орлогууд нэмэгдэх, цалин хөлснүүд нь нэмэгдэж байгаа ийм мэдээллүүд бид нарт байна аа. Нөгөө талаасаа инфляцад одоо энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэхэд нөлөөлөх үү гэдэг асуултуудыг асууж байсан. Ерөнхий сайд ч гэсэн хэд хэдэн удаа бас энэ Засгийн газар дээр энэ асуудлуудаар мэргэжлийн байгууллагуудын байр суурийг сонс гэж байсан. Ингээд Үндэсний статистикийн хороо Монголбанкнаас бид нар, Ариунзаяа гишүүн ээ бид нар дүгнэлтүүд авсан. ҮСХ-ны мэдээллээр болон Монголбанкны мэдээллээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт сарын инфляцад 0.002 нэгж хүртэл хувиар нөлөө үзүүлнэ. Энэ тийм инфляцад нөлөөлөх нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлтийг бид нарт өгсөн. Ийм нөхцөл байдлуудыг бид нар харгалзаж Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдөх юм бол одоо бас тодорхой хэмжээнд зөрчил үүсэж байна гэж

харагдаж байна шүү дээ. Зөрчилдөх юм бол ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэхээр тусгасан байгаа.

Тийм учраас энэ удаагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 сарын 1-ээс нэмэгдүүлсэн энэ 3 талт хорооны тогтоол бол Монгол ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон энэ зохицуулалтыг хийсэн ийм тогтоол болсон гэдгийг би хэлье гэж бодож байна. Энэ дээр ингээд манай Булгантуяа сайд маань 3 сайд, дараалж 3 сайд нэгэндээ ажлаа өгч нэг нь ажлаа хүлээж авсан 3 сайд сууж байна. Яг одоо ингээд энэ сүүлийн 3 жилийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны тогтоолыг бид 3-ын гарын үсэг зурсан Булгантуяа, Ариунзаяа сайдын миний зурсан. Энэ ингээд Булгантуяа сайдын буюу Монголын Засгийн газар үүрэг хүлээсэн энэ тогтоол байна манай тогтоол. Энэнийхээ дагуу бид нар нэгэнт Монгол Монгол Улсын Засгийн газар одоо энэ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талтын Үндэсний хороогоор үүрэг хүлээсэн учраас энэ хүрээндээ бид нар нэмсэн байгаа гэдгийг ойлгож байна. Энэ дээр бол их олон 100 мянган ажилтнууд маань нэлээн талархаж хүлээж авч байгаа гэдгийг хэлье.

Хоёр дахь асуулт.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр нэмэгдүүлснээр цалин хөлсөд уялдуулах эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал улсын төсөвт үзүүлэх ачааллын талаарх тооцоолол мэдээллийг та бүхэн хийсэн үү гэдэг асуудал.

Хариулт. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тооцсоноор аж ахуйн нэгж байгууллага д ажиллаж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин хөлс авдаг ажилтны цалин хөлс нэмэгдэх зарим төрлийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх эерэг үр дагавар дагуулсан. Тухайлбал хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж авч байгаа 47500 мянган хүний тэтгэмж 93 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Жирэмсний амаржсаны тэтгэмж авч байгаа 29500 мянган хүний тэтгэмж 167 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 16600 хүний ажилгүйдлийн тэтгэмж 182 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж байгаа юм. Сая энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээр.

Нөгөө талаас сайн дурын даатгуулагчийн шимтгэл төлөлт ажил олгогчдын цалингийн зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ ээ. Энэ ойлгомжтой. Тухайлбал нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөд дараах нөлөө үзүүлэхээр байна. Улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх 81400 мянган даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл 4.7 төгрөгөөр нэмж төлөгдөнө. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.17, 21.2, 21.22. 21.23 дахь заалтад заасан цаа буга маллан тайгад амьдарч амьдарч байгаа цаатан, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил эрхлээгүй, эсхүл эцгийн шимтгэлийг бүрэн хэмжээгээр 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, малчин, туслах малчны төлөх шимтгэлийн шимтгэлийн 50 хувийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс төлөхөөр заасан байдаг. Нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөх 18900 даатгуулагчдын Нийгмийн даатгалын шимтгэл 2 тэрбум төгрөгөөр нэмж төлөгдөхөөр байгаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн холбогдох заалтуудад заасан Хөдөлмөр эрхлээгүй, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс

шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагчийн шимтгэлийг бүрэн, 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн шимтгэлийн 50 хувийг нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөхөөр ийм зохицуулалттай.

Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 129 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ. 129 тэрбум төгрөгөөр. Үүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалинтай даатгуулагч болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс дээгүүр цалинтай нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон ажил олгогч сар бүр төлж буй 295 мянган даатгуулагчдын шимтгэлийн орлого бол 101 тэрбумаар нэмэгдэнэ. Түүнчлэн сайн дураараа даатгуулсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцсон Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 134 мянган даатгуулагчийн шимтгэл 28.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна аа.

Нийгмийн даатгалын сангийн орлого нь 120 хэдэн тэрбум төгрөгөөр нэмэгдээд, зарлага нь бол 38.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Үүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээ авдаг 1498 тэтгэвэр авагчийн тэтгэврийн доод хэмжээ 66 мянгаас 132 мянга болж нэмэгдэж байгаа. Энэ дээр 2.5 тэрбум төгрөгийн зардал гарна. Нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны болон жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн даатгал нь нийт 36 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-18 насны 3 болон түүнээс дээш өрх толгойлсон эцэг, эхэд улирал бүр тэтгэмж олгохоор заасан байдаг. Энэ тэтгэмжид 2024 оны 12 дугаар сарын байдлаар 8812 иргэн хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 20 орчим тэрбум төгрөгийг олгосон байн.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 сарын 1-ээс 792 мянган төгрөг болгосноор 3.5 тэрбум төгрөг нэмж шаардагдана. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр холбогдох зардлын өөрчлөлтийн мэдээллийг Сангийн яаманд бид нар тухай бүр хүргүүлж байсан. Манай Ариунзаяа сайд маань Улсын Их Хурлын чуулган дээр Сангийн сайд Жавхлангаас яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулж төрөөс ЭМД-ын шимтгэлүүдийг нь төлдөг. Энэ чинь 4 юу байгаа шүү дээ. 4 зохицуулалтууд байгаа. Энэн дээр 2026 оны улсын төсөв дээр энэ эх үүсвэр суусан хувьд гэдэг асуултуудыг асууж байсан 2025 оны. Энэ дээр холбогдох миний бие андуураагүй бол Эрүүл мэндийн даатгал бусад даатгалуудтай холбогдуулаад нийт 47 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрүүдийг бид нар энэ урсгал зардал дээр суулгасан гэдэг мэдээллийг Сангийн сайд Жавхлан удаа дараа өгч байсан гэдгийг би энд онцолж хэлье гэж бодож байна аа.

Асуулт 3.

Хөдөлмөрийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөх хэчнээн аж ахуйн нэгж байгууллага байгаагаас хэд нь тус төлбөрийг төлж байгаа мөн гадаадаас ажиллах хүч авч байгаа ААН-д үзүүлж байгаа нөлөөлөл зэргээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр үүсэх нөлөөллийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл тооцоо судалгааг ирүүлээч гэсэн байна аа.

Хариулт.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-т өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна гэж заасан байгаа.

Мөн хуулийн 144.3-д аж ахуйн нэгж байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих орон тоо тутамд ноогдох хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө өө гэж заасан. Уг хуулийн заалтын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2024 онд 4346 хүний 7.1 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Энэ их чухал тоо шүү тийм ээ? Ингээд л хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэд ажиллуулаагүй бол аж ахуйн нэгжүүд маань ингээд ийм юу төлдөг, төлбөр төлдөг. Энэ төлбөр нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан байдаг учраас бол энэ ийм тодорхой эерэг хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих санд буюу яг нөгөө ядарсан зүдэрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маань хөдөлмөр эрхлэх 7.1 тэрбумын шинэ боломжууд гарч ирсэн байна гэж ойлгож болно. 2024 онд тус санд төлбөр төлсөн хүний тоогоор бодоход 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээр сард ойролцоогоор 1.1 тэрбум төгрөг нэмж төлөгдөнө. Энэ 1.1 тэрбум юу болох вэ гэхээр нөгөө л хөгжлийн бэрхшээлтэй байгаа мөртөө хөдөлмөрлөх боломжуудтай байгаа нөгөө 90-ээд мянган иргэдэд дахиад 1 тэрбум төгрөгийн боломж ажлын байр нэмэгдэх боломж энүүгээр нэмэгдэж байна л гэж ойлгож болно. Ийм маягаар сайн хэрэг талууд байна.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах аж ахуйн нэгж байгууллага нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.1-д заасны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн 1 сарын хэмжээ нь нэг сард ноогдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнд тэнцэх хэмжээтэй байна гэж заасан байгаа. Энэ аж ахуйн нэгж байгууллага нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасны дагуу дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагддаг ийм зохицуулалттай.

Тэгэхээр энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-д заасан гадаад ажилтан боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш дасгалжуулагч авч ажиллуулах, ажил олгогчдыг ажлын байрнаас чөлөөлнө гэсэн. Энэний дагуу чөлөөлөлтүүд явагддаг.

Хоёрт нь Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэл, шинэ хотын бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газрын ажлын байрнаас төлбөрөөс чөлөөлж хөнгөлдөг ийм байгаа. Энэ дээр ирсэн та бүгдэд өгсөн мэдээллээр бол бид нар нийт 2024 онд бол гадаад ажилтан авсан нийт байгууллагын тоо 5733, Монгол Улсад орж ирсэн гадаад ажилтны тоо 26480. Энэ нөгөө 280 мянгаар орж ирдэг хужаа орж ирдэг энэ тэр гэсэн ийм тоо байхгүй шүү. Ерөөсөө энийг далимдуулаад би нэг тайлбарыг хийчихье гэж бодож байна.

Монгол Улс руу орж ирж байгаа гадаадын ажилтнууд дээр хязгааргүй тоо гэж ерөөсөө байдаггүй, хязгааргүй тоо гэж ерөөсөө байдаггүй хязгаар байдаг. Энэ хязгаар бол нөгөө Монгол Улсад байгаа Монголын хүн амын 3 хувь, нэг улсаас нэг хувиас хэтрэхгүй гэсэн ийм хязгаартай байхгүй юу. Квотгүй хязгааргүй гэдэг ийм буруу ойлголт ерөөсөө байхгүй. Тийм учраас Монгол Улсад жилээс 30-аас 40 мянгаас дээш гадаадын нэг ч ширхэг ажилтан орж ирдэггүй ийм хуультай. Яагаад энийг гуйвуулаад тэр квотгүй гэдэг ойлголт.

Л.Энхнасан: Сайд дуусгаж хариулна уу цагийг нь нэмье.

Л.Энх-Амгалан: Яагаад тэр квотгүй гэдэг ойлголтуудыг гарч ирнэ. Квотгүй гэдэг ойлголт бол квот дотроо байгаа тухайн салбарууд дээр зарим салбаруудын квотуудыг нэм. Квот дотроо байгаа салбаруудыг хөдөлгөдөг нэмдэг ийм зохицуулалттай байгаа юм аа. Ийм тайлбаруудыг би энэ далимд өгчихье гэж бодож байна аа. Ингээд ер нь эцэст нь дүгнээд энэ 3 асуултуудын юугаас ингээд 3 асуултуудыг яахад бол би түрүүн онцолж хэлсэн байна.

Ариунзаяа сайд маань бол өнөөдөр ингээд хийдэл гараад байгаа энэ 3 талтын хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой эрх зүйн зохицуулалтууд, шинэ эрх зүйн зохицуулалтууд 1 дүгээрт хэрэгтэй юм байна. Одоо энэ дээр ингээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулах тухай хууль дээрээ өөрчлөлт оруулах шаардлага байгаа юм байна гэж олж хараад энэ өөрчлөлтүүдийг хийх гэж байгаа юм байна гэж харж байгаа. Ер нь бол Монгол Улсад энэ цалин хөлсний бодлогоо бид нар эргэж харах ийм зайлшгүй шаардлага үүссэн. Өнөөдөр нөгөө ДНБ-д эзэлж байгаа энэ бодит цалингийн зардал бол манай улс хамгийн бага явдаг, хамгийн бага явдаг. Дөнгөж 31, 32 хувь хүрэхгүй хэмжээнд байна. Бусад улсуудын ДНБ-д үзүүлдэг бодит цалингийн энэ зардал бол даруй 40-өөс 60 хувьд хүрчихсэн байж байгаа.

Өнөөдөр яагаад ер нь энэ Монголчууд Солонгосыг зориод байгаа юм, Австралиудыг зориод байгаа юм гэдэг асуудлуудын хариулт нь ер нь явж явж энэ Монгол Улсад энэ Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж нэг цагийн үнэлэмжтэй холбоотой хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний зохицуулалттай зайлшгүй холбоотой ийм асуудлууд гарч ирж байгаа юм аа. Тэгээд энэ хүрээндээ цөмөөрөө ярилцаад эндээс тодорхой шийдэл гаргаад явах нь зүйтэй болов уу гэсэн бас ийм хүлээлттэй байгаа гэдгийг салбарын сайдын хувьд хэлье ээ. Тэгээд энэ хариултуудыг өгье.

Л.Энхнасан: Баярлалаа.

Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуульд гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ гэсний дагуу өнөөдрийн Байнгын хороогоор Ариунзаяагийн асуултыг хэлэлцүүлж байгаа. Мөн Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл нэг минут илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж тайлбар аваад мөн дахиад нэг минутаас илүүгүй байх ёстой.

Тэгэхээр асуултын хариутай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

А.Ариунзаяа: Түрүүлээд ирчихлээр дахиад л нөгөө 1 дүгээрт асуулт асуух болчихоод байдаг. Уг нь жоохон сонсож байгаад асуулт асуучихвал илүү улс төр хийх боломжтой юм даа сайд аа. Хажууд суучхаад миний ах сайд маань тэгээд манай Ариунзаяа чинь ингэсэн юм, тэгсэн юм гэхлээр нэг жоохон зөөлрөх маяг орчихоод болдоггүй. Тийм 3 сайд суучихлаар.

Тэгээд 1 талын бол үнэн л дээ. Би яагаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар асуулт тавьсан бэ гэхлээр мэдэхгүй биш мэдэж байгаа. Тэгээд ер нь энэ бодлогын талаар олон нийтийн анхаарлыг оруулж мөн дээрээс нь энэ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг өөрчлөхгүй бол болохгүй нь ээ маш их сөрөг үр дагаврууд олон байна шүү гэдгийг хэлэх гэж энэхүү асуултыг тавьсан. Уг нь чуулганаар сонсчихъё гэсэн чуулганаар асуулт биш асуулгын л хариултыг сонсдог юм байна. Болохгүй бол дараад нь асуулга тавьдаг юм уу даа гэж бодож байна. Сайдаа энэ би яах вэ нөгөө төсөв ярьж байхад та хэд бол төсвийн төсөл өргөн барьсан хойно энэ шийдвэр чинь орж ирсэн учраас төсөв дээр бол ороогүй. Гагцхүү Сангийн яамны зүгээс бол нөгөө сангуудын ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сангийн орлого тал дээр нь төсвийн татаас тал дээр нь ахиу тавьчихсан байгаа учраас энэ төрөөс даах энэ орлого дээр бол асуудал үүсэхгүй гэж Жавхлан сайд хариулсан.

Гэхдээ энийг бол яг Байнгын хороон дээр ч яриагүй, төсөв дээр ч яриагүй, манай бүлэг дээр ярьсан асуудал. Тэгээд би гол нь юун дээр болгоомжлоод байна вэ гэхлээр та хэд маань яах вэ орлого тал чинь гайгүй болдог санж. Зарлага тал чинь нэмэгдэхээр төлөвлөгдөөгүй, төсөвлөгдөөгүй зардал тал чинь гарч ирнэ. Тэгээд эрсдэлтэй шүү эрсдэлтэй шүү. Энийгээ анхаарч зөв талаас нь ярьж дараа төсвийн тодотгол орох юм бол энэ дээрээ бас хангалттай төсвөө тавихгүй бол та хэд одоо хүнд нөхцөл байдалд байхад чинь хүндрэл улам л даамжирна гэсэн үг. Тэгээд энэ тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ нэмэгдэнэ гээд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч байгаа 47.5 мянган хүний тэтгэмжийн хэмжээ 93 мянган төгрөгөөр жирэмсний, амаржсаны тэтгэмж авч байгаа 29.5 мянган хүний тэтгэмж 167 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 18.6 мянган хүний тэтгэмж 182 мянган төгрөгөөр нэмэгдэнэ гэж ярьж байна. Яг одоо тэтгэмж авч байгаа хүмүүсийн сарын тэтгэмж нэмэгдэж байгаа юм уу? Энэ чинь өөрөө эргээд ямар буруу ойлголт өгчхөөд байна вэ гэхээр тэтгэвэр тэтгэмж дагаж нэмэгддэг юм шиг ийм ойлголтыг өгчхөөд байгаа байхгүй юу.

Уг нь бол та хэдийн энэ бичиж байгаа тайлбар чинь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн дүнгээрээ төлж байгаа юм бол тэр дүнгээсээ дараад нь алсдаа нэмэгдэж түүгээрээ нэмэгдэж тооцогдоно гэдэг л тогтолцоо л доо. Тэгээд одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэмж авч байгаа хүмүүс байгаа бол тэр нь нэмэгдэнэ гэсэн л ийм агуулга. Тэгэхгүй бол нийт иргэдийн тэтгэмж яг өнөөдөртөө нэмэгдэх юм шиг ийм ойлголтыг өгөх чинь өөрөө эргээд галтай буруу шүү. Эргээд та нар нэмэгдэнэ гэсэн яасан бэ минийх нэмэгдээгүй байна нэмэгдүүлээч гэдэг ийм шаардлага чинь ирнэ шүү дээ. Энийгээ яаж тооцсон юм тайлбарлаад өг.

Л.Энхнасан: Сайд хариулах уу? Ажлын хэсгээс хариулах уу? Батжаргал дарга 6 дугаар микрофоныг өгнө үү? Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Б.Батжаргал: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэмэгдэлтэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зарлага тал дээр буюу богино хугацааны эрсдэл болох тэтгэмжүүдийг тооцоолол хийхдээ бид нар программ дээр тооцоолол хийгээд 2025 оны 4 сарын 1-ний өдрөөс хойшоо эрсдэлд ороод хүсэлтээ гаргах магадлалтай тооцоо, хүнийхээ тоог гаргаад тэгээд дундаж цалингийнхаа хэмжээг оруулаад ингээд тооцсон байгаа. Тэгээд завсрын үе гарна. Энэ дунджаар 660-тай хэсэг сарыг нь тооцно. 792-той хэсэг сарыг нь тооцно.

Тэгээд хамгийн эхлээд 7 сараас эхлээд хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмж нь бүрэн 792 мянгаар тооцогдохоор ингээд дундын завсрын болон бүрэн бодолттой ийм хувилбараар тооцож энэ гаргасан зардлын тооцоолол байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Болсон уу тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Харин тийм. Би наадхыг чинь мэдээд байгаа байхгүй юу Батжаргал дарга аа. Тийм учраас болгоомжтой байгаарай. Та нар яг одоо тэтгэвэр тэтгэмж авч байгаа хүмүүсийн сарын тэтгэмж 4 сарын 1-ээс нэмэгдэх юм шиг ийм ойлголтыг өгчхөөд байгаа байхгүй юу. Гэтэл үгүй шүү дээ. 792-оосоо тооцож шимтгэл төлж байгаа бол алсдаа тэр хүмүүс тэтгэвэр, тэтгэмж авах юм бол буюу саяын нөгөө тооцооллоор эрсдэлд оруул гэж байна шүү дээ тиймээ. Тэр үед нь тооцогдох мөнгө нь нэмэгдэнэ гэж ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр маш болгоомжтой энийгээ зөв илэрхийлээрэй гэж хүсэж байна. Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмснээр шууд тэтгэвэр тэтгэмж яг өнөөдрийн тэтгэвэр тэтгэмж нэмэгддэг энэ ойлголт байхгүй шүү дээ. Байхгүй тийм биз дээ.

Маргаашийн буюу өнөөдөр бодогдож байгаа тэр цалин нэмэгдэж байгаа бол тэрнээсээ алсдаа бодогдох тэр тэтгэвэр тэтгэмж нь л нэмэгдэх болохоос биш яг өнөөдрийн олголт дээр ямар ч нөлөө байхгүй байхгүй юу. Тийм учраас өнөөдөр ахмадууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмсэн юм чинь миний тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ёстой гэдэг ийм юмыг яриад байна шүү дээ.

Л.Энхнасан: Сайд хариулна уу?

Л.Энх-Амгалан: Тийм Ариунзаяа сайд салбарын сайд угаасаа энэ бүх ньюансуудыг сайн мэдэж байгаа. Тэгээд зөв л дөө. Өөрийнх нь болгоомжлол нь Ариунзаяа сайдын угаасаа энэ болгоомжлол их зөв. Бид нар энийг хүлээж авах ёстой юм байгаа юм. Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдчихэнгүүт бүх хүмүүсийн цалин нэмэгдээд бүх хүмүүсийн авч байгаа тэтгэвэр тэтгэмж нэмэгдэнэ гэдэг энэ тийм ойлголт хэзээ ч байхгүй. Угаасаа тийм ч боломж ч үгүй. Тэгэхээр угаасаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг чинь яаж нэмэх ёстой юм, ямар аргачлалаар нэмэх ёстой юм гэдэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ер нь яг гашуун үнэнийг хэлэхэд бол өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн Монголд бараг байхгүй дээ. Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр шимтгэл төлж байгаа улсууд л байгаа, шимтгэл төлж байгаа. Ерөөсөө ингээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шимтгэл төлдөг нэг ийм хэмжээ болгочихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар цаашдаа сая Ариунзаяа сайдын хэлээд байгаа энэ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульдаа зайлшгүй энэ цаг үеийнхээ шаардлага эрэлт хэрэгцээг оруулсан ийм өөрчлөлтүүд хийхээс өөр бид нарт өөр сонголт гарц ерөөсөө байхгүй.

Л.Энхнасан: Баярлалаа. Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу?

М.Ганхүлэг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой тодруулах 2, 3 асуулт байна аа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдолтой, олон улсын жишигт нийцүүлэхтэй холбогдолтой агуулга яах вэ явах нь зөв өө. Гэхдээ ер нь яах вэ эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг нь ингээд хараад үзэхээр бүртгэгдээгүй ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх инфляцад нөлөөлөх, орон нутгийн түвшинд Улаанбаатар болон төв суурин газраас илүү бодит байдал дээр жоохон хүндрэл илүү байх, ажилгүйдэл бий болох нэг шалтгаан болох, хамгийн гол нь ялангуяа хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын хувьд хамгийн бас хамгийн хохирол гэдэг юм уу сөрөг үр дагавар нь бол гардаг.

Ялангуяа улирлын чанартай ажлууд хийгдэж байгаа. Энэ хүмүүсийн хувьд ХАА-н салбарынхны хувьд нэг жоохон хүндрэл тулгардаг. Тэр утгаараа бол тодорхой үүн дээр гарах өөрчлөлт нөлөөллийг судалдаг, тооцдог, хариу арга хэмжээ авдаг энэ зүйлүүд нь ямар байдаг вэ. Энэ чиглэлийн зүйлүүд ямар байгаа вэ гэдэг эхний асуулт байгаа юм аа.

Хоёр дахь нь сая сайд хэллээ. Ер нь шимтгэлийн тодорхой авах дүн гэж үндсэндээ ашиглагдаад байна гэж. Тэгээд яг энэ агуулгын хүрээнд ер нь Батжаргал даргаас би гол голчлоод асууя. Хувиараа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ер нь иргэд хэчнээн байдаг юм бэ? Тэгээд сар болгон өөрсдийнхөө сайн дураар саналаараа төлөөд л байдаг, яг бодит байдал дээр энэ төлж байгаа иргэдийг дэмжих чиглэлийн тодорхой зээлд хамрагдах бусад чиглэлийн энэ боломжуудыг олгох чиглэл дээр бараг ашиглагдах ийм боломжгүй, визэнд байдаг юм уу бусад чиглэл дээр бас орох ийм боломжгүй ийм байдалтай л байдаг аа.

Тэгэхээр энэ чиглэлийн асуудлыг ер нь бид нар цаашдаа яах ёстой вэ гэдэг ийм 2 дахь асуулт байгаа.

Гурав дахь нь энэ оны 1 сарын 1-ээс Малчны тухай хууль хэрэгжиж эхэлж байгаа. Үүнтэй холбогдолтой тодорхой малчдыг дэмжих нэлээн олон заалтууд орсон. Түүний нэг нь бол орон нутагт ажиллаад ингээд явж байхад бол нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбогдолтой заалтыг маш тодорхой энэ хуулиар олгоно оо, нөхөн төлүүлнэ гэдэг ийм агуулга орсон байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр явц ямар байдалтай явж байна, энийг тусгах асуудлыг ирэх оны төсөв болон бусад чиглэлээр оруулах бололцоо судалгаа энэ саналууд яаж явж байгаа вэ гэдгийг албан ёсоор хэлэх нь зөв байна аа. Ийм асуулт байна.

Л.Энхнасан: Сайд хариулна уу?

Л.Энх-Амгалан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Ганхүлэг гишүүн ээ яг одоо Монгол Улсад бол яг нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сайн дурынхаа даатгалыг төлж байгаа 134 мянган иргэд байна. 134 мянган иргэд энэ илүү дандаа нөгөө манай малчид хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа зах дээр худалдаа үйлчилгээ хийж байгаа ийм иргэд ерөнхийдөө байгаад байгаа юм. Жижиг аж ахуйн нэгжүүд ч гэсэн ерөнхийдөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөд яваад байгаа. Энэ тэгэхдээ их хортой шүү дээ. Ер нь бол нийгмийн даатгалын шимтгэлээ

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээрээ төлөөд байна гэдэг бол ирээдүйд бага тэтгэвэр авна л гэсэн үг. Өнөөдөр манай энэ иргэдийн дунд сая санал асуулга хийгээд бараг 100 мянган иргэд саналаа өгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулъя гэхээр 100 мянган иргэд дэмжиж байна гэсэн. Энэ их аюултай шүү дээ. Яг ер нь бол ажил олгогч нар бол аль болохоор юу гэдэг юм нөгөө алтыг нь аваад авдрыг нь хаяна гэдэг шиг залуу занд насанд нь ажил хөдөлмөрийг нь эрхлүүлчхээд чамайг ямар нэгэн байдлаар үйлдвэрлэлийн осолд эрсдэлд оронгуут чинь эс үгүй бол өтөл насанд чинь чиний тэр тэтгэвэр тэтгэмж надад хамаагүй шүү л гэсэн ийм харгис нь бодлого байхгүй юу.

Тийм учраас бид нар ер нь энэ нийгмийн даатгалын шимтгэлийнхээ энэ ойлголтыг, нийгмийн ойлголтуудыг ер нь бид нар их өөрчилмөөр юм байна аа. Сая нөгөө Ерөнхий сайд яриад нөгөө ашигт малтмалын АМНАТ-ийн татварыг ард иргэд ойлгодоггүй юм байна гэдэгтэй яг адилхан нийгмийн даатгалын шимтгэлийг ерөөсөө шимтгэл, хураамж, татвар гээд ойлгочихсон байгаа юм. Уг нь энэ чинь хуримтлал байхгүй юу ирээдүйдээ хийж байгаа тэр чинь хуримтлал. Тэгээд энэ чиглэлээр бид нар энэ ойлголтуудыг ер нь өөрчлөх ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа юм. Тэгээд 1 өдрийн хөлсөөр ХАА-н салбарт ажилладаг ямаагаа самная гэж байна аа. Өдөрт юу гэдэг юм 70-аас 80 мянган төгрөгөөр нэг ямаа өдрийн юугаар самнаад өгөөч, ногоогоо тарья 100 мянган төгрөг. Өнөөдөр Улаанбаатар хотод энэ барилгын ажил дээр өдөрт 100 мянган төгрөгөөр өгье, хүрч ирээд ажиллаад өгөөч гэхээр энэ чинь ирж ажиллаж байгаа хүмүүс ерөөсөө байхгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр бид нар нөгөө нэг цагийн ажлын хөлсийг Монгол хүний нэг цагийн ажлын хөлс уг нь энэ чинь нэмэгдэж байгаа байхгүй юу. Саяын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр энэ чинь нэг цагийн хөлс бол яг нэг цагаар тооцож нэг цагийн хөлсөөр олгодог байгууллагуудад нэг цагийн хөлс 3929 төгрөг байсан бол доллар 10 цент байсан бол саяын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмснээр Монгол хүний нэг цагийн хөдөлмөрийн хөлс хамгийн багадаа 4715 төгрөг болж нэмэгдэж байгаа. Ийм сайн юу гэдэг юм бодлого сайн жишиг юм байгаа гэдэг талаас нь бид нар харах ёстой.

Хоёр дахь асуултад хариулахад минут хүрэхгүй байна. 2 минут байна шүү дээ.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийн асуудал байгаад байгаа юм тийм ээ. Энийг би нэг сайхан дэлгэрэнгүй ер нь нэг хариулж өгье өө.

Л.Энхнасан: Сайдын энэ минутыг нэмье.

Л.Энх-Амгалан: Энэ дээр бид нар ер нь ойлголтуудаа нэг болгож авах ёстой гэж бодож байгаа юм. Би ч өөрөө хөдөөгөөс сонгогдсон гишүүн. Энэ дээр яг ямар асуудал үүсчхээд байгаа юм бэ гэж. Ямар асуудал. Энэ Малчны тухай хуулийг хэрэгжүүлэхэд. Ингэхээр ер нь өнгөрсөн хугацаанд бид нар энэ нийгмийн даатгалын одоо сан дээр маш их тийм ачааллууд үүсгэсэн улс төрийн үр дагавартай шийдвэрүүдийг гаргаж байсан. Бид нар 10 жилийг нөхөн тооцох тухай хуулийг баталж гаргасан. Эдийн засгийн өршөөл зарласан малчдын тэтгэврийн насыг 5 насаар наашлуулсан, олон хүүхэдтэй эхчүүдийн хүүхдийн тоогоор 1.5 жилээр үржүүлж одоо тэтгэвэрт гаргадаг тогтолцоонд шилжсэн гэх мэтчилэнгээр одоо энэ Улсын Их Хурлаас гаргасан энэ тогтоол шийдвэрүүдийн бүх ачааллууд өнөөдөр

нийгмийн даатгалын сан дээр ирээд ирээд нийгмийн даатгалын сан энэ хуулиудыг хэрэгжүүлэхэд өөрийн буюу нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн мөнгөөр энэ хуулиудыг хэрэгжүүлсэн.

Нэг ёсондоо бол шударгаар нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд явж байсан хуримтлал хийгээд явж байсан хүмүүсийн мөнгөөр нэг хэсэг улсуудад хөнгөлөлт өгсөн гэсэн үг байхгүй юу. Энэ бол 5.6 их наяд төгрөгийн бодитой ачааллыг нийгмийн даатгалын сан дээр үүрүүлсэн.

Уг нь шударга ёсоор юу байсан бэ гэхээр энэ хуулиуд Улсын Их Хурлын гишүүд хуулиа батлуулж болно. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг төсөв дээр суулгаж өгөх ёстой байсан юм байна лээ. Энийг 5.8 их наядын ачааллыг ингээд хүргүүлээд өгчихсөн. Малчид дээр яг юу болсон бэ гэж. Малчид дээр бид нар малчдын насыг 5 насаар наашлуулсан хууль батлуулсан. Олон мянган малчид маань алга ташсан. Олон улс төрчид маань дахиж сонгогдсон. Гэхдээ хамгийн харамсалтай нь өнөөдөр нийгмийн даатгалын сан дээр маш том ачааллыг үүсгэсэн. Энэ нийгмийн даатгалын сан гэдэг чинь НДШ төлөгчдийн хуримтлал шүү дээ. Тэгэхэд өнөөдөр малчдын тэтгэврийн насыг наашлуулсантай холбоотой энэ хуулийг хэрэгжүүлснээр одоо өнгөрсөн хугацаанд бид нар 68 тэрбум төгрөгийн ачааллыг бусдууд нь үүрээд явж байна. Малчдын нэрийн өмнөөс бусад шинэ шударгаар шимтгэл төлсөн хүмүүс үүрээд явж байна. 68 тэрбум төгрөг тиймээ. Одоо дахиад дээрээс нь энэ хуулийг дахиж хэрэгжүүлбэ дахиад Сунгая малчдад дахиад нөгөө ажиллаагүй төлөөгүй шимтгэлийг нь дахиж олгоё гэсэн хуулийг намайг хэрэгжүүл гэж шахаж байгаа байхгүй юу.

Би малчдадаа таалагдаж дахиж Улсын Их Хуралд сонгогдох улс төрийнхөө оноог харах юм бол би маш хурдан энэ хуулийг хэрэгжүүлнэ. Тэгэхдээ би дахиж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хийж байгаа тохиолдолд энэ хуулийг хэрэгжүүлэх надад ийм иргэний ёс зүй алга. Бусдын төлж байгаа шимтгэл, бусдын хуримтлуулсан шимтгэлээс нэг хэсэг улсуудад хөнгөлөлт хийдэг энэ гашуун бөгөөд энэ алдааг би дахиж үргэлжлүүлэхийг хүсмээргүй байна.

Тийм учраас би Улсын Их Хурлын гишүүдээсээ юу гэж хүсэж байна вэ гэхээр хууль хэрэгжүүлж болно. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд 38 тэрбум төгрөг жил бүхэн 38 тэрбум төгрөгийн эх үүсвэр хэрэгтэй байна Тэмүүлэн гишүүн ээ.

Тэмүүлэн гишүүн бол Улсын Их хурал дээр их тийм олон удаа дайрч байгаа. Олон удаа шүүмжилж байгаа. Би ч Тэмүүлэн гишүүнээсээ илүү малчдадаа хайртай. Надад жил бүхэн 38 тэрбум төгрөгийг улсын төсөв дээр тавьж өгөөч Ганхүлэг гишүүн ээ. Ингэсэн тохиолдолд.

Л.Энхнасан: Батжаргал дарга асуултад хариулах уу? 6 дугаар микрофон НДЕГ-ын дарга.

Б.Батжаргал: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя аа. 2024 оны жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгалд даатгуулсан хүний тоо 171332 байгаа. Үүнээс малчин хүний тоо 51502 гэсэн тоо байна. Малчдын хувьд 2023 онд Улсын Их Хурлаас баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу шимтгэлийн 50 хувиар улсын төсвөөс төлүүлж байгаа. Ингээд энэ 5 жилийн хугацаанд төлүүлэх ийм хуулийн зохицуулалттай байна аа. Сайн дураар даатгуулж байгаа иргэдийн зүгээс хамгийн их хүсэлт тавьдаг нэг зүйл нь бол нийгмийн даатгалын үндсэн

үйлчилгээнээс гадна банкны зээл авахад нотлох баримт болгож өгөөч гэсэн хүсэлт ирүүлдэг. Энэ асуудлаар НДЕГ-ын зүгээс арилжааны 13 банканд хүсэлт явуулсан. Энэ дээр бол харин Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журмаар энэ сайн дурын даатгалаар төлж байгаа орлогыг тухайн иргэний өр авлагын харьцаанд оруулахад боломжгүй гэсэн заалт байдаг юм байна. Тэгээд ийм учраас боломжгүй байна гэсэн хариуг банкнууд ирүүлж байгаа.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 6 дугаар микрофон.

Б.Батжаргал: НДЕГ-ын зүгээс яамаараа дамжуулаад энэхүү журамд өөрчлөлт оруулах тухай саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид уламжлахаар бид нар ажиллаж байна аа. Визний хувьд бол одоо бид нар Монгол Улсад суугаа ЭСЯ консулын газарт шууд хандах эрх бол Ерөнхий газарт байхгүй. Тэгээд яамаараа дамжуулаад энэ хүсэлтийг ер нь тавихаар ажиллаж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Ганхүлэг гишүүн тод тодруулна уу?

М.Ганхүлэг: Хөдөө аж ахуй болон ЖДҮ-лэлийн салбарынхны хувьд хөдөлмөр хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдолтой ямар эрсдэлүүд тулгарч болох вэ? Сая сайдын хувьд тэр ажиллах хүчинтэй холбогдолтой асуудлыг бас хэллээ. Улам л яах вэ цагийн хөлс нэмэгдээд ажиллах хүчнийг аваад ажиллахад яг хувийн хэвшил талаасаа газар тариалан туслах малчин авахад улам л хүндрэлтэй болох ийм эрсдэлүүд байна л даа. Мөн дээрээс нь ЖДҮ-лэл эрхэлж байгаа залуучууд шинээр эрхэлж байгаа хүмүүсийг л бид нар энэ тодорхой өөрчлөлтөөрөө ямар эрсдэл тулгарах вэ гэдэг дээр судалсан анхаарсан зүйлүүд нь юу байдаг юм бэ гэдэг ийм асуултууд байгаа юм.

Тэгээд энэ бол яагаад гэх юм бол энэ өөрчлөлтийн хамгийн их хүндээр тусаж байгаа хэсэг байгаад байгаа юм. Тэгэхээр тэр хэсгийг бол бид нар үл тоогоод энэ ер нь агуулгаараа зөв гэдэг байдлаар яваад байх нь зөв үү буруу юу гэдэг асуудал байгаа юм аа. Малчдын тухай асуудлыг бид нар дахиад сайн ярилцах ёстой. Аль болох болох талаас нь энэ хуулийг хэрэгжүүлэх талаас нь бид нар авч үзэх.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна аа.

Л.Энх-Амгалан: Ганхүлэг гишүүн ээ ер нь бид нарын энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх гээд байгаагийн оролдлого бол би бараг 2 жил тутамд нэг биш, бараг жилд 2-оос доошгүй байгаасай л гэж би бодож байгаа юм. Аль болохоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдээд байгаасай л гэж бодож байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдээд байхад Монгол хүний ажлын цалин хөлс нэмэгдэнэ. Мэдээж нөгөө талдаа бүтээмж гэдэг нэг асуудлыг бид нар хэзээ ч мартаж болохгүй. Бүтээмж мэдээж бүтээмжийг бий болгож байж цалин хөлс нэмэгдэх ёстой. Яг ингээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдчихээр ингээд ийм жижиг хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа улсууд жижиг аж ахуйн нэгжүүд энэ чинь хөлд нь чирэгдчих юм биш биз дээ гэдэг нэг ийм болгоомжлол бол байгаа. Тэрийг үгүйсгэхгүй.

Тэгэхдээ яг бодитой нөхцөл байдал дээр өнөөдөр яг одоо нэг сард сарын цалин 792 мянган төгрөгийн цалин авч байгаа хүн ер нь Монгол Улсад байна уу? Яг 792 мянган төгрөгийн цалин авч байгаа. Энэ чинь хуучин 600.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу?

Л.Энх-Амгалан: Тэгэхээр бид нар аль болохоор энэ Монгол хүний цалин хөлсийг энэ бүтээмжтэй нь уялдуулж л сар бүхэн, жил бүхэн ингээд нэмэгдээд яваад байгаасай л гэж бодоод байгаа шүү дээ тиймээ. Ер нь Монголчууд тэнэг биш л дээ. Яагаад энэ ажлын цаг өнөөдөр ингээд 1 ажлын цаг цагийн хөлс 4715 болчихоод байхад ирж ажиллахгүй байна. Нэг өдөр хүрч ирээд ямаа самначхаач 100 мянган төгрөг өгье өө гэхэд хүрч ирж ажиллахгүй байна гэдэг нэг их тийм тэнэгдээ, залхуудаа биш гэж ойлгоод байгаа шүү дээ. Нэг их тийм халамж ч хавтгайрчихсан байдалтай ч биш гэж ойлгоод байгаа. Энэ бол өнөөдөр Монгол хүн илүү их тийм бүтээмжтэй ажилладаг гэдэгтээ итгэлтэй. Энэнээсээ илүү их тийм цалин хөлс одоо Солонгост очоод хамгийн өндөр ур чадвартай, хамгийн өндөр цалинг өнөөдөр Монголчууд авч байна шүү дээ.

Өнөөдөр Австралид очсон Монголчууд тэр барилгын төмөр бетон тэр зангидалт дээр хамгийн өндөр цалинуудыг авдаг Монголчууд бий болчихоод байна шүү дээ. Тийм учраас Монгол хүн өөрөө ийм ур чадвартай учраас ур чадвар.

Л.Энхнасан: Баярлалаа. Ер нь сайдаа яамд нөгөө цалин хэчнээн хүмүүс ямар түвшний цалин авсан, ер нь авч байгаа гэсэн тийм сүүлийн тийм судалгаанууд байна уу?

Л.Энх-Амгалан: Статистикийн хорооноос гаргадаг дундаж цалингийн юу байгаа. Энэ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал гээд нөгөө юу гаргадаг судалгаа статистикийн судалгаа гаргадаг. Энэ дээр 2024 оны 4-д дүгээр улирлын байдлаар энэ дундаж цалин Монгол Улсад ямар ямар салбар дээр ямар ямар цалин авч байгаа гэдэг энэ мэдээллүүд ингээд гардаг.

Л.Энхнасан: Тэгээд таны хэлж байгаа яг тэр нөгөө 792-оос баг авч байгаа, цалин авч байгаа хүмүүсийн тоо ер нь хэд байгаа юм бол.

Л.Энх-Амгалан: Гэхдээ ямар азаар миний хажууд суусан нөгөө ийм салбар салбарын хариуцсан ээлжилж сайд хийж байсан улсуудын л юу шүү дээ. Одоо яах вэ яг ийм л байна л даа. 550 мянган төгрөг хүртэлх цалин авч байгаа хүмүүс гэхээр ингээд нийт 18 мянга гэсэн нэг тоо байна. Тэгэхдээ энэ бол яг энэ цалингийнхаа юмыг зөв бүртгээд байна уу гэдэг дээр бас жаахан эргэлзээ надад миний хувьд байгаа шүү.

Ер нь бол одоо ингээд нэг ийм зүгээр бодит амьдрал дээр эргэн тойрныхон гээд харахад бол ер нь сая төгрөгөөс доошоо цалин аваад байна гэсэн улсууд их л цөөн л байна гэж би хараад байгаа. Би бас тойргоос сонгочихсон гишүүн. Тойрог дээр очиж байн байн уулзалт хийдэг тэгээд энд ер нь Монгол хүний өрхийн орлого, дундаж орлого ч гэсэн ингээд нэмэгдэж байгаа. Энэнтэй уялдуулаад дундаж орлого.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн асуултаа асууна аа.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

3 асуулт л байгаа. Нэгдүгээрт энэ хэд хоногийн өмнө Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох ажил зохион байгуулагдсан. Тэгээд энэ хуулиараа ингээд 3 яам, ажил олгогч, үйлдвэрчний эвлэл гээд ингээд заагаад

өгчихсөн. Тэгээд энэний бүрэлдэхүүнд ахмадуудын төлөөллийг ер нь оруулах нь зүйтэй юм биш үү? Энэ сонсгол хийгдэж байгаа энэ зохион байгуулж байгаа энэ процессоос ингээд аваад үзэхэд би эндээс гараад ирсэн хүн эндээс би томилогдох ёстой гэсэн ийм нэг дүр зураг анзаарагдаад байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ квотоор орж ирж байгаа энэ квотынхоо асуудал дээр эргэж нэг хараад энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гарч байгаа шийдвэрийн гол бүлэг нь ахмадууд байгаа шүү дээ. Тэгээд уг нь ахмадынх нь төлөөлөл ороод энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлдөө ороод ажиллавал би бас шийдвэр их зөв тал руугаа жоохон амьдралтай ингэж гарах юм болов уу гэж ингэж харсан. Үйлдвэрчний эвлэлд нь ч байг, ажил олгогч нь ч байг Засгийн газрын төлөөлөл нь ч байг ингээд нэг тал талаасаа ийм.

Тэгэхээр энэ дээр ер нь яам ямархуу байр суурьтай байдаг юм бэ гэж 1 дүгээрт би асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт, энэ цалин хөлстэй холбоотой асуудал дээр яах вэ албан бусаар зохицуулалт яваад байгаа боловч уул нь жоохон хууль, эрх зүйн орчин нээгээд өгчих юм бол ялангуяа орон нутагт, хөдөө сум дээр, баг дээр ажлын байр гэж хэлэх нэмэгдэх нэг зүйл бол энэ гэрээт малчны асуудал байгаа юм аа. Одоо ямар зохицуулалтаар явж байна гэхээр ердөө аман зохицуулалтаар. Үүнээс болоод уг нь энэ ингээд нэг хууль, эрх зүйн зохицуулалтууд ороод ирэх юм бол олон залуучууд тэндээ мал маллаад цалин хөлс бүх юм нь хуулийн хүрээнд зохион байгуулагдаад ингээд явчих бүрэн дүүрэн бололцоо байгаа шүү. Одоо хэн нэгэн хүн сайхан ааштай үедээ аваад, жоохон саар ааштай үедээ чи яв гээд ингээд явуулчихаад байдгаас болоод эсвэл нөгөө нөхөр нь ажил сайн хийхгүйгээс болоод юм уу энэ нэг том хөдөлмөрийн зах зээл бас хаягдчих гээд байдаг юм аа.

Тэгэхээр энэ дээр нэг яах вэ Их Хурлын гишүүний хувьд хууль санаачлаад явж болох ч яам өөрөө энэ дээр ингээд санаачилга гаргаад энэ бүхэл бүтэн бүтэц байгаа. Энүүгээрээ судалгаа юмнуудаа хийгээд энэ ХАА-н салбар дээр тэр дундаа МАА-н салбар дээр энэ шинэ ажлын байр болох зүйлийг нь хийчихвэл.

Би аймгийн дарга байхдаа энэ гэрээт малчны асуудлаар зүгээр хөтөлбөр хэрэгжүүлээд нэг жил хэртэй явж байсан ковидын үед. Бас нааштай үр дүн дөнгөж гарч эхэлж байсан юм байгаа юм. Хаана хаана нь хэрэгцээ байдаг. Малаа маллуулах хэрэгцээ байдаг. Мал маллаад мөнгө олчих хэрэгцээ нөгөө талдаа байдаг юм аа.

Тэгэхээр энэн дээр ер нь яам ямархуу бодлого судалгаа юм ер нь хийсэн байдаг вэ гэсэн 2 дахь асуулт байгаа юм. Ингээд цаг дууссан учраас энэ 2 дээрээ аваад.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна уу?

Л.Энх-Амгалан: Тийм. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саяын тэр гишүүн сонгох юун дээр манай яам бол энэ зөвлөлийн гишүүн дээр энэ ахмадын холбооны тэтгэвэр авагчдын төлөөлөл буюу ахмадын холбооны төлөөллийг сонгож өгөөч гэдэг бид нар хүсэлтээ мэргэжлийнхээ Байнгын хороо Нийгмийн бодлогын байнгын хороон дээрээ ирүүлчихсэн. Тэгээд энэ сонгон шалгаруулалтыг угаасаа хуулиараа Нийгмийн бодлогын байнгын хороо хийдэг. Тиймээ ийм зохицуулалттай

байгаа. Хуучин бол Сүхбаатар гуай төлөөлж байсан. Энэ хүний хугацаа дууссан. Тэгээд оронд нь бид нар яг энэ ахмадуудын төлөөлөл болсон нэг хүнийг энэ Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллуулж өгөөч гэсэн хүсэлтээ ирүүлсэн. Энийг Байнгын хорооны дарга хариулах болов уу гэж бодож байна аа.

Хоёрт нь энэ хөдөлмөрийн тухай хуулиар бид нар энэ туслах малчинтай холбоотой энэ зохицуулалтуудыг их сайн зохицуулалтууд хийж өгсөн юм байгаа юм аа. Тэгээд одоо энийг бол бид нар бас энэ малчдад их сайн ойлгуулж өгмөөр байгаа юм. Ингээд энэ хөдөлмөрийн жишиг гэрээг нь хүртэл манай Ариунзаяа сайд байхдаа ийм жишиг гэрээ хийх ёстой шүү гэдэг гэрээг нь хүртэл гэрээний загваруудыг нь боловсруулаад ингээд өгсөн. Тэгээд яах вэ дээ одоо манайхан чинь нэг ийм нөгөө энэ чинь нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг төлөх ёстой гээд бас нэг хэдэн үүрэг хариуцлагууд байдаг. Тэгээд тэр үүрэг хариуцлагуудаа хэн хэн нь нэг жаахан ойшоодоггүй дундаа тохирчих гээд тэрнээсээ болоод эрх ашиг нь хөндөгдөөд байдаг нэг ийм асуудал байдаг.

Ер нь ингээд цаашдаа энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ нөгөө малжуулах хөтөлбөрүүд гэж байдаг шүү дээ тиймээ. Энэ малжуулах хөтөлбөртэйгөө уялдуулж бид нар ер нь энэ залуу малчид буюу туслах малчдыг яг энэ хөтөлбөртэй нь уялдуулж ингэж дэмжих ийм бодлого хэрэгжүүлэх ёстой юм байна гэж бодож байна. Тэгээд түрүүн малчдыг дэмжиж байгаа НДШ-тэй ч хүртэл малчдаас өөр ямар ч хүн өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөр даалгахгүй байгаа шүү дээ. Өнөөдөр бид нар малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн эхний 5 жилийнх нь 50 хувийг төр дааж явж байгаа шүү дээ.

Тийм тэгэхээр ийм уг нь эдийн засгийн хөшүүрэг бодлогууд ингээд хэлээд байдаг. Гэтэл яг үнэхээр манай малчид маань бол жаахан тийм юутай л баймаар байгаа юм л даа. Юу гэдэг юм, зарим үг хэлчихээр хатуудчих гээд байдаг учраас тийм жаахан бүтээмжтэй тэгээд 1 ийм хөдөлмөрөө зөв үнэлүүлсэн хөдөлмөрийнхөө харилцааг зөв зохицуулсан энэ харилцаанд л орох нь зүйтэй болов уу л гэж бодож байгаа шүү дээ. Одоо тэгээд мэдээж нөгөө энэ сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа цагаан алт хөтөлбөрүүд, ХАА-н салбарт хэрэгжиж байгаа хоршоог дэмжих энэ хөтөлбөрүүд хэрэгжих учраас бол хөдөө орон нутагт мал маллах, ХАА эрхлэх энэ ажилчдын хүсэл сонирхол бол нэлээн нэмэгдэж байгаа болов уу л гэсэн ийм хүлээлттэй байна.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн тодруулга хийнэ ээ.

Ц.Идэрбат: Миний 3 дахь ярих асуудал бол энэ бид ингээд хууль, эрх зүйн орчноо сурталчлах ажлыг бүүр маш сайн хийхгүй бол энд ингээд л яриад л байдаг, яриад л байдаг, тэнд байгаа суманд байгаа төрийн албан хаагчид яг тэрийг цааш нь хүргэж байна уу, үгүй юу гэдэг чинь өөрөө их чухал асуудал болчихоод байна л даа. Жишээ нь сая энэ залуу малчны асуудал байна. Сая өвөл бид нарыг тойргоор ажиллаж байхад тэр Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын тэр Зүрхэт багийн малчин Оюунзул гээд эмэгтэй би нийгмийн даатгалын шимтгэлээ гээд нэг хуваагаад төлж баймаар байна гэдэг юмыг ярьж байгаа юм. Гэтэл нөгөө хууль дээрээ энэ чинь уул нь эхний сарыг нь төлөөд ингээд гэрээ байгуулаад явах ёстой боломжтой байгаа шүү дээ.

Тэгэхээр би энэ дээр юу хэлэх гээд байна вэ гэвэл яах вэ бараг санал болчих юм болов уу. Тэр энэ гэрээт малчны асуудал, энэ залуу малчдын асуудал, энэ

малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 50 хувь хөнгөлж байгаа. Энэ чинь хугацаатай. Тиймээ хугацаа нь яваад байгаа. Дээрээс нь малчид сар болгон биш тодорхой хугацаанд гэрээ байгуулаад төлөх бололцоотой байгаа гээд.

Л.Энхнасан: Сайд хариулах уу? Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Идэрбат гишүүн бол маш чухал саналыг хэлж байгаа юм аа. Үнэхээр зовлонг нь мэддэг хүн хөдөө орон нутагт аймгийн Засаг даргаар ингээд ажиллаж байсан. Өөрөө ч их сайн жишиг сайн дэлгэрүүлсэн юм байна лээ Дорнодод хөдөө орон нутагт малчдын дунд. Тийм учраас уг нь бид нар чинь суман дээр манай нийгмийн даатгалын байцаагч, халамжийн, ингээд нийгмийн ажилтнууд гээд ингээд хүмүүс байгаа байхгүй юу. Тэгээд манай анхан шатан дээр ажиллаж байгаа улсууд одоо яг энэ иргэдэд яг энэ батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилт энэ хууль тогтоомжоор иргэдэд яг ямар ямар давуу тал олгоод байгаа юм бэ гэдгийг ингээд байнга мэдээлэл өгч байдаг энэ тал дээр үнэхээр жаахан алдаа дутагдлууд байна уу гэвэл байна байна. Энэтэй би тантай санал нэг байна.

Тийм учраас ингээд шинэ технологи жаахан хол сонсогдож магадгүй. Тэгэхдээ шинэ технологи нэвтрээд бид нар энэ хиймэл оюун ухаанаар 24 цаг хүн чинь 8 цаг л ажилладаг шүү дээ. 24 цаг энэ малчдад та нарт ингээд нэг ийм ийм хөдөлмөрийн гэрээ хийх бололцоо байна. Нийгмийн даатгалын шимтгэлээ бололцоотой үедээ.

Л.Энхнасан: Сайдын микрофоныг нэмж өгнө үү.

Л.Энх-Амгалан: Виртуал гээд ярихаар гадаад үг орууллаа. Харь ертөнцийн үгээр ярилаа гээд малчид маань шүүмжилж магадгүй л дээ. Гэлээ гэхдээ энэ чинь өнөөдөр гар утас ухаалаг утас болоод хүн бүхний өдөр тутмын хэрэглээ болчихсон учраас фэйсбүүкээ ухаж байхаар, фэйсбүүк сүлжээ байна аа. Өнөөдөр Монгол Улсад 1600 орчим хөдөөгийн багуудаас одоо яг 1400 орчим хөдөөгийн баг дээр одоо сүлжээ орчихсон байгаа. Манай малчид маань гар утсан дээрээ ухаалаг гар утсан дээрээ одоо яг энэ хөдөлмөрийн бид нарын ч дутуу тал байгаа. Энэ хууль энгийн үгээр ойлгуулах, тайлбарлах, сурталчлах тэгээд тэр хуулиар нээгдэж байгаа тэр боломжуудыг малчдад өгөх чиглэлээр бол бид нар нэг тийм цаг үеийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн ийм ажлуудыг хийж өгөх ийм шаардлагууд байгаа. Тэрэн дээр бид нар энэ технологийн онцлогийг харуулсан ийм шинэ бүтээгдэхүүнүүд үйлчилгээнүүд удахгүй гаргаж ирнэ гэж ингэж бодож байна.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн тодруулъя нэг минут.

Ц.Идэрбат: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр сайд яг хууль дээрээ энэ чинь 3 яам, үйлдвэрчний эвлэл, тэгээд ажил олгогч гээд ингээд яг тэнцүү сайхан хуваачихсан байгаа шүү дээ. Танайхаас хүсэлт ирсэн юм байна лээ. Гэхдээ тэр чинь хуулиараа үйлдвэрчний эвлэлээс ирсэн нэрэн дээр л бид ярих ёстой болохоос биш үйлдвэрчний эвлэлийн хажуугаар яамны ирсэн нэр гэж ярьж болохгүй болчихоод байсан байхгүй юу хуулиараа.

Тэгэхээр чинь энэ чинь үйлдвэрчний эвлэлийн эрх ашиг хөндөгдөж байна шүү дээ. Зүгээр миний хэлж байгаа санаа бол энэ 9 хүний бүрэлдэхүүн дотор хэд байдаг юм. Энэ ахмадын төлөөллийг бид тэр хуулиараа шинэчлээд өөрчлөөд оруулчихмаар юм билээ шүү, оруулчихмаар юм билээ. Магадгүй өнөөдөр энэ

тэтгэврийн зээлтэй холбоотой, энэ тэтгэвэртэй холбоотой энэ олон асуудлуудыг бид болон төрийн албан хаагч нар олж хараагүй байхад тэр ахмадууд бол яг тэтгэвэр авагч өөрөө учраас илүү ойрхон зүйлийг ярьж хэлж шийдвэрт тусгуулах юм билээ.

Л.Энхнасан: Тийм зөв зөв энэ асуудлыг бид нар Байнгын хороон дээрээ ярьсан. Тэгээд нийгмийн даатгалын ерөнхий хуульд нөгөө МҮЭХ-ноос 3 төлөөлөл байх ёстой гэсэн. Тэрний дагуу үйлдвэрчний эвлэлээс ирсэн нэрсийн дагуу бид нарт сонсгол хийж нэр дэвшигчийг сонгосон. Одоо дараачийн удаа дахиад нэр дэвшигчийг бид нар сонгоогүй учраас дахиж сонголт явагдана. Энэ үед бол ахмадын холбооноос нэр дэвшигч ороход бол нээлттэй байгаа. Ер нь бол бид нар бол энэ Нийгмийн даатгалын ерөнхий хуульд энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төлөөллийг бол дахин ярьж өөрчлөлт хийх нь зүйтэй юм байна гэдэг дээрээ бол бид нар Байнгын хорооны гишүүд бид нар санал нэг байгаа. Тэгэхээр энэ дээрээ бас анхаарч ажиллана аа.

Ингээд Булгантуяа гишүүн асуултаа асууна уу?

Х.Булгантуяа: Би Асуулт асуухаасаа илүү санал хэлье гэж бодлоо. Бид нар ер нь яах вэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яагаад нэмчхэв гэдэг биш хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яаж нэмэх вэ гэдэгт эсрэгээрээ Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурал ажиллах ёстой гэж бодож байна. Өнөөдөр түрүүн бас Энх-Амгалан сайд хэлж байна. Одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллаж байгаа хүн бараг байхгүй. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дорвитойхон шиг нэмэхээр ганц айдаг юм нь төрөөс хариуцаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг төрөөс хариуцаж байгаа хүмүүсийн цалин хөлс дээрээс нь түүнтэй уялдуулж сайн дурын шимтгэл төлөгчдийн байдаг юм уу төлөх төлбөр л нэмэгдчих вий гэж бид нар айгаад нэмж чадахгүй байгаад байдаг.

Гэтэл нэг ийм зүйлээс айсаар байгаад эсрэгээрээ өнөөдөр Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмж бага байгаад байгаа учраас гайгүй чадвартай боловсон хүчнээ гадаад руу алдахаас авхуулаад бидэнд асуудал их байна. 2023 онд бид нар хөдөлмөрийн зах зээлийн нэг томоохон судалгаа хийгээд аваад үзэхэд 2012-оос 2022 оны хооронд цалин нэмэгдсэн байдал нэрлэсэн цалинг ам доллароор илэрхийлэхэд 2012 онд 410 доллар 20 цент байсан доллароор.

2022 онд 10 жилийн дараагаар 478 доллар 20 цент. Ингээд өөрөөр хэлбэл манай хөдөлмөрийн хөлсний сарын дундаж цалин ерөнхийдөө олигтой нэмэгдэж чадаагүй иргэдийн зүгээс өнөөдөр хөдөлмөрийн үнэлэмж муу байна гэж хэлж байгаа нь бас аргагүй. 2023 оны 7 сард 3 талт хөдөлмөр нийгмийн түншлэлийн хэлэлцээрийг 3 талт хэлэлцээрийг хийхэд тухайн үед Энх-Амгалан сайд Боловсролын сайдын шугамаар оролцож байсан. Эрүүл мэндийн сайд, Хэрэг эрхлэхийн сайд, дээрээс нь Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд гээд анх удаагаа 5 сайд оролцож тухайн үед Эрдэнэбат гишүүн үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч байсан.

Ингээд аль аль талаасаа 5, 5 хүний төлөөлөлтэй оролцож байсан. Тэгэхэд хамгийн их яригдаж байсан асуудал бол ерөөсөө энэ хөдөлмөрийн үнэлэмжийн асуудал. 1990 оноос 2005 оны хооронд 15 жил энэ хугацаанд төрөлт огцом буурсан. Үүнээсээ үүдээд энэ үеийнхэн 18-аас 35 насныхан яг хөдөлмөрийн зах зээлд орж ирж байгаа хүмүүс бол 250-аас 300 орчим мянгаар цөөрсөн. Төрөлттэй уялдуулаад. Тэгэхээр төрөлт буурна гэдэг бол ийм үр дагавартай байдаг. Тэгээд яг одоо бол

манай ажил олгогчдын хувьд бол хамгийн том толгойны өвчин бол ерөөсөө ажиллах хүн олдохгүй байна гэдэг асуудал болсон. Ажиллах хүн олдохгүй байна. Одоо 1.2 сая хүн нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа. Тэгээд түрүүний манай Идэрбат гишүүний хэлж байгаа үнэн л дээ. НДШ төлөгч ажилчдыг ганцхан үйлдвэрчний эвлэл, хуулиараа нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр төлүүлнэ гээд ингээд оруулаад ирчихсэн. Гэтэл үйлдвэрчний эвлэл нь 200 мянган гишүүнчлэлтэй. Одоо НДШ төлж байгаа хүн 1.2 сая. Дээрээс нь 500 мянган хүн тэтгэвэр авч байна. Өмнө нь төлчхөөд авч байгаа хүмүүс. Тэгэхээр 1.7 сая хүнийг төлсөн болон одоо төлж байгаа хүмүүсийг үйлдвэрчний эвлэлийн 200 мянган гишүүнчлэлтэй байгууллага л ганцаараа хуулиараа төлөөлнө гэдэг бол бас энэ учир дутагдалтай. Тэр үнэн.

Л.Энхнасан: Тодруулга нэг минут нэмчихье.

Х.Булгантуяа: Тухайн үед одоо манай үйлдвэрчний эвлэлийн байгууллага бүр нэлээн уурласаар байгаад л энийг хуулийн зүйл заалтад оруулаад хамгийн харамсалтай нь өөрснөө сая Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох болоход маш хариуцлагагүй хандсан байна лээ. Тэгээд нэг зар тавьсан тэгээд нэг хүн материал ярьсан. Тэр хүний материалыг л ирүүллээ шүү дээ гэсэн байдалтай бараг хандаж байна лээ. Тэгэхээр тэр ер нь буруу.

Тэгэхээр би бол ийм саналтай байна. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асууя гэж бодож байна. Ер нь энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хуульдаа бүр шигтгээд өгвөл 1 дүгээрт яасан юм бэ?

Хоёрдугаарт ахиад дээрээс нь нэмээд ер нь энэ хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас цаашид ямар арга хэмжээ авах вэ? Иргэдэд бухимдаад байгаа эдийн засгийн өсөлт иргэдийн амьдралд хүрэхгүй байна гэдэг бол яг үүний нэг тод жишээ. Монгол Улс эдийн засаг нь өсөөд байдаг. Яг нөгөөдөх нь цалин болж иргэдээр амьдарч цалинг бууж байгаа нь харьцангуй бага байгаад байна аа. Тэгэхээр энэ талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас цаашид ямар арга хэмжээ авах вэ?

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна уу?

Л.Энх-Амгалан: Манай Ариунзаяа сайд, Булгантуяа сайдууд маань, Булгантуяа сайдууд маань мэргэжлийн сайдууд учраас асуудлын шийдлүүд дандаа ярьж байгаа. Сая бид нар энэ танхимд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ яагаад нэмэгдүүлсэн бэ гэж хэлэлцэж суухаас илүү хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яаж нэмэгдүүлэх вэ гэж ярилцаж суувал илүү их тийм үнэ цэнтэй цаг хугацаа байна гэдэг маш том зөв өнцөг.

Тэгэхээр мэдээж би түрүүн хэлсэн энэ Монгол Улсад ДНБ-д эзэлж байгаа бодит цалингийн зардал яг манайтай адилхан эдийн засгийн өсөлт одоо нэг 4-өөс 6 хувьтай явж байгаа улс орнуудын хувьд бол их бага юм байна лээ. Сая Булгантуяа сайд маань жишээ татаж хэлж байна шүү дээ. Доллароор илэрхийлэхээр ерөөсөө цалин нэмэгдээгүй байхгүй юу. Үндсэндээ сүүлийн 10 жилд доллароор цалин нэмэгдээгүй доллар руу шилжүүлэхээр. Тэгэхээр ингээд мэдээж энэ макро эдийн засгийн том үзүүлэлтүүд гарч ирнэ. Цаашдаа бид нар Монгол хүний энэ бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэл рүү бид нар анхаарах ёстой юм байна гэж би харж байгаа. Тэр утгаараа одоо энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ бүтээмжийн үндэсний

хувьсгалыг нэвтрүүлэе гэж их том яах вэ сүржин нэртэй байж магадгүй гэхдээ ямар ч байсан энэ хөтөлбөрт туссан. Сая бид нар Азийн бүтээмжийн байгууллагатай хамтарч Монгол Улсад анх удаа энэ Монгол хүний бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэл рүү нэлээн том үндэсний хэлэлцүүлгүүдийг хийлээ. Удахгүй одоо ингээд Монгол Улсын бүтээмжийн мастер төлөвлөгөөг Булгантуяа сайд гаргах гэж байна. Ингээд цаашдаа ер нь хамгийн бүтээмж муутай байгаа ХАА-н салбар өнөөдөр ХАА-н салбарт цалин яагаад бага байна вэ гэхээр бүтээмж муутай байгаад байгаа юм.

Өнөөдөр уул уурхайн салбар банк, санхүү мэдээлэл технологийн салбарт яагаад өндөр цалин 5-аас 8 сая төгрөгийн цалинтай байна гэхээр тэнд бүтээмж өндөр байгаа. Тэгэхээр бид нар энэ бүтээмж муутай байгаа, цалин хөлс муутай байгаа салбаруудынхаа бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийг нэвтрүүлэх, тийм ур чадварыг дээшлүүлэх чиглэл рүү бол маш том бодлого явуулах ёстой гэж харж байгаа. Манай энэ хөдөлмөрийн зах зээл дээр байгаа гажуудал бол ерөөсөө энэ хөдөлмөрийн хомсдолын гажуудал, эрэлт нийлүүлэлтийн гажуудал бол мэдээж цалин хөлсний асуудал, бүтээмжийн асуудал. Хамгийн гол нь ур чадварын гайп зөрүү.

Тийм учраас энэ ур чадварын яг зөрүүг арилгах. Ингэснээр бүтээмж нэмэгдүүлж байж Монгол хүн бүрийн нэг цагт дор хаяж нэг тийм 5-8 доллар ядахдаа авах. Цаашдаадаа 1 цагт 10 долларыг үнэлүүлж авах, цалин хөлсөө үнэлүүлж авах ийм бүтээмжтэй ард түмэн болохын төлөө л бид нар бүгдээрээ зориг орж яах ёстой гэж бодоод байгаа шүү дээ. Би ер нь энэ аж ахуйн нэгжүүдийн захирлуудаас бас нэг уриалахад би ч гэсэн хувийн хэвшилд ажиллаж байсан. Одоо ингээд манай аж ахуйн нэгжүүдийн чинь орлогын ашгийн хувь их өндөр юм байна лээ шүү. Ашгийн хувь их өндөр юм байна лээ. Хурдан морь авах болохоор хэдэн тэрбумаар авдаг. 5, 10 ажилчдынхаа цалинг 10 хувиар, 20 хувиар нэм гэхээр НДШ дарамт болоод байна гэж суугаад байдаг. Ийм байдлаар явж болохгүй. Би энийг Хөдөлмөрийн сайдын хувиар бүр онцгойлж дурдаж хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь манайхан шиг энэ мэдээж ажил олгогч баялаг бүтээгчид маш чухал том ачаалал үүсэж явж байгаа. Гэлээ гэхдээ өнөөдрийн ашгийн маржен манайхан шиг ингэж өндөр байдаг ийм улс орнууд их ховор болчихсон шүү. Ашгийн маржен өндөр байна гэдэг бол ажилчдадаа бага цалин өгч байна л гэсэн үг.

Тэгэхээр энэ чиглэл рүү бид нар энэ цалин хөлсний бодлого бүтээмжийнхээ бодлогыг бол зайлшгүй өөрчлөх ийм цаг хугацаа болсон. Тэгэхгүй бол Монгол хүн эх орондоо ажиллах, хөдөлмөрлөх сонирхол маш ихээр буурч байна л гэж харж байгаа. Би түрүүн нэг жишээ дурдаж хэлсэн. Өнөөдөр Австрали улсын барилгын арматур зангидалт дээр бол 7 мянган залуучууд ажиллаж байгаа юм байна лээ шүү дээ. Өнөөдөр үндсэндээ Австрали улсын барилгын зах зээл дээр яг 7 мянган залуучууд бол үнэ тогтоож байгаа юм байна лээ. Арматур зангидалтаар. Гэх мэтчилнээр Монгол залуучуудын ур чадвар бүтээмж бол үнэхээр өндөр. Тэгэхээр энийг эх оронд нь бид нар яаж энэ бүтээмжтэй, ур чадвартай залуучуудын өндөр цалинтай, ажлын байруудыг бий болгох вэ л гэдэг. Манай Монгол Улсын том зорилт байх болов уу л гэж бодож байна.

Тэр хүрээндээ энэ Засгийн газрын нэг хүнд ноогдох ДНБ 10 мянган долларт хүргэе гэж зориод байгаа чинь Монгол хүний цалин хөлс хамгийн багадаа доллароор мянган доллар болох одоо энэ зорилтыг тэр 14 мега төслөө хэрэгжүүлж

чадах юм бол энэ зорилтод хүрэх цаг хугацаа их ойрхон байна гэдгийг л ингэж уялдуулж тайлбарлая гэж бодож байна.

Л.Энхнасан: Баярлалаа Бейсен гишүүн асуултаа асууна уу.

Б.Бейсен: Энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 төгрөг болно гэж байна л даа. 792 мянга болчихсон. Тэгээд энэ баруун алслагдсан бүс нутаг энэ хүрэлцээтэй юу байна. Жишээлбэл бид сая гурилын импортын татварыг тэглэсэн юуг аваад хаячихлаа. Булган сум гэхэд аймгийн төвөөс 317 км. Нийтдээ энэ Улаанбаатараас 2 мянгаад километр хол шүү дээ. Нэг ч удаа гурилыг 200-аас 250 мянгаар авдаг. 1 тонн нүүрсийг 280-аас 350000-ын хооронд авдаг. Одоо бензин шатахуун нэмэгдсэн. Тэгэхээр энд бүсийн нэмэгдлийг олгох асуудал байна уу? Олгож байгаа юу? Олгохгүй байгаа юу? Олгож байвал хэдэн төгрөг энэ бүсийн нэмэгдэл гэж олгодог вэ. Энэ НДШ жишээлбэл өндөр насны 2 хүн байлаа гэхэд тэтгэвэр, хоол, хүнс нь ч хүрэхгүй. Бензин шатахуун нь ч хүрэхгүй эмнэлэг явж чадахгүй ийм асуудал үүсээд байгаа байхгүй юу. Булган сумын хувьд бол ард иргэдийн бараг гучаад хувь нь нүүгээд ийм нийгмийн байдалтай холбоотой нүүчихсэн. Бараг сум 40-өөд хувь нь нүүчихсэн гэхэд бүр хилсдэхгүй биз. Энэ асуудлыг яаж шийдэх вэ? Энэ талаар асуулт асууя.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна аа.

Л.Энх-Амгалан: Бейсен гишүүн ингээд бүсийн нэмэгдэл гэдэг ойлголт бол төрийн албан хаагч нарт байгаа. Тэр тусмаа төрийн тусгай албан хаагч нар хилийн цэрэг дээр энэ нэмэгдлүүд байдаг. Алслагдсан хүнээс шалтгаалаад тийм ээ алслагдсанаас шалтгаалаад 2-т нь бол өнгөрсөн жилээс авхуулаад бид нар хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч нарт бол бид нар сумын нэмэгдэл гэж 40 хувь олгож байгаа. Аймгийн төв дээр 20 хувь олгож байгаа тийм ээ. Энэ нэмэгдлүүд байгаа. Ер нь цаашдаа сая одоо манай Бямбацогт гишүүн гээд ингээд байнга бүсийн нэмэгдэл ярьдаг энэ тэр гишүүнүүд бий л дээ. Тэгээд бид нар энэ хүн амын орлогын албан татвар дээр ингээд тодорхой шинэчлэл хийхээр энэ Засгийн газар ажиллаж байгаа. Тэгээд удахгүй Улсын Их Хурал дээр энэ хүн амын татварын шинэчлэл реформ нийгмийн даатгалын шимтгэлийн реформуудыг хамтарч оруулж ирэхээр ингээд энэ тодорхой тооцоо судалгаанууд хийгдэж байна. Энэ хүрээндээ Улаанбаатараас хэр зэрэг алслагдах тусам бараа бүтээгдэхүүнүүд тэр алслагдсан хөдөө орон нутагт хямд байдаг. Иргэдийнх нь орлого өндөр байдаг. Нэмэгдлүүд нь өндөр байдаг. Ийм тогтолцоо руу л шилжих ийм бодлогын шийдлүүдийг л хийж судалгаанууд гаргаж байна гэж хэлье.

Л.Энхнасан: Бейсен гишүүн тодруулга асууна аа.

Б.Бейсен: Энэ бүсийн нэмэгдлийг асууж байгаа нь Энх-Амгалан сайд аа. Жишээлбэл Булган суманд бензин шатахуун 4 мянган төгрөг, цахилгаан нь ингээд нэмэгдээд л өндөр үнэтэй тэгээд бүх өргөн хэрэглээний хүнсний бараа бас ийм үнэтэй. Тэгэхээр энэ бүсийн нэмэгдлийг зөвхөн төрийн үйлчилгээний албан хаагч төрд ажиллаж байгаа улсуудад олгож байгаа юу? Ажилгүй улсууд дээр олгогдох уу? Ажилгүй улсууд өндөр настан тэтгэвэрт гарсан улс энэ бүсийн нэмэгдэл гэж авч байгаа хүн байхгүй байна. Бодит байдал дээр энийг яах вэ?

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Тэгээд хүн бүхэн л ажил хөдөлмөр эрхлэх л эрхтэй л дээ. Тэгээд халамж хэрээсээ хэтэрсэн гэдэгтэй бол бид нар санал нэг байгаа. Тийм учраас удахгүй Улсын Их Хурал дээр бид нар энэ Нийгмийн даатгалын багц хууль, Халамжийн багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд, Гэр бүлийг дэмжих тухай хуулиудаа ингээд багцаар нь өргөн барихаар бэлдэж байна. Энэ хүрээндээ татварын реформуудыг хийнэ.

Тэгэхээр мэдээж баруун бүсэд нэгэнт бүсийн бүсчилсэн хөгжлөөр хөгжих энэ шинэ хөгжлийн шинэ боломжууд хаалгууд нээгдэж байгаа учраас одоо энэ баруун бүсэд аль болохоор мега төслүүдийг хэрэгжүүлэх Эрдэнэбүрэнгийн УЦС-аас авхуулаад том аж үйлдвэрүүдийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх ажлын байр бий болгох чиглэл рүү л энэ бодлого барьж байж бид нар хүмүүсээ ажилгүйдэл ядуурлаас л гаргах өөр шийдэл байхгүй болов уу гэж би бодож байгаа шүү дээ.

Л.Энхнасан: Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байгаагүй учраас магтуулахгүй байх. Бид нар олон асуудлуудыг хөндөж байгаа. Халамж бол халамж биш хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хөндөж байгаад баяртай байгаа. Гол нь манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны явж байгаа үндсэн чиг зарчим Энх-Амгалан сайдын үед энэ нэлээн сайн явах болов уу гэсэн ийм итгэл үнэмшилтэй яг ний нуугүй хэлэхэд байгаа. Энэ НДШ бол хуримтлал юм гэдгийг сая Энх-Амгалан сайд өөрөө хэлчихлээ.

Шударгаар хөдөлмөрлөж байгаа хүмүүсийн мөнгийг шударга бусаар халамж авч байгаа нөхдүүд хүртэж байна гэж байгаа агуулга ч юм уу нэг талдаа. Тэгээд бид нар энэ хөдөлмөр хөлсний доод хэмжээг нэмэх тусмаа сайн л даа. Заавал 2 жил хүлээгээд байхгүй. Тэгээд нэмээд явж л байвал сайн. Халамж биш хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж л байвал сайн. Одоо үнэхээр тэгж болдог бол аль аль талдаа л байнга л нэмж баймаар л байна. Тэгээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр хөдөө орон нутагт яг ажил эрхлэлт байдалтай холбоотой нөлөөллийн судалгаануудыг хийдэг юм болов уу?

Тухайлбал энэ орон нутагт ажлын байр нэмэгдэх үү эсвэл нөгөө талдаа зардлын дарамттай холбоотойгоор буурах уу? Энийг яг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам судалгаа хийсэн бол яг тэдэн оны тийм судалгаа тийм үр дүн гарсан гэдгээ нэг тайлбарлаад өгчихмөөр байна.

Хоёрдугаарт, энэ нийгмийн даатгалын шимтгэлийн өөрчлөлттэй холбоотой иргэдэд үзүүлж байгаа нөлөөллийн асуудал байна. Би сая хэлсэн. Доод хэмжээ нэмэгдээд л байвал сайн. Гэхдээ шимтгэлийн асуудал яригдана. Шимтгэлийн нэмэгдэл яг иргэдийн орлого дээр хэрхэн нөлөөлж байгаа судалгаа байгаа юу? Энийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яг тэдэн сарын тэдэнд тийм судалгаа хийсэн, тийм байдлаар нөлөөлөл үзүүлж байгаа гэдгийг тайлбарлаад өгчихмөөр байна.

Нөгөө нэг асуудал энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай холбоотой асуудал байгаа. Энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байгаа санхүүжилт яг ажилгүйдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж байгаа юу? Энэ дээр үнэлгээ хийсэн үү? Энэ үнэлгээ хийсэн бол яг үнэлгээ хийсэн яг ийм бодит

үр дүн байгаа гэдгээ яамныхан маань хэлээд өгчихмөөр байна. Тэгвэл их сайн байна.

Түрүүн Ганхуяг гишүүн ч хөндлөө. Би одоо Энх-Амгалан сайдын ярианаас ойлгохдоо Энх-Амгалан сайдыг сайд байх хугацаанд хууль хэрэгжихгүй юм байна гэж ойлголоо. Хуулийн хэрэгжилтийг хангуулахгүй юм байна гэж ойлголоо. 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлагдсан хууль. Энэ бол парламентад Ганхүлэг гишүүн бид 2 тэр үед байгаагүй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд маань өөрөө байсан. Та бүхний л баталсан хууль шүү дээ нэг талдаа. Тэгээд хууль баталчхаад дараагаар нь энэ асуудалтай юмаа хэрэгжүүлэхгүй гээд суугаад байж болохгүй л дээ. Эсвэл Ганхүлэг гишүүн нэг 38 тэрбум төгрөг олоод ир гэж байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүд боломжоороо төсөв тавиад хууль хэрэгжих ёстой учраас хуулийнх нь дагуу тавиад л явах ёстой л байгаа.

Л.Энхнасан: Нэмэлт нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр малчны тухай хуульд төрөөс баримтлах бодлого 4.29 дээр хуульд заасан өндөр настны тэтгэвэр тогтоолгоогүй, малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ л гээд оруулчихсан шүү дээ. Үгүй тэгээд хэрэгжүүлэхгүй юм энийг яах гэж оруулсан юм. Энэ популизмын чинь л үр дүнг өнөөдрийг хүртэл бид нар хүртээд явж байгаа л хэлбэр шүү дээ. Нийгмийн даатгалын сан даахаа больчихлоо гээд л та өөрөө сая маш олон жишээ ярилаа. Маш олон популизмуудын л үр дүн нэг талдаа. Нөгөө талдаа сонгуульд л чиглэсэн үйл ажиллагааны чинь үр дүн. Тэгээд анхнаасаа эх үүсвэр тодорхой юмнуудыг бид нар маш сайн бодох л ёстой байсан. Тэгээд одоо нэгэнт хууль гарчихсан, тогтоол гарчихсан, хэрэгжих ёстой. Маш олон малчид энэ дээр итгэл үнэмшлээ өгчихсөн. Үүнийх нь хүрээнд ч гэсэн МАН магадгүй санал авсан байх. Тэгээд энэ дээр би тодорхой хариултуудыг аваад нэмэлт асуулт асууя.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: Хамгийн сайн халамж бол хөдөлмөр эрхлэлт гэж бодож байгаа. Тийм учраас өнгөрсөн хугацаанд энэ халамжийн чиглэлээр хийсэн төсөл хөтөлбөрүүдэд бид нар үнэлгээ хийсэн. Тэгээд өнгөрсөн намар би буруу санаагүй бол өнгөрсөн намар 2 удаа Байнгын хорооныхоо бүх гишүүдэд энэ өнгөрсөн хугацаанд нийгмийн хамгааллын чиглэлээр халамжийн чиглэлээр ийм ийм бодлогууд хэрэгжсэн юм байна, ийм ийм хөтөлбөрүүд хэрэгжсэн юм байна. Энэ нь ийм ийм үр дүн өгсөн юм байна гэдэг ийм цэнхэр ном өгсөн Бат-Эрдэнэ гишүүн ээ. Бүх гишүүдэд. Тэрэн дээр үнэлгээнүүд байгаа. Тэгээд энэ номыг би танд дахиж хүргүүлье. Анх удаа бараг ер нь энэ өнгөрсөн хугацаанд халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд дээр үнэлгээ хийсэн анхны тохиолдол болов уу гэж бодож байна.

Энэ дээр үндэслэж бид нар цаашдаа Монгол Улсад нийгмийн хамгааллын тогтолцооны зураглалаа бид нар хийж байгаа. Системийн шинжилгээ бид нар хийлгэсэн. Ариунзаяа сайдын үеэс, Булгантуяа сайдын үеэс үргэлжлүүлж хийж байсан энэ ажлууд ингээд үргэлжлээд одоо тогтолцооны зураглалууд гарч ирж байна. Тэгээд удахгүй бид нар энэ нийгмийн хамгааллынхаа багц хууль болох Нийгмийн даатгалын багц хууль, Халамжийн багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих тухай хууль, Гэр бүлийг дэмжих тухай хууль ингээд ер нь багцаар нь өргөн барих гэж байна. Энэ тогтолцооны шинэчлэл гэж харж байгаа. Манай яаманд байгаа судалгааны институт байдаг. Энэ институтийг бид нар жинхэнэ утгаар нь энэ судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэн болгож зохион байгуулъя гэж зохион байгуулалт хийж байна.

Цаашдаа энэ салбарын статистик мэдээллүүдийг бид нар их өгөгдөлд суурилсан ийм платформуудыг бид нар хөгжүүлж байна. Эхний бид нар дашбоардуудаа та бүхэнд танилцуулсан. Энэ хүрээнд ингээд цаашдаа бид нар ер нь нэг бид нарыг нэг шүүмжлээд байгаа гадаадын донор орнууд энэ хандивлагч орнуудын шүүмжлээд байгаа зүйл ингээд байна шүү дээ. Та нар ерөөсөө хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, халамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж болно.

Нэгдүгээрт та нар ерөөсөө зорилтот бүлэгтээ ерөөсөө хүргээгүй байна аа. Зорилтот бүлгээ тодорхойлж чадаагүй юм байна. Нийт халамжид зарж байгаа 100 төгрөгийн чинь 26 төгрөг нь дандаа өндөр орлоготой иргэдэд очоод байна шүү л гэж байгаа шүү дээ, өндөр орлоготой иргэдэд. Тийм учраас зорилтот бүлэгтээ ерөөсөө тодорхойлж чадаагүй.

Хоёрдугаарт, ерөөсөө та нарын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд чинь дуусдаггүй юм байна аа. Уг нь халамжийн хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд бусад улс орнуудад хугацаатай хэрэгждэг. Хэзээ эхлэх вэ, хэзээ дуусах вэ, ямар үр дүнд хүрэх вэ гэдэг. Тэгэхээр энэ бодлогын шинжилгээнүүдээ хийдэг, бодлогодоо үнэлэлт дүгнэлт хийдэг. Одоо ийм тогтолцоо бүтцүүдийг л яамандаа бий болгож байгаа. Тэгээд энэ чиглэлээр нэлээн ахиц дэвшил гарах болов уу гэсэн ийм хүлээлтүүд байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн 6 хөтөлбөрийн хөтөлбөр нэг бүрээр нь Монгол Улсад энэ зарласан жил бүхэн 130 тэрбум төгрөг зарж байгаа энэ сангийн хэрэгжүүлж байгаа тэр хөтөлбөрүүд нь жил бүхэн хэдэн ажлын байрыг бий болгочхов. Тэр нь хэдэн тогтвортой ажлын байр байна, хэд нь улирлын шинж чанартай ажлын байр бий болгочихсон юм бэ гэдгийг ингээд бид нар салбарын эрдэмтдийг цуглуулсан ийм ажлын хэсэг судалгаануудын ажлын хэсэг гаргаж байна. Одоо тайлангууд нь удахгүй гаргана. Энийг би Байнгын хорооныхоо гишүүдэд хүргэнэ гэсэн ийм бодолтой байна аа.

Хоёрт нь ойлгож байна Бат-Эрдэнэ гишүүнээ. Тойргийн гишүүн болчихсон зовлон их байгаа. Би ч хөдөөгийн тойргоос 4 удаа сонгочихсон. Засгийн газар Засгийн газрын гишүүн хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Хууль хэрэгжүүлэхгүй гэж үг Засгийн газрын гишүүний амнаас гарч болохгүй. Энэ хуулийн хариуцлага хүлээнэ. Засгийн газар хууль дээдлэх зарчмыг баримталж ажилладаг. Нэгэнт хууль батлагдсан бол Засгийн газар хэрэгжүүлэх ёстой. Тэгэхдээ энэ хууль дээр энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална гэсэн ийм зохицуулалттай.

Өнөөдөр энэ журам нь батлагдаагүй байна. Энэ журам батлагдах гэхээр энэ журмыг баталж энэ журмыг хуулийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр 2025 оны улсын төсөв дээр тусгагдаагүй учраас энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд маш их том хүндрэл учирч байна гэж харж байгаа. Би таныг дахиад нэг ийм популист улс төрчдийг дагасан ийм шинэ популист улс төрч битгий байгаасай гэж би хүсэж байгаа. Битгий байгаасай гэж хүсэж байгаа. Асуудалд их прагматик ханддаг хүн та.

Тийм учраас бол ингээд энэ бусдын өмнө улс төрчдийнхөө муу жишгийг бид нар алдааг давтаж болохгүй. Тийм учраас ингээд энэ Малчны тухай хуулийн энэ

хэрэгжилтүүдийг хангах 1 дүгээрт журмаа баталъя. Журмаа батлахад санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй. Энэ журмыг хэрэгжүүлэхэд тэр санхүүгийн эх үүсвэрийг нь та бүхэн 2026, 2027 оны улсын төсөв дээр тусгаад өгөөрэй. Ингээд энэ хууль хэрэгжих ийм бүрэн боломжтой гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа.Эрдэнэбат гишүүн асуултаа асууна. Тодруулга дахиад нэг л минут байгаа.

Л.Энх-Амгалан: Таны өөрийн чинь л хэлсэн үг шүү дээ. Би Нийгмийн хамгааллын сайд байхдаа энийг хэрэгжүүлэхгүй л гэсэн шүү дээ. Таны хэлсэн үг дээр л би асуусан. Мөнгийг чинь төсөвлөөд өгөх ёстой. Тэрэн дээр явах ёстой. Та саяынхаа хариултыг Л.Ганхүлэг гишүүний үгэн дээр хэлчихсэн бол тэгээд л болоо байхгүй юу. Популизм хийх гээгүй. Өнөөдөр популизмын үр дүнг нөлөөллийг бид нар улсаараа амсаж байгаа.

ТАЗ-ийн ажлын албаны маргаан хянах газрын ахлах референт ингэж мэдэгдсэн байна. Хуурамч дипломоор төрд ажилласан хүмүүсийн төрөөс авсан бүх цалинг буцаан төлүүлнэ гэж. Миний санаж байгаагаар би буруу санаагүй бол 2015 оноос хойш тушаал гаргасан албан тушаалтан нь төлөөд явж байсан санагдаж байна. Одоо ажилд орсон хүмүүс нь төлөх юм байна. Ингэж болдог юм уу?

Л.Энхнасан: Сайд хариулах уу?

Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг сайн ярья гэж бодоод байсан. Ашгүй манай 3 сайд маань яг зэрэгцээд гоё сууж байна. Би гурвуулантай нь хэлэлцээрт ороод хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмсэн сайд нар. Хамгийн сүүлд Ариунзаяа сайдын үед, дараа нь Булгантуяа сайдын үед, Энх-Амгалан сайд маань энэ уламжлалт сайхан 3 талт хэлэлцээрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 жилд огцом нэг удаа нэмэх биш жил болгон нэмээд явъя. Сая бүр бүр шаардлагатай бол жилдээ 2 удаа бууруулж ч болно шүү дээ. Ийм хуулийн заалт байдаг. Тэр утгаараа бол Энх-Амгалан сайд маань Засгийн газрынхаа залгамж чанарын үүднээс асуудалд их шуурхай ажил хэрэгч хандаж нэмэхэд хүчин чармайлт гаргасан хүний хувьд би эхлээд баяр хүргэе.

Хоёр сайд ч гэсэн асуулга тавьсан сайд ч гэсэн бас энэ дээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэхэд бол хувь нэмрээ оруулсан сайд нар, талархаж явдаг. Эхний ээлжид.

Хоёрдугаарт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой хэлэхэд манай улс маань ер нь нэг Африкийн жоохон урдуур л яваад байгаа юм.

Өдөрт нэг 10 доллар л байна л даа. Өдөрт шүү дээ. Цаашдаа ингээд харах юм бол яг эдийн засгийнх нь утгаар нь тооцоод томъёолоод дотоодын бүтээгдэхүүнтэй харьцуулаад үзэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сая 900 орчим мянган төгрөг байх ёстой байгаа юм. Хэрвээ бид нар нийгэмд байж байгаа нийт баялгаа зөв шударгаар хуваарилж чадсан бол гэдгийг би хэлмээр байна.

Хоёрдугаарт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 9 бүрийн юмтай хольж хаяад утгыг нь алдагдуулаад хийчихжээ хэдүүлээ. Тийм учраас энэ тал дээрээ

ярилцъя зөвлөлдье. Тэр ажлын байрны төлбөр гэхээр 10 сая төгрөгийн ажилтай хүн ч 2 сая, 1 сая 500-г тэр хөдөлмөр хөлсний доод хэмжээг дабльдаж төлж байдаг. Сая төгрөгийн цалинтай гадаадын ажилтан ч гэсэн яг ижилхэн төлж байдаг.

Тэгэхээр энэ нь өөрөө ингээд бид нар өөрчлөлт хийх юм бол цаана нь байгаа.

Хоёрдугаарт тэр тэтгэвэртэй холбоотой асуудал ярихад тодруулж асуухад маш олон ахмадууд залгаад байна. Одоо гол нь тэтгэврийн зээлийг хязгаарлаад хаячихлаа. 30 хувьд л авахаар боллоо. Манай нийт тэтгэвэр авагчдын 70 хувь нь, 80 хувь нь үндсэндээ бага дунд, тийм тэтгэвэр авдаг. 700, 800 орчим мянган төгрөгийн ийм асуудал тавиад байсан. Энэ тал дээр Энх-Амгалан сайд маань яг нэг Байнгын хороон дээр тодорхой хариулт өгөөч. Энэ тал дээр танд би хандаж олон ахмадад хандаж байгаа учраас тавьсан. Бас арай чангадчихсан юм биш үү гэдэг тал дээр та бас энэ дээр нэг хариулт өгөөрэй гэдгийг хэлмээр байна. Тэр 3 талт механизмыг би тодруулаад асууя.

Тэтгэврийн даатгалын санг манаж байгаа энэ 3 талт механизм гэдгийг бид нар бол энэ өнгөрсөн хууль дээр бол энэ зарчмыг барьж л хийсэн юм. Хэн нэгэн байгууллага гэхээсээ илүүтэйгээр. Тэгэхээр одоо ахмадын холбоо ч гэдэг юм уу ийм байгууллага орсон ийм улс орон байдаг юм уу? Сүхбаатар гуайг ахмадын холбооны хувьд хуучин үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшээд л ороод ирчихсэн юм байна лээ. Дахиад нэр дэвших нь нээлттэй байгаа юм байна лээ. Тийм учраас би ингээд ороод ирвэл улсууд дэмжихэд бэлэн.

Тийм учраас энэ тал дээр бол би тогтоод тодруулга аваад.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх энэ шийдвэрүүд дээр манай Эрдэнэбат гишүүн маань манлайлж үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл ерөнхийлөгч байхдаа манлайлж ажилласан. Одоо цаашдаа ч гэсэн Улсын Их Хурал дээр бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх чиглэл рүү ч гэсэн дуу хоолой болоод ажиллах байх аа. Тэгээд тантай санал нэг байна. Ариунзаяа сайд ч гэсэн өнөөдөр Ариунзаяа сайдын асуулга ч гэсэн ерөнхийдөө энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулж байгаа хууль маань Хөдөлмөрийн хууль нь өөрөө шинэчлэгдчихсэн. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд зохицуулдаг энэ хууль маань бас ингээд нэлээн олон жил шинэчлэгдээгүй. Цаг үеийнхээ шаардлагыг хангаж чадахаа больсон ийм хууль болчихсон юм байна лээ. Тэгээд ер нь үндсэндээ бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг бол бараг үндсэндээ энэнээс тооцож шимтгэл төлдөг л нэг ийм л механизм болчихоод байгаа байхгүй юу.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өнөөдөр цалин авч байгаа иргэд бараг л ер нь байхгүй дээ. Түрүүн манай Байнгын хорооны дарга ч гэсэн алив тэр нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн Монгол Улсад хэд байна гээд ингээд асуугаад байна л даа. Тэгээд ингээд статистик ингээд хараад сууж байхад бол яг үнэхээр бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн их л бага л болчихсон тоо харагдаад байгаа юм. Тэгээд мэдээж энэ чинь цалингийн доод хэмжээ чинь бараг 2.4 саяд дундаж хэмжээ 2.4 саяд хүрчихсэн ийм байгаа. Тэгээд дээд цалин гэхээр 5 сая 8 сая хүрчихсэн. Гэхдээ энэ цөөхөн хүмүүсийнх манай иргэд чинь нэг шүүмжлээд байдаг юм аа. Энэ цалин дээр их эмзэг

байдаг учраас. Энэ бол нөгөө цалин өндөртэй уул уурхай, банк санхүү, мэдээлэл технологийн салбарууд нь ийм өндөр цалинтай явдаг. Гэхдээ ямар ч байсан дундаж цалин бол улсын хэмжээнд энэ 2 дугаар улирлаар нэг ийм үзүүлэлттэй гараад байгаа юм.

Тийм учраас бид нарын гол зорилго бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яг цаашаа ер нь энэ аргачлалаа шинэчилье. Эрдэнэбат гишүүнээ тийм ээ. Аргачлалаа шинэчилье, хуулиа шинэчилье. Тэгээд Монгол хүний нэг цагийн цалин хөлс л дор хаяж нэг 5-аас 8 долларт эхний хэмжээнд цаашаа 10 долларт хүрэх л нэг ийм бүтээмжтэй ард түмэн байх ёстой гэдэгтэй би тантай санал нэг байна аа.

Хоёрт нь тэр ахмадын тэтгэврийн асуудал байгаа юм, тэтгэврийн зээлийн асуудал байгаа. Энэ уг нь үйлдвэрчний эвлэлээс ч ийм санал гаргасан. Манай ахмадын хорооноос ч гэсэн ахмадын зөвлөлөөс ч гэсэн ийм санал гаргаад ер нь энэ ахмадын зээл гэдэг бол яг тухайн өрхийн орлогын амьжиргааны асуудал байдаг учраас энэ их эмзэг асуудал аа. Тэгээд нийт энэ ахмадын зээл чинь ахмадууд чинь авч байгаа энэ зээлээ өөртөө зарцуулахгүй үр хүүхдэдээ зарцуулчихаад байна. Энэнээс болж ингээд л амьдралын өрхийн орлого нь буураад байна гэдэг нэг ийм нийтлэг асуудал байна гэдэгтэй хүн бүхэн санал нэг байх шиг байгаа юм. Гэхдээ би ахмадуудад нэг зүйлийг хэлье.

Тэтгэвэр бол та бүгдийн өмч. Та бол өмчөө захиран зарцуулах нь та бүгдийн эрх. Та бүгдийн эрхэд хөндлөнгөөс хэн ч оролцох эрхгүй. Энэтэй л би та бүхэнтэй санал нэг байгаа. Гэлээ гэхдээ ахмадын амьжиргааны асуудал бол төрийн бодлого, төрийн хамгаалалт, нийгмийн хамгаалал байх ёстой. Тийм учраас нийгмийн хамгааллын бодлого хийж байгаа төр засгийн бодлого энэ рүүгээ чиглэх ёстой. Ингээд үндсэндээ бол энэ ахмадын тэтгэвэр дээр саяын авсан арга хэмжээ бол жаахан цочмогдсон байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл манай нийт ахмадууд чинь бараг үндсэндээ 48-аас 52 хувь нь бага тэтгэвэр авдаг. Тэгээд үндсэндээ нэг жишээ аваад нэг тэтгэвэр авагчаар ярихад 650 мянган төгрөгийн тэтгэвэртэй ахмад байхад тэрнийх нь 470-480 мянга нь ингээд амьжиргаандаа авч үлд ээ. Энэнийхээ зөрүүгээр зээл ав гэхээр нэг тийм 200 хүрэхгүй сарын төгрөгөөр жилийн гэхэд чинь нэг 2.4 сая төгрөгийн зээл аваад ахуй амьдралдаа тохиолдсон зүйлээ шийд гэж хэлэхэд жоохон хатуудаж байгаа нь үнэн.

Тийм учраас нөхцөл байдал дээр бид нар дүгнэлт хийгээд Монголбанктай ярилцаад гэхдээ бид нар бол зээлийн хүү, энэ зээлийн хэмжээг бид нар тогтоодоггүй юм шүү дээ энэ чинь. Монголбанк тэгээд Монголын Монголбанкны мөнгөний бодлого зохицуулж энэ арилжааны банкнууддаа ийм чиглэлүүдийг өгдөг. Тийм учраас энэ арилжааны банкнуудтай бид нар хэлэлцээрт орж саяын зохицуулалтуудыг ямар ч байсан жаахан яг амьдралд нийцсэн тэр тусмаа энэ бага тэтгэвэр авч байгаа хүмүүс зээл авах юм бол тэтгэврээ барьцаалж зээл авах юм бол тэр өөрийнх нь эрэлт хэрэгцээнд нь шаардсан ийм зохицуулалтууд байх ёстой юм байна гэдэг дээр бид нар тохиролцсон. Монгол банкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн ерөнхийлөгчтэй тохиролцсон.

Тэгээд ирэх 7 хоногт энэ бодлогын зөвлөлөө хуралдуулъя гэж байна лээ. Тэгээд эндээс энэ тодорхой шийдлүүд гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. Эхний ээлжид ямар ч байсан авч байгаа цалингийнх нь 50 хувь тийм юу гэдэг юм 700 мянган төгрөгийн цалинтай байхад 300 тавиа өөрөө авч үлдээд 350-иараа бол одоо зээлээ ав гэсэн ийм зохицуулалт энэ дээр Идэрбат гишүүн ч гэсэн энэ Монгол

банк руу асуулгууд асууж яасан юм байна лээ. Тэгээд энэ тайлбарууд дээр тайлбарууд өгч байгаа энэ шийдлүүд удахгүй гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байна аа.

Л.Энхнасан: Тодруулга нэг минут.

С.Эрдэнэбат: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотойгоор ЖДҮ-лэл эрхлэгч нарт хүнд цохилт болж байгаа гэдэг нэг талаас харах өнцөг мөн. Нөгөө талдаа хэрвээ энийг өгч чадахгүй бол цагаар тогтоогоод байгаа юм шүү дээ. Үнэхээр энийг өгч чадахгүй бол 8 цаг заавал ажиллуулах биш 5 цаг ажиллуулаад тэр хүнийг 3 цагтаа өөр дахиад өөр боломжтой газар ажиллах гэдэг юмыг нь бид нар нээж өгөх энэ орон зайг хаахгүйгээр шууд автоматаар сараар нь үржүүлээд 792-оос л заавал төл гэдэг ийм хуулийн юм руу аваачиж тавьчихаад байгаа учраас нөгөө талынх нь энэ боломжийг бид бүхэн олж харахгүй байгаад байгаа юм. Хуулиар бол цагаар тогтооно гэсэн байгаа шүү дээ. Яг сараар тогтооно гэсэн юм байхгүй.

Тийм учраас энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдчихээр ЖДҮ-лэл эрхлэгч нар дампуурна, унана, ингэнэ тэгнэ гээд л манай яг үнэндээ жижгүүд нэг их ярьдаггүй шүү дээ. Манай том компаниуд л яг үнэнийг хэлэхэд тэр ажлын байрны төлбөрөөс жоохон нэмчих болов уу. Нөгөө талаас нөгөө нэг дээд цалингийн төлдөг хэмжээ гэдэгтэй холбоотойгоор дэгсдүүлж яриад байдаг юм байгаа.

Тийм учраас өнөөдөр бол гишүүд.

Л.Энхнасан: Баярлалаа. Би нэг асуулт. Эрдэнэбат гишүүний дээр яг энийг асууя гэж бодож байсан. Ер нь яах вэ ажилтны цалин хөлс нэмэгдээд тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ бол нэмэгдэх ийм эерэг үр дагавартай. Яг ажил олгогчдын хувьд нөгөө шимтгэл төлөгчид нь нэмэгдэж байгаа. Энэ дээр нөгөө судалгаа хийсэн яг ийм дарамт ирэх юм байна эс үгүй бол ийм нэмэгдэл ирэх юм байна гэсэн тийм судалгаа байна уу?

Хоёрдугаарт бол саяын тэр бас цагаар ажиллах цагийн гэрээт ажилчдын талаар яам ямар бодлого баримталж байна? Ялангуяа сая нөгөө малчдын гэрээт ажилтан ажиллах гэсэн оюутнууд бол маш их цагаар ажиллаж байна. Ер нь энэ цаашдаа энэ гэрээт ажилтан ажиллах энэ нэмэгдүүлэх энэн дээр ямар нэгэн хөшүүрэг заримдаа яах вэ олон улсад бол жишээлбэл Японд бол цагаар ажиллаж байгаа хүмүүс бол зарим татвараас нөгөө нэг чөлөөлөгдсөн байдаг. Тийм бодлого ер нь баригдах уу. Энэ дээр сайд ямар, яам ямар бодолтой, Засгийн газар ямар бодолтой байгаа вэ?

Л.Энх-Амгалан: Энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх асуудлаар энэ чинь бас нөгөө дангаараа яам шийдчихдэг биш. 3 талынхаа хэлэлцээрт орж байж яадаг. Энэ дээр ажил олгогчдыг төлөөлж ажил олгогчдын холбоо тэгээд танхим байгаа. Худалдаа үйлдвэрлэлийн танхим байгаа. Ингээд танхимын төлөөллүүд бас орж энэ дээр нэлээн тооцоо судалгаатай хандсан. Тийм учраас нэг талын үйлдвэрчний эвлэл болон Засгийн газар ингээд хамтраад ингээд шийдчихсэн асуудал биш шүү гэдгийг энэ дээр хэлэх ёстой болов уу.

Байнгын хороон даргын асуусан яг ямар хүмүүст ерөнхийдөө тодорхой ачааллууд ирэх, тэр тусмаа ЖДҮ-лэл эрхэлж байгаа улсууд дээр ирэх ачааллуудыг тооцоолж үзсэн үү гэж байна. Энэ дээр яг энэ сайн дураараа НДШ төлж байгаа 134

мянган хүн байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сайн дураараа төлж байгаа. Энэ дээр мэдээж ачаалал дээр нь 660 мянгаас НДШ төлж байсан 792 мянгаас ингээд төлнө. 176 мянган ажил олгогч ингээд нөгөө нэг шимтгэл төлж байгаа НДШ төлж байгаа хүмүүс 176 мянган иргэд бол нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж байгаа. Тэрийгээ дагаад мэдээж тодорхой НДШ бас нэмэгдэнэ. Гэхдээ НДШ нэмэгдэхэд эргээд ирээдүйд өөрийнх нь тэтгэвэр бас нэмэгдэх ийм шууд үр дагавартай ийм өгөөжөө хүртдэг шимтгэл юм байгаа юм гэж л хэлэхийг хүсээд байгаа юм.

Дээр нь ч цөмөөрөө энэ нэг НДШ гэдгийг цаашаа энэ шимтгэл, хураамж, татвар гэж ойлгохоосоо илүү энэ бол хуримтлалын нэг хэлбэрийн юм байгаа юм гэдгийг л нэг сайн ард иргэддээ сайн ойлгуулах ийм хэрэгцээ шаардлага үүссэн байна гэж бодож байгаа. Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр НДШ төлж байгаа улсууд нийт НДШ төлөгч чинь өнөөдөр 25 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. НДШ төлөгч бол 1.2 сая хүн байна. Үүнээс 25 хувь нь бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байгаа энэ хүмүүс дээр бол ачаалал, бага зэргийн ачаалал ирсэн гэдгийг үгүйсгэхгүй ээ.

Л.Энхнасан: Цагийн ажилтны талаар яам ямар нэгэн бодлого.

Л.Энх-Амгалан: Ер нь энэ цагийн ажлыг бид нар цагаар ингээд тооцож ажил хөлсийг нь олгох, цагаар ажиллуулах энэ тогтолцоо руу орох нь зүйтэй. Гэхдээ энэ чинь эерэг бөгөөд сөрөг талтай л юм байна лээ. Одоо цагийн ажил хийж байгаа улсуудын хөдөлмөрийн гэрээний асуудал бол маш сул байдаг. Ямар нэгэн байдлаар ингээд цагийн ажил хийж байгаад үйлдвэрлэлийн аваар осолд орох гэдэг юм уу тиймээ одоо ингээд ажилгүйдэлд өртөх гэх мэтчилнээр нөгөө яг хөдөлмөрийн гэрээ хийгддэггүй, хөдөлмөрийн гэрээгээр бус хөдөлмөрийн хөлсний гэрээгээр зохицуулагдаж байгаа. Энэ юунууд учраас бол энэ нийгмийн хамгааллууд нь л жаахан сулрах ийм сул үр дагавартай. Гэхдээ Монгол Улсад чинь ийм арбат гэж ярьдаг яг цагийн буюу өдрийн ажлын ийм брокер биржүүд их бий болчихсон байна. Би бас хэд хэдэн удаа энэ биржүүд дээр хувийн биржүүд дээр очиж ажилласан. Ингээд энэ цаашдаа бол.

Л.Энхнасан: Нэмэлт нэг минут.

Л.Энх-Амгалан: Ямар ч байсан одоо ингээд Монгол Улсад энэ цагийн ажил тэр тусмаа энэ оюутнууд манай Ганхүлэг гишүүн байж байна. Энэ залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл рүү бол бид нар энэ цагийн ажлын зохицуулалтуудыг хийж өгөхөөс өөр арга байхгүй. Энийгээ дагаад бид нар энэ нийгмийн хамгааллын асуудлуудыг нь мартаж болохгүй. Бид нар нийгмийн даатгалын шимтгэлийн энэ тэтгэврийн шинэчлэл дээр энэ оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн том бодлого явуулах гэж байна. Ганхүлэг гишүүн энэ дээр бид нар яг оюутан цагтаа НДШ төлөхгүй. Яг тогтмол ажлын байран дээр бол тогтмол цалинтай болсон үеэс ирж эхэлж тэр нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх гэрээ байгуулаад, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх гэх мэтчилэнгээр энэ оюутнуудыг ажил хөдөлмөртэй болгох ахмадуудад бас ажил хөдөлмөр эрхлэх бас нэг боломжууд нь энэ цагийн ажил байгаад байгаа шүү дээ. Манай энэ нэгэнт хөдөлмөрийн зах зээл дээр хомсдол бий болчихсон. Бид нарт байгаа өнөөдрийн нөөц оюутнууд байна, ахмадууд байна. Тийм учраас ахмадууд оюутнуудыг цагаар ажиллах энэ боломж зохицуулалтуудыг л хийж өгөхөөс өөр арга байхгүй юм байна л гэж харж байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа.

Зөвхөн асуулт асуусан гишүүн үг хэлж, асуулт асууж болох юм байна. Тэгэхлээр Ариунзаяа гишүүн үг хэлж, асуултаа асууна уу.

А.Ариунзаяа: 5 минут байгаа байх тиймээ. Миний минутыг 5-аар тавиад өгөөрэй. Би асуулт асуухгүй. Би үг хэлье ээ.

Хөдөлмөрийн хөлсний тухай хууль, тогтоомж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох тухай хууль байгаа. Үүний хуулийн зорилт нь бол хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээнд баримтлах цагийн үндсэн цалин хөлсний доод хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна гэж байгаа. Гэтэл цагийн харилцаа гэхээсээ илүүтэй бид нар сарын 792 мянган төгрөг гэдгээрээ л 1 дүгээрт яваад байна.

Хоёр дахь нь болохлоор зөвхөн цалин хөлстэй холбоотой асуудлыг зохицуулах ёстой байтал энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан маш олон бусад бодлогууд эерэг байдлыг давуу байдал үүсгэхээсээ илүүтэй сөрөг санхүүгийн ачаалал үүсгээд байна аа. Ийм учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулсан бусад бүхий л энэ бодлогуудаа больж бид нар бол торгууль хүртэл энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбогдсон байсан шүү дээ. Тэгээд тооцох нэгж гэж яг энэ хууль зүйн салбарын торгуулиудыг бол тусад нь гаргасан. Энэнтэй нэгэн адилаар бусад энэ шимтгэл төлөлт болоод бусад энэ төлбөрүүдийг тусад нь гаргах шаардлагатай байна аа.

Хуулийн 5.4 буюу Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хороонд 2 жилд нэг удаа тогтоох бөгөөд гэсэн үндсэн хугацаа нь байгаа учраас ер нь бол 2 жилдээ нэг удаа тогтоох нь өөрөө тухайн ажилтны цалин гэхээсээ илүүтэй тухайн цалинг олгож байгаа ААН байгууллагуудад бизнесээ тогтвортой хөгжүүлэх эдийн засгийн хүртээмжээ жоохон нэмэгдүүлж байж сая эргээд цалингаа нэмэх энэ боломжийг нь өгөх тухай асуудал учраас бизнесүүдийг хамгаалах тал дээр нь анхаарсан ийм заалтыг 2010 онд тухайн үед Хөдөлмөрийн сайд Ганди сайд байсан, Хууль зүйн сайд Нямдорж сайд байсан. Тэгээд тухайн үед энэ оруулсан өөрчлөлт нь 2 жилд нэг удаа байна гэдэг гол агуулга нь бизнесүүдийг энэ эрсдэлээс хамгаалах асуудал байсан юм аа. Яах вэ 7.2 бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотойгоор маш их энэ төсвийн зохицуулалтууд төрөөс дааж байгаа энэ шимтгэлийн асуудлуудын болон олгогдож байгаа тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ нь уялдаатай байдаг учраас зайлшгүй төсвөөр үүнийг бас хэлэлцэж, баталж, тухайн жилийн 1 сарын 1-ээс хэрэгжүүлнэ. Хэрэв тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш шинэчлэн тогтоосон бол дараагийн төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө өө гэж заасан байгаа.

Тэгэхээр яалт ч үгүй төсөв өргөн барьсан хойно энэ шийдвэр гарсан учраас энэ 7.2-ыг бол үндсэндээ зөрчсөн байна гэж миний хувьд бол үзэж байгаа. Ер нь бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хүмүүс юу гэж буруу ойлгоод байдаг вэ гэхлээр хөдөлмөрийн бүтээмж л юм шиг дундаж цалинтай, ердийн, цалинтай их хольж хутгаж бодоод байдаг. Гэтэл яг өнөөдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь бол зөвхөн цалин хөлсний асуудал биш юм аа. Би тэгээд хэдэн тоон мэдээлэл статистикийг та бүхэнд хэлье.

Хэн яг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжаад байна вэ гэхлээр ердөөсөө 1 ч төрийн албан хаагч байхгүй. Төр бол төрийн албан хаагчдынхаа цалингаа нэмчихсэн. Дандаа хувийн хэвшлийн л ер орчим мянган хүн бол яг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доош цалин хөлс авч байгаа гэдэг НДЕГ-ын тайлангийн мэдээн дээр бол байгаа юм аа. Тэгэхлээр сайн дурын НДШ бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй шууд уялдсан байдаг. Сарын 89100 төгрөг төлж байсан бол яг одоо 4 сарын 1-ээс 106920 болж яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хөдөлснөөс болж сар бүрийн нэмэлт ачаалал нь 17820 болж байна аа. 170 орчим мянган хүнтэй. Малчдын асуудал. Малчин гэхэд чинь л ер нь бол 280 мянган малчин байгаа бол 51 хувь нь л НДШ төлдөг сайн дураараа. Малчдын 20 хүрэхгүй хувь нь нийгмийн даатгалын энэ харилцаанд орсон байна гэсэн үг. Тэгэхээр төрөөс 50 хувийг нь даагаад даагаад энэ хамрагдалт нь нэмэгдэхгүй байгаа.

Ер нь бол маш их ачааллыг яг энэ зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор сарын төлөх хэмжээ нь 2022 онд нийгмийн даатгалын сайн дурын шимтгэл нь 56 мянга байсан бол 2023 онд 74 мянга, 2024 онд 89 мянга, 2025 онд 106 мянган төгрөг болж нэмэгдэж байна аа. Энэ бол нэмэлт санхүүгийн ачаалал учраас тухайн сар бүртээ хүн НДШ төлөх үү үгүй юу. Ийм өндөр болох тусмаа төлөхгүй байх сэдэл нь улам нэмэгдэнэ. Тэгээд нэн ялангуяа одоо нийгмийн даатгалын нэр хүндийг олон талаас нь муулж ярьж байгаа цаг үед бол маш их хүндрэлтэй гэсэн үг. ЭМД-ын шимтгэл сайн дураараа төлж байгаа, сайн дураараа гэнэ. Албан хөдөлмөр эрхлээд 700 мянган хүн төлж байгаа бол 2.4 сая иргэний төлбөрийг яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар төлдөг. Тэгэхээр энэн дээр ч гэсэн сарын нэмэлт ачаалал бол орж ирж байна аа. Яг одоо бол тухайн хамрагдалт.

Л.Энхнасан: Нэг минут нэмье.

А.Ариунзаяа: Ингээд нийгмийн даатгалын сайн дурын шимтгэл ЭМД-ын шимтгэл дээр давхар ачаалал үүсэж байгаа. 2025 онд бол сарын 15840 төгрөгийг бол төлж байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2, 144.3 дээр 25-аас дээш ажилтантай ААН байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах үүргийг хүлээж байгаа. Ажиллуулахгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх төлбөрийг төлөх ёстой. Одоогийн байдлаар бол 8 мянган аж ахуйн нэгж байгууллага төлөх ёстой байтал 800 аж ахуйн нэгж байгууллага төлж байгаа. Гадаадаас ажиллах хүч авч байгаа бол мөн л адилхан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр төлбөр төвлөрүүлэх ёстой энэ ч гэсэн өнөөдөр дахиад давхар ачааллыг үүсгэж байгаа юм аа.

Ийм учраас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг зайлшгүй өөрчилж цагийн хөлсийг тогтоодог байх бусад холбогдсон энэ нэмэлт ачааллуудыг салгах тал дээр нь ажиллахгүй бол энэ ердөөсөө болохгүй байна аа. СӨХ-ны төлбөр хүртэл нэмэгдэж байна гэдгийг иргэд гомдол ирүүлсэн. Баярлалаа.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

16.30 цагт

Хоёрдугаар асуудал. **Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болсон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсоно уу.**

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Өнөрбаяр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Бумаажав Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр хариуцсан референт, Отгон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх Газрын үнэлгээ мониторингийн газрын ахлах референт. Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга, Тамир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Рэгзэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга, Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга, Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Гантуяа ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга, Төгсдэлгэр ЭМЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Энхболд ЭМД-ын Ерөнхий газрын дарга, Эрдэнэбаяр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга нар иржээ. Сайд байхгүй байна. Яамыг төлөөлөөд Гантуяа дарга ирсэн байна даа.

Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаяр тайлантай холбогдуулан танилцуулга хийнэ ээ.

4 дүгээр микрофоныг өгнө үү.

Э.Одбаяр: Монгол Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг ирж мэндчилье ээ. Засгийн газрын хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д заасны дагуу хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж Засгийн газрын Засгийн газарт танилцуулна гэж заасныг тус тус үндэслэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Яам, аймаг, НЗДТГ-аас Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний цахим мэдээллийн санд ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно. Засгийн газрын 206 дугаар тогтоолын 8.5-д ЗГХЭГ, хууль, тогтоол тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж Засгийн газрын

хуралдаанд танилцуулан холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ҮАБЗ-ийн Ажлын албанд тус тус хүргүүлнэ гэж заасны дагуу 2 сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газарт уг тайланг хүргүүлсэн болно.

Монгол Улсын хууль Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд Монгол Улсын нийт 89 хууль, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын Байнгын хорооны 79, нийт 272 шийдвэрийн 1550 заалт бүртгэлтэй байгаа бөгөөд хэрэгжилт нь дунджаар 66.4 хувь байгаа нь өмнөх оноос 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна аа. Үүнээс Нийгмийн бодлогын байнгын хорооны гаргасан 4 тогтоол БСШУС-ын байнгын хороотой хамтран гаргасан 13, нийт 14 тогтоолоор өгсөн 100 заалтын хэрэгжилтийг дунджаар 85.3 хувь буюу хэрэгжих шатдаа гэж үнэлсэн байна. Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хорооноос гарсан Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн холбогдох тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг дэлгэрэнгүйгээр нь Байнгын хорооны гишүүд та бүхэнд тарааж өгсөн байгаа. Тэгээд Байнгын хорооны харьяалах 2 яам буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ЭМЯ-ны холбогдох албан тушаалтнууд ирсэн байгаа учраас тайлан мэдээтэй холбоотой асуулт байх юм бол Байнгын хорооны гишүүдэд үнэлгээ хийсэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын удирдлагууд байгаа. Бид бүхэн та бүхний асуултад хариулахад бэлэн байна аа.

Л.Энхнасан: Хууль тогтоолоор энэ Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцүүлж байгаа. Тийм учраас бас холбогдох яамдын сайд нь байх нь зүйтэй. Мөнхсайхан сайд байвал сайдыг дуудаарай. Гишүүдэд дэлгэрэнгүй очсон байгаа. Тэгэхлээр тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүдийн хувьд нэрсээ өгнө үү? Энх-Амгалан сайдаар тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу?

А.Ариунзаяа: Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой маргааш болно. Бид гэтэл яг хүүхдээ үнэхээрийн хамгаалж чадаж байна уу үгүй юу гэдэг бол маш том асуултын тэмдэг бол тодоос тод үлдэж байгаа юм аа. Тэгээд хүүхдийн асуудал зүгээр нэг эмэгтэй гишүүдийн асуудал ч юм шиг. Хүүхдийн тухай хуулийг хэлэлцэхэд заал хоосон дан ганц эмэгтэй хүүхэд, эмэгтэй гишүүд сууж байсныг санаж байна. Аливаа хүүхдийн асуудал хүчирхийллийн асуудал боллоо гэхэд энэ эмэгтэй гишүүд дуугарахгүй байна гэж нийгмийн шүүмжлэлийг ч би харж байсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ажлаа хийхгүй байгаа юм шиг дайрч байхыг Нийгмийн бодлогын байнгын хороон дээрээ ч харж байсан.

Гэтэл энэ бол зүгээр нэг дан ганц яамны асуудал дан ганц эмэгтэй гишүүдийн асуудал огтоос биш. Тэгээд энэн дээр бид нар өгч байгаа үүрэг даалгавруудаа ч гэсэн зөвхөн Нийгмийн бодлогын байнгын хороо гэлтгүй яг энэ хүүхдийн хөгжил хамгааллын асуудал бол ер нь бүх Байнгын хороогоор хэлэлцэгдэж үүрэг даалгавар өгөх ёстой гэж миний хувьд бол бодож байгаа юм. Хөдөлмөрийн тухай хуулиар ч тэр, Хүүхэд хамгааллын хуулиар ч тэр бид нар тодорхой байгууллага бүрийг үүрэгжүүлсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дээр байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлоготой байх ёстой гэдэг ийм үүрэг даалгаврыг өгсөн боловчиг хэрэгжилт нь 30 хувьтай байна гэдэг ийм үнэлгээтэй байна.

Хүүхдийн эрхийн байцаагч маш өндөр эрхтэй тухайн байгууллагуудыг торгодог, тухайн байгууллагуудад чиглэл өгдөг ийм байцаагч нарыг эрх мэдлийг нь

нэмэгдүүлэх нийгэмд таниулах ажил мөн л 30 хувьтай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байхдаа би ах сайд Энх-Амгалан сайд, Боловсролын сайд байсан. Тухайн үед яг гуравласан Эрүүл мэндийн сайдтай хамт бас нэг тушаал, тогтоол хамтдаа гаргаад энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал маягт шинэчлэх гэсэн ийм үүрэг даалгаврыг авч байсан. Энэ биелэлт нь 0 хувьтай байна гэсэн ийм үнэлгээний дүнг хараад үнэхээрийн харамсаж байна аа.

Яагаад хүүхдийг 1 дүгээрт тавихгүй байгаа юм бэ? Яагаад хүүхдээ хамгаалж чадахгүй байгаа юм бэ? Энэ зүгээр нэг Байнгын хороо ч юм уу нэг яамны асуудал огтоос биш болоод байгаад ямар дүгнэлт хийж байна вэ? Бид яах боломжтой вэ? Хүний хөгжлийн асуудал хэнд хамаарах вэ гэдэг ийм асуултуудыг тавиад дараад нь тодруулъя.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд хариулна уу?

Л.Энх-Амгалан: Ариунзаяа гишүүн энэ хүүхэд хамгааллын асуудлууд хөндөж энэ дээр бид нар яг үнэн дүгнэлтүүдийг өгч өнөөдрийн байгаа нөхцөл байдал дээр их үнэн зөв үнэн дүгнэлтүүд хийж байж бид нар их зөв бодлого гаргаж зөв бодлогоо хэрэгжүүлэх ёстой гэдэгтэй санал нэг байна аа. Хүүхдийн асуудалд бол бүх нийтийн үйлс. Энэ бол бүх нийтийн үйлс. Монгол хүн бүр энэ хүүхдийн асуудалд анхаарал хандуулах, ёстой. Монголын гэр бүл бүхэн гэр бүлийн гишүүд бүхэн хүүхдэд анхаарал хандуулах ёстой. Монголын төрийн албан хаагчид ер нь бүх л хүмүүс 3.2 сая иргэдтэй. 1.2 сая хүүхэдтэй. Тийм учраас 1.2 сая хүүхдээс бусад 2.3 сая иргэд маань энэ хүүхэд дээр анхаарал хандуулах ёстой. Гэлээ гэхдээ ямар ч байсан бид нар өнгөрсөн хугацаанд энэ 100 жилийн хугацаанд энэ Монголд энэ хүүхдийн байгууллагын үүрэг гүйцэтгэсэн үүрэг бол би маш их гэж бодож байгаа. Зах зээлийн шилжилтийн үед ч гэсэн энэ хүүхдийн байгууллагуудаа бид нар татан буулгачхаагүй ингээд аваад явж байсан цаг үе бүрдээ энэ хүүхдийн байгууллагууд үүргээ гүйцэтгэсэн. Маргааш 100 жилийн ой нь тохиох гэж байна 2025 оны 5 сарын 8-нд их зохиолч Нацагдорж 19 насандаа Хойдыг залгамжлагч багачуудын холбоо гэдэг энэ сайхан байгууллагыг байгуулж өнөөдөр 100 жил болсон байна.

Тэгээд энэ жил бас НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод элссэний 35 жилийн ой тохиож байгаа юм байна лээ. Тэгэхээр бид нар 35 жилийн хугацаанд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал дээр Монгол Улс энэ НҮБ-ын өмнө хүлээсэн ОУБ-ын өмнө хүлээсэн аль аль үүргүүдээ биелүүлсэн бэ гэдэг дээр ч гэсэн бид нар үнэлэлт дүгнэлт өгөх ёстой. Саяхан бид нар тайлангаа тавьсан. Ингээд Ерөнхий сайд ахалдаг энэ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл байгуулагдаж 30 жилийн нүүр үзэж байгаа юм байна лээ.

Тийм учраас Хүүхдийн байгууллагын 100 жил НҮБ-ын Хүүхдийн конвенцод ирсэн 35 жил, хүүхэд Ерөнхий сайдаар ахлуулж байгаа хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 30 жилийн хугацаанд хийсэн ажлуудаа бид нар үнэлэлт дүгнэлт хийж энэ өнөөдрийн үүссэн нөхцөл байдал дээр их зөв оношилгоо хийж гаргалгаа гаргах ёстой. Энэ дээр олон сайн талууд байна аа. Өнгөрсөн 9 сарын 1-ээс бид нар Хүүхэд хамгааллын тухай хуулийг яг хэрэгжүүлж эхэлсэн. Ямар ч байсан 330 сум 170 хороон дээр бид нар гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтантай боллоо. Энэ бол хамгийн том дэвшил. Анх удаа 2025 оны улсын төсөв дээр, 2026 оны улсын төсөв дээр бид нар хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийн зардал дээр 20 тэрбум төгрөгийн эх үүсвэр төсвийн эх үүсвэртэй боллоо. Энэ бол хамгийн том

дэвшил. Ямар ч байсан хүний нөөцийн асуудлаа шийдлээ, санхүүжилтийн асуудлуудаа шийдлээ. Одоо цаашдаа энэ хүүхэд хамгаалал, хүүхэд, хөгжил оролцооны асуудлуудыг яг яаж зөв үндэсний тогтолцоо болгох вэ гэдэг асуудал хамгийн чухал байгаа юм. Үндэсний тогтолцоо болгох уу гэдэг асуудал. Тэгээд өчигдөр Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл анх удаа шинэ Засгийн газар байгуулагдаад анхныхаа шинэ бүрэлдэхүүнтэйгээр энэ хурлыг хийсэн.

Ерөнхий сайдын зүгээс албан даалгавар гаргасан. Өнөөдрийн Засгийн газрын хуралдаан дээр салбарын сайдын хувьд өчигдрийн анхны Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын холбоотой энэ мэдээллүүдийг хийж Засгийн газар дээр танилцуулгууд хийгдсэн. Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайд, Хууль зүйн сайд, Соёлын сайд мэдээж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдуудад бас энэ тодорхой үүрэг чиглэлүүдийг өгсөн байж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хамгийн гол нь хэрэгжилт бид нарт хамгийн их чухал. Тийм учраас өнөөдөр энэ 100 мянган хүүхдийн эрсдэлтэй орчинд амьдарч байгаа энэ хүүхдийн асуудлуудыг шийдвэрлэх энэ дээр ингээд энэ хүүхдийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжүүдийг нэмэх энэ тогтолцоог бид нар зайлшгүй хийх шаардлага байна. Удахгүй бид нар энэ Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийг дэмжих хуулиа Улсын Их Хурал дээр өргөн барихаар ингээд ажиллаж байна аа.

Л.Энхнасан: Ариунзаяа гишүүн нэмж асууна уу.

А.Ариунзаяа: Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаан болсонд баярламаар юм уу, уйлмаар юм уу, би сайн мэдэхгүй л байна. Эдийн засгийн хороо нь 7 хоног бүр л хуралддаг шүү дээ. Хүүхдийн төлөө яагаад сардаа нэг удаа хуралдаж болохгүй гэж. Хүүхдээ хамгаалж чадахгүй байгаа нь тоон мэдээллээр гараад байна шүү дээ. Тэгэхээр энэ бол Энх-Амгалан сайдын хийх ч ажил биш энэ бол маш олон сайд нарын, салбарын, Засгийн газрын хийх ажил. Хэчнээн хүүхэд зам тээврийн осолд өртөөд байна, хэчнээн хүүхэд амиа хорлоод байна, хэчнээн хүүхэд цахим энэ электрон тамхи татаад байна, хэчнээн хүүхэд хохироод байна, хэчнээн хүүхдийг зодоод байна. Маш олон асуудал байна шүү дээ. Эдийн засаг чухал байж болно. Гэхдээ эдийн эдийн засгаасаа илүүтэй хүн илүү чухал болов уу гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ бол санал юм гэдгийг аваарай. Энд бол Энх-Амгалан сайдын нэг их буруу гэхээсээ илүүтэй хүүхдийн салбарыг хүүхдийг 1 дүгээрт тавьж чадахгүй байгаатай л холбоотой.

Л.Энхнасан: Чинбүрэн гишүүн асуултаа асууна уу.

Ж.Чинбүрэн: Манай мэргэжлийн Байнгын хороо чухал асуудлууд хэлэлцэж байна аа. Ялангуяа Улсын Их Хурал дээрээс нь Байнгын хороо легтив шинж чанар буюу энэ залгамж халаа энэ өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэг энэ асуудлыг эргэж энэ хянах энэ тогтолцоо асар чухал. Тэгээд өнөөдөр бид энэ тайлан гээд аваад үзэж байна. Их Хурлын хянан шалгах газраас гаргасан тайлан дотор Засгийн газрын өгсөн үүрэг даалгавар, хуулийн хэрэгжилт, биелэлт бүүр манай Байнгын хорооны асуудалтай холбоотой ерөөсөө бүгдээрээ 0 байна аа. Энэ ерөөсөө л Их Хурлаас гарч байгаа тогтоол шийдвэрийг үл тоомсорлодог биелүүлдэггүй ийм байдал харагдаж байна шүү дээ. Тэгээд өнгөрсөн парламентад миний орж ажилласан,

өөрөө заримыг нь ахалсан энэ ажлуудын л өгсөн үүрэг даалгаврууд энд ерөөсөө бүгдээрээ биелээгүй л байж байх жишээтэй.

Жишээлэх юм бол би Одбаяр сайдаас асуумаар байгаа юм. Одоо Засгийн газарт Хяналт шалгалтын газар яагаад эрүүл мэндийн салбарын ерөнхий байцаагчийн тэр хөлдөөсөн шингэн оруулж ирсэн Баасантуяа гэдэг хүнийг томилоод байгаа юм бэ? Энийг та мэдэхгүй томилчхов уу эс үгүй бол энэ ямар шалгуур энэ тэр байдаггүй юм уу?

Хоёрт би зөвхөн Байнгын хорооноос гаргасан чиглэлийн биелэлтийн талаар л яримаар байгаа юм. В, Д вирустэй холбоотой Д вирусийн эмчилгээний асуудал дээр өнгөрсөн парламентын үед бид төсөв батлуулах гэж арай чүү гэж 1 нэг 10 тэрбум төгрөг тавьж байхад 6.7 тэрбумыг пиг интерфон авах гээд улайм цайм гүрийгээд сууж байсан. ХӨСҮТ нь 2012 онд пиг интерфон Монголд таарахгүй юм байна гээд дүгнэлт гаргачихсан байхад бүүр гөлийсөөр байгаад л оруулж ирээд л тэгээд харин бүүр АТГ энэ тэрт өгч байж нэг төсвийг болиулсан. Болиулсан гэсэн чинь 30 хувьд нь пиг интерфон аваад хадгалчихсан байж байгаа шүү дээ. Гаж нөлөөтэй үр дүнгүй юмыг авах гээд байдаг.

Энд ахмадын асуудал байна. Байнгын хорооноос чиглэл өгөх тухай 2022 оны 6 сарын 7. Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулъя, орыг нэмэгдүүлье гээд тэгж байхад ахмадуудаа хэвтүүлээд шаардлагагүй хэвтэлтээс хэрэггүй гээд нөгөө сайд нь улаан цайм ингээд яриад сууж байгаа. Бид энэ Байнгын хороогоороо бүр ийм чиглэл өгчихсөн байгаа шүү дээ. Тэгээд энэ тэрийг одоо хэрэгжүүлээд явах битгий хэл бүүр хууль даахгүй байна шүү дээ. Тэгэхлээр би бас Одбаяр сайдыг энэ дээр анхаараасай гэж бодож байна.

Дөнгөж ажлаа авчихсан хийж байгаа байх. Энэ хяналт шалгалтын ажил энэ өгсөн үүрэг даалгавар энэ чинь Их Хурлаас гарч байгаа юм болгон чинь л хууль гэсэн үг шүү дээ. Тэгээд зөв бурууг нь яриад л сууж байна шүү зарим салбарын сайд нар чинь. Энэ дээр онцгой анхаарч энэ биелэлт дээр анхаараач ээ. Бид энийг чинь олон талаас нь ярьж хэлэлцэж мэргэжлийн Байнгын хороогоороо гаргах гэж хэчнээн их цаг хугацаа зарцуулж байна гэж санана.

Л.Энхнасан: Одбаяр сайд хариулна уу. 4 дүгээр микрофон.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагч томилсон тухай асуудал дээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга тушаал шийдвэр гаргахдаа хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг нь холбогдох байгууллагуудаар нь хянаад хянуулаад шийдвэр гаргасан гэж ойлгож байна. Бодлого шийдвэрийн хэрэгжилтийн тухайд би бас буруу ойлгоогүй бол хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тайлангаа Засгийн газар анх удаа энэ мэргэжлийн Байнгын хороо тус бүрээр нь тайлангаа гаргаад хэлэлцүүлж тайлагнаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд байдаг энэ хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс Улсын Их Хурлын гишүүд тэр дундаа мэргэжлийн Байнгын хороодынх нь гишүүдтэйгээ цуг энэ эрхээ хамт хэрэгжүүлье ээ. Дотор талаас нь, гадна талаас нь 2 талаасаа хяналт тавьж салбарын яамдуудын салбарын сайд нарынхаа үйл ажиллагаанд 2 талаас нь

хяналт тавьж ажиллая гэдэг үүднээсээ энэ тайлангаа оруулж ирж хэлэлцүүлж байгаа юм аа.

Энд учиргүй амьдрал сайхан байгаа тухай учиргүй хуулийн хэрэгжилт сайн байгаа тухай ерөөсөө дурдаагүй. Бодит байгаа тоогоо, бодит байгаа тоонуудаа нийлүүлээд Байнгын хороо тус бүрээр нь орж ирээд танилцуулж байгаа юм. Тэгээд таны ярьж байгаа тэр эрүүл мэндийн салбартай холбоотой асуудал дээр ч гэсэн яг тодорхой кэйс жишээ юунууд дээр бид нарын хувьд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар тэр дундаа Хяналт үнэлгээний үндэсний хорооны хувьд энэ хуучин мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгасантай холбоотойгоор салбарын хяналтын чиг үүргийг одоо байгаа бүтэц дээрээ тулгуурлаад иргэдэд хувийн хэвшилд хүндрэл чирэгдэл багатай байхаар зохион байгуулахаар хичээж ажиллаж байгаа. Тэгээд энэ хуульд заагдсан эрх хэмжээнийхээ хүрээнд бас энэ саяын асуудлууд дээр таны онцгойлон сануулж байгаа асуултууд дээр хамтарч ажиллахад бэлэн байна гэдгээ хэлэх нь зүйтэй байх аа.

Л.Энхнасан: Тодруулгаа хийнэ үү.

Ж.Чинбүрэн: Бид ер нь их зөв зөв энэ дадлага руу орох гэж байна. Тэгэхлээр Засгийн газраас өөрийгөө хянадаг, ажиллаагүй болоогүй хэрэгжээгүй зүйлүүд дээр анхаардаг. Ялангуяа манай эрүүл мэндийн салбарт бид өнгөрсөн 4 жилийн хугацаанд асар том реформын шинж чанартай зүйлүүд хийсэн. Олон хуулиудыг баталсан. Тэр дотроо Эмнэлгийн тусламжийн тухай хууль хүртэл байж байна. Эмнэлгийн тусламжийн хууль дотор бол эмнэлгийн удирдлага нь ТУЗ-тэй байх гээд бүхэл бүтэн хуулийн заалт хэрэгжихгүй өдий хүртэл явж байгаа. Тийм ээ. Сая би хэлсэн. Би Байнгын хорооны өгсөн чиглэлийн тухай л сая ярьсан шүү. Энэний цаана ерөөсөө хэрэгжээгүй, биелээгүй маш олон зүйлүүд байж байгаа. Та бүхний энэ гарсан зүйл дээр би ингээд тэмдэглээд яахад бараг бүх хуудсан дээр цэнхэр болчихно. Дандаа нөгөө миний өөрийн ажилласан юмнууд байхгүй юу. Өөрийн ажилласан зүйлүүд байгаа.

Тийм учраас би маш сайн мэдэж байгаа.

Л.Энхнасан: Ганмаа гишүүн, Ганхүлэг гишүүн 2-ын төхөөрөмж нь ажиллаагүй байна нэмээд өгнө үү. Б.Бейсен гишүүн асуултаа асууна уу?

Б.Бейсен: Одбаяр сайд энэ ЭМЯ-ны Хяналт үнэлгээний газар энэ Төгсдэлгэр дарга 2-оос асуух асуулт байна. Энэ төсөв хэтрээд байна эмнэлгүүдийн. Нэлээн өртэй байна. Би өчигдөр хавдар суудал дээр очсон. 2, 1 дээр очлоо. Тэгэхээр энд нэг юм байна. Бид нар ЭМД-ын сангийн төсөв хүрэхгүй байна гээд яриад байдаг. Гэтэл орон нутагт болон хотод орон тоо хэтэрвэл нөгөө гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой орон тоог өөрсдөө мэддэг гэдгээр төсвөө зүй бус зарцуулж байгаа асуудал байгаа. Энийг шалгаж үзсэн үү, 1 дүгээрт.

Хоёрдугаарт ер нь эмнэлгийн бүтэц, орон тоог шинэчилж батлахгүй бол болохгүй юм байна. Жишээлбэл 150 ортой байна уу, 250, бараг 300 ортой эмнэлгүүдийн яг бүтэц орон тоогоор нь орон тоог нь баталж өгөхгүй бол энэ эмнэлгийн өрнөөс салах боломжгүй байна. Илүү авсан ажилчдын орон тоо, тэдний НДШ-д явчхаад байна.

Тэгэхээр энийг яаж шийдье гэж бодож байна. Тэр юун дээр ажиллаж байгаа юу? Гол нь ЭМШУИС, ЭМЯ, Нийгмийн бодлогын байнгын хороо хамтарч байгаад энийг шийдэхгүй бол ер нь цаашдаа бид нар өр зээлээс харах боломж муу байна. Энэ хөдөөд энэ орон тоог хэтрүүлэн ашиглаж байгаа юмнууд байна уу? 1 дүгээрт.

Хоёрдугаарт, энэ өр зээлтэй эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүд хэр байна. Өөрөө нууж байгаа байгууллагууд байна уу энэ талаар асууя, 1 дүгээрт.

Хоёрдугаарт хөнгөлөлттэй эмийн талаар Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын дарга Эрдэнэбаяр дарга уг нь АШУУИС-ийн удирдлагад ажиллаж байсан цусны төвийг ажиллаж байсан менежмент сайтай залуу гэж бодож байгаа. Энэ хөнгөлөлттэй эмийг хөдөөд ерөөсөө авч чадахгүй байгаа. Сум, багийн түвшинд. Яах вэ хотын төвд, аймгуудын төвд олон аптектай тэрүүгээрээ авдаг. Хөдөөд Булган сум гэхэд аймгийн төвөөс 317 км алслагдсан, хотоос 2 мянган км алслагдсан газар л даа. 10 ширхэг нэг трубка даралтны эм 28-аас 30 мянга болж байна шүү дээ. Энийг яаж шийдье гэж бодож байна? Ямар менежмент хэрэгжүүлье гэж бодож байна. Энэ дээр тодорхой асуулт асууя.

Л.Энхнасан: Одбаяр сайд хариулна уу?

Э.Одбаяр: Бейсен даргын асуултад хариулъя аа. Тэр эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн орон тоотой холбоотой асуудлыг энэний өмнө ярьсан нөгөө салбарын хяналтын асуудал нь, салбарын яамдууд шилжсэнтэй холбоотойгоор ЭМЯ-ны салбарын хяналтын холбогдох хүмүүс яамны албан тушаалтнууд танд тодорхой мэдээлэл өгөх байх. Ер нь тэр эмийн үнэ чанартай холбоотой асуудал бол одоо өнгөрсөн жилээс авхуулаад энэ Засгийн газрын хувьд нэлээн тийм чухал асуудал болж яригдаж байгаа. Энэ эмийн чанарыг сайжруулах эмийн орц найрлага ер нь стандарт гэдэг юм хангагдаж байна уу үгүй юу гэдэг дээр, эрүүл мэндийн сайд, салбарын сайд, шадар сайдуудын хэмжээнд энэ эмийн чанарыг сайжруулах нь зүйтэй гэдэг дээр ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Одоогийн нөхцөл байдлын талаар эмийн чанарын тухай асуудал дээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс дотоод хүний нөөцдөө тулгуурлаад менежментийнх нь хувьд шалгалтын ажлыг эхлүүлж байгаа. Тэгээд яг тэр мэргэжлийн жишээлэх юм бол химийн орц найрлага, тэр элдэв дээдийн юмнуудыг бол салбарын хяналтын хуучнаар байсан нөгөө мэргэжлийн хяналтын лаборатори, лавлагаа лаборатори гэж байсан тэр газар илүү мэргэжлийн дүгнэлт хийх байх.

Ер нь бид нар эрүүл мэндийн салбарт энэ олон улсын стандартыг нэн яаралтай нэвтрүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ болоод эмийн чанарт анхаарна гэдэг зорилт тавиад ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Мөнхсайхан сайд шаардлагатай бол бас нэмэлт тайлбар өгөх нь зүйтэй байх. Тодруулга.

Л.Энхнасан: Төгсдэлгэр ЭМЯ-ны ХШҮДАГ-ын дарга. 5 номер. Асуултад хариулна уу.

С.Төгсдэлгэр: Бейсен гишүүний асуултад хариулъя аа. Төсвийн хэтрэлттэй холбоотой асуудал бол Ковид 19 цар тахлын улмаас үүссэн өр төлбөр тухай бүр хэдийгээр тодорхой хэмжээгээр шийдвэрлэж ирж байсан ч гэсэн хуримтлагдсан. Тэр хуримтлагдсан өрний асуудал өнөөдрийг хүртэл ингээд бүрэн шийдэгдэхгүйн улмаас эрүүл мэндийн байгууллагууд бол өртэй гарах асуудал байсаар байна. Бүтэц орон тооны хувьд бол эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл

ажиллагааны стандартаар орон тооны доод хязгаарыг баталж байгаа. Гэхдээ манай салбарт 2020 оноос хойш хийгдэж байгаа гүйцэтгэлийн санхүүжилтийн реформын гол зорилго бол эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад өөрийн хүний нөөц, дотоод бусад нөөц бололцоогоо удирдах менежмент хийж орон тоогоо өөрсдөө шийдвэрлэх ийм боломжууд бүрэн нээгдсэн байгаа.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 5 дугаар микрофон. Стандартаар бол орон тооны доод жишгийг баталж байгаа. Эрүүл мэндийн байгууллагууд энэ доод жишгээсээ буулгахгүйгээр орон тооныхоо асуудлыг шийдвэрлэх асуудлууд нь бол байгууллагуудад нээлттэй байгаа. Гэхдээ харьяа байгууллагуудын болон өрх сумын ЭМТ-үүдийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэх үйл ажиллагаа яаман дээр хийгдэж байгаа. Тэгээд энэ дээр бол бас тодорхой хэмжээний зохицуулалтууд орно гэж хүлээж байгаа.

Эрдэнэбаяр 1 дүгээр микрофон.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая аа. Бейсен гишүүний асуултад хариулъя. Ер нь Монгол Улсад бүртгэлтэй одоогийн байдлаар 3899 эм яг өнөөдрийн байдлаар байгаа. Ер нь бүртгэлийн явц дээр зарим нь одоо бас ингээд бүртгэлийн хугацаа дуусдаг. Ингээд сунгах байдлаар бид нар явж байгаа. Яг улсын хэмжээнд 3422 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа юм. Энэ дээр ханган нийлүүлэх байгууллага бол 473 байгаагийн 333 нь яг эм ханган нийлүүлэх байгууллага байж байна. 33 үйлдвэр байгаа. Тэрний 24 нь бол эмийн үйлдвэр байна. 2916 эмийн сан байгаагийн 1162 нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа гэсэн ийм сүүлийн статистик тоон үзүүлэлтүүд байж байгаа.

Таны сая дурдаад байгаа энэ асуудлууд ер нь гардаг юм байна лээ. Тэгээд энэ дээр бид нар бас дотооддоо ярилцаж байгаа. Ер нь бодлогын хүрээнд ямар шийдлүүд гаргаж байгаа вэ гэхээр манай.

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу? 1 дүгээр микрофон. Одоо бид нар эмийн ер нь гаалиас, хил гаалиар орж ирэхээс өгсүүлээд эцсийн хэрэглэгч дээр бүр иргэдэд хүрэх хүртэлх энэ бүх үйл ажиллагааг хянах энэ Лайсмед гэж энэ цахим программыг хөгжүүлээд бид нар яг энэ тестийн шатан дээрээ явж байна. Энэ программ ашиглалтад орсноор бид нар яг аль аймгийн аль суманд ямар хэмжээний эмийн нөөц байна вэ? Ялангуяа зайлшгүй шаардлагатай эмийн нөөц хүрэлцээ ямар байна вэ гэдгийг хянадаг тогтолцоог ер нь энэ ондоо багтаагаад бүрэн хэрэгжүүлнэ гэж хэлэхээр байна. Тэгээд бид нар бол цаашдаа энэ дээр бодлогоор энэ эм ханган нийлүүлэх байгууллагуудыг илүү бас менежментийг нь зөв хийх, зохицуулах энэ ажлуудыг хийнэ гэдгээр ингэж зорьж ажиллаж байгаа.

Энх-Амгалан сайд үг хэлэх гэж байна уу? Тодруулга уу? Бейсен гишүүн.

Энэ эрүүл мэндийн яамнаас энэ хугацаанд ер нь хэчнээн удаа шалгалт хийсэн юм бол? Энэ бүтэц, орон тоо төсвийн хэтрэлттэй аймгуудын нэгдсэн эмнэлэг, хотын эмнэлгээр шалгалт хийсэн үү? 1 дүгээрт.

Хоёрдугаарт, ковидын өр мөр гээд яриад байна. Энэ ковидын би чинь түр хороонд ажилласан шүү дээ. Тухайн үед ЭМЯ-ны өгсөн тайланг би энэ дүнгийн

хурал дээр нь суусан. ЭМД-ын ерөнхий газар, ЭМЯ 2-ын эмнэлгийн тусламж үйлчилгээнд өгсөн тайлан дээр чинь 260 хэдэн тэрбумаар зөрчихсөн. Хамгаалах хэрэгсэл хувцас хунар гэх дээр чинь 71 аравны хэдэн тэрбумаар. Багцынх нь 09 тэрбумаар зөрсөн. Би тухайн үед энэ тайлангаа засаарай нэгтгээрэй гээд хэлсэн. Эрүүл мэндийн салбарын хүн учраас. Эрүүл мэндийн хувьд тухайн үед ковидод нэг хэсэг өр гарах нь гарсан л даа.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд асуулт асуух гэж байна уу? 5 номерын микрофоныг нээнэ үү.

С.Төгсдэлгэр: Үрийн тухайд бол мэдээж ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор хуримтлагдсан үр тодорхой хэмжээгээр явж байсан. Түүнээс гадна эдийн засгийн инфляц, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой ялангуяа эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлт бол нэлээн энэ үр хуримтлагдаад нөлөө үзүүлсэн. Энэ дээр бол харин аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад энэ төсвийн хяналт шалгалт хийх асуудлыг бол төсвийн ерөнхийлөн захирагч, Засаг дарга нартай байгуулсан гэрээний дагуу орон нутгийн аудитын байгууллагууд хийж гүйцэтгэж байгаа. Тэгээд эдгээр тайлан юмнууд, өгсөн зөвлөмж, албан шаардлага, акт, тавьсан акт энэ тэр бол хууль журмынхаа дагуу барагдуулалт нь явагдаж байгаа.

Л.Энхнасан: Тодруулна уу Бейсен гишүүн?

Б.Бейсен: Тэгэхээр ийм байгаа. Аймгуудын тэр аудитын газарт найдаад хэрэггүй. Ер нь ЭМЯ дээрээс нь сайн мэргэжлийн өндөр хяналт хийхгүй бол энэ төсвийн бид нарын алдагдал тэр чигээрээ явна. Хуучин яамны групп шалгалтад очдог байсан. Энийг хэрэгжүүлэх тал дээр баримталж байгаа бодлого байна уу? Төлөвлөгөө байна уу? Ер нь ажлын хэсгээс хэн хариулах юм? 5 дугаар микрофон.

С.Төгсдэлгэр: ЭМЯ-ан дээр санхүүгийн байцаагч 2 хүн байдаг. Тэгэхээр 2 орон тоогоороо бол зөвхөн харьяа байгууллагуудынхаа санхүүгийн хяналт шалгалтыг хийхэд хүрэхтэй үгүйтэй нөхцөл байдал байгаа учраас аймаг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн хяналт шалгалтыг бол орон нутгийн аудитын байгууллагаар хийлгэхээс өөр сонголт ховор байгаа. Гэхдээ манай санхүү эдийн Засгийн газраас бол Байнгын төсвийн нөгөө сар, улирлын хуваарь.

Л.Энхнасан: Энх-Амгалан сайд. Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу?

М.Ганхүлэг: Одбаяр сайдтай анх удаа бас яг энэ Байнгын хорооны асуудлаар уулзаж байгаа болохоор ер нь манайх одоо хяналтын чиг үүрэг бүхий сайдтай болоод Үндэсний хороотой болоод ингээд явж байна аа. Тэгээд ингээд тухайлаад Байнгын хорооныхоо асуудал руу ингээд ороод тэрэн дээрээ дүгнэлт хийгээд ингээд явах ийм агуулгууд явж байна уу эс үгүй бол тогтолцооны хувьд энэ хяналт хэрэгжүүлэхтэй холбогдолтой асуудал дээр ер нь яг ямар бодлого юмнуудыг барьж байгаа вэ гэдэг ерөнхий асуултыг би тавьж ер нь мэдээлэл авъя гэж бодож байгаа юм. Танай үндэсний хорооны хувьд одоо хэчнээн бүрэлдэхүүнтэй яаж үндсэндээ ажиллаж явах юм гээд. Ингээд детальчлаад бүх асуудлыг ингээд ярих юм бол ер нь Засгийн газрын түвшинд Их Хурлаас гарч байгаа энэ хууль энэ тогтоолыг хэрэгжилтүүд үнэхээрийн хангалтгүй байгаа гэдгийг бид бүхэн хаа хаанаа мэдэж байгаа.

Гэхдээ энийг хэрэгжилтийг хийж байгаа, дүгнэж байгаа тэр шалгуур үзүүлэлтийн асуудлыг Их Хурлын гишүүд нэлээн дүгнээд байгаа. Тэгээд үүнтэй холбогдолтой ямар байр суурьтай ямар өөрчлөлт шинэчлэлт хийх асуудлаа ер нь цогцоор нь яаж хараад бусдын болон хүний хүчин зүйлээс хамааралгүйгээр дүгнэдэг байх асуудал нь ямар байх юм бэ гээд эхний асуулт байгаа.

2 дахь үндсэн асуудал нь одоо ингээд 481 заалт бүхий 69 буюу 14.3 хувь нь хэрэгжээгүй орж ирж байна тийм ээ. Ингээд огт хэрэгжээгүй 84 тогтоол энэ тэр гээд зөвхөн ингээд манай Байнгын хороотой холбогдолтой асуудлууд ингээд гарч ирж байна. Нэлээн олон жилийн хугацааны асуудлууд дээр дүгнэлт хийсэн байх шиг байна. Тэгээд одоо яг энэ дээр ямар хариуцлага тооцох юм. Тэр тодорхой тооцох гэж байгаа эрх зүйн боломж бололцоо нь танд ер нь байгаа юм уу? Энийгээ нэг талдаа засаж сайжруулах талаасаа хариуцлагаа үүрүүлээд ингээд явах талаасаа танд ямар хэмжээний эрх мэдэл олгочихсон ийм байдалтай байх юм бэ гэдэг зүйлийг эхний агуулгын хүрээнд бид нар сайн ойлголцох хэрэгтэй байна аа. Мөн дээрээс нь Их Хурлын даргын захирамжаар энэ 800, 900-аад энэ хуулийн үндсэндээ хэрэгжилт дундаас хамгийн нэн шаардлагатай байгаа нэг 80 гаруй хуулийн хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай бол шинэ хуулийн төслийг өргөн барих ажлын хэсгүүд байгуулагдсан байгаа.

Ингээд гишүүд бүгдээрээ л нэг ажлын хэсэг ахлаад л янз янзын байдалтай ажиллаад л ингээд л явж байгаа. Тэгэхээр эдгээр ер нь ажлын хэсгүүд л ялгаагүй чиг үүрэгтэй санагдаад байгаа юм. Ер нь хуулийн хэрэгжилт нь ямар байгаа юм, яаж явж байгаа юм бэ гэдэг дээр энэн дээр Үндэсний хороо зөвлөмж өгөх, хамтран ажиллах тодорхой саяын ярьсан энэ агуулгын хүрээнд тэр нэг талдаа чиглүүлэх, нөгөө талдаа хэрэгжээгүй бол тэрэн дээр нь яаж ажиллах вэ энэ тэр гэдэг ийм уялдаа холбоо юмнууд байна уу? Цаашдаа ингээд Байнгын хороо болгоноор гарсан тогтоолуудыг ингэж детальчлаад ингээд явах юм уу? Явбал ямар хариуцлага тооцох юм? Ер нь агуулгаараа бид бүхэн яаж явах юм бэ гэдэг нэг ийм ойлгомжгүй ийм байдлууд үүний цаана байгаад байна аа.

Тэгэхээр энэ дээр та яг өөрийн нэг байр сууриа хэлээч. Тэгээд шаардлагатай бол тодруулья.

Л.Энхнасан: Одбаяр сайд хариулна уу.

Э.Одбаяр: Ганхүлэг гишүүнд баярлалаа.

Нэлээн ажил хэрэгч асуудал хөндлөө. Тэгээд бас нөгөө шинэ тутам сая энэ Засгийн газарт шинэ бүтцээр бий болсон үндэсний хороо учраас ойлголт бас нэмэлт мэдээлэл хэрэгтэй байх. Энэ үндэсний хорооны бүрэлдэхүүнд нь салбарын сайд нар, шаардлагатай бол Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар буюу өөрөөр хэлбэл төсвийн захирагч нар нь ороод явдаг. Тэгээд энэ үндэсний хороон дээрээ бол яах вэ гэхээр түрүүний хэлдэг нөгөө салбарын хяналтуудын уялдааг хангаж давхардлыг бууруулах чиглэлээр мэргэжлийн хяналтын ажиллаж байсан орон зайг нөхөх зорилгоор орон тооны бус бүтцээр ажилладаг. Энэ ажлынхаа хүрээнд бид нар төлөвлөгөөт хяналт шалгалтуудын давхардлыг манипуляц хийж давхардал цаг хугацааны хувьд, шалгалтын удирдамжийн хувьд агуулга нь давхцаж байгаа эсэхээс шалтгаалаад 30 орчим хувьтай байсан давхардлыг ямар ч байсан 1 оронтой тоо руу оруулж төлөвлөгөөт хяналт шалгалтыг багасгаж чадсан байгаа.

Нийтдээ нэг бүх салбарын яамдуудын хэмжээнд нэг 15 мянга орчим объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байсан энэ онд. Засгийн газрын дотоод хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар бол 2022 оны 9 сард батлагдсан Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн дагуу 2023 оны 1 сарын 1-ээс эхлээд үйл ажиллагаа хэрэгжүүлж явж байгаа. Үндсэн хуулийн боломжийн хувьд бид нар төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн ЗДТГ гадаад болон дотоодын эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд Засгийн газрын зүгээс хэрэгжүүлэх дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Хяналтыг хэрэгжүүлэхдээ яах вэ гэхээр тус газарт ажиллаж байгаа хянан шалгагч нар маань хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд акт шаардлага тавьж ажиллах тийм хуулийн боломжтой ийм бүтэц байгаа.

Энэ тайлан мэдээ оруулж ирж байгаа асуудлын хувьд эргэх холбоо гэдэг зүйлийг та Их Хурлын гишүүний хувьд ярьдаг. Тэгэхээр Засгийн газар, Их Хурал хоорондоо эргэх холбоотой байя. Тайлан мэдээгээ жил бүр хэлэлцдэг холбогдох Байнгын хороод дээрээ салбарын яамдууд нь тайлангаа оруулж ирээд оруулахын өмнө Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээний хэлтэс, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар өөрсдийнхөө үнэлгээг хийгээд үнэлсэн, үнэлүүлсэн хүмүүс нь хамт сууж байгаад мэргэжлийн Байнгын хороондоо тайлагнадаг. Асуудал явахгүй байгаа ч гэдэг юм уу удааширсан байгаа салбарууд дээр дотооддоо кабинет дотроо хариуцлагын асуудлаа ярья. Төрийн албан хаагчдын хувьд саяын тэр Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн дагуу, Төрийн албаны тухай хуулийн дагуу бас асуудлуудаа ярья. Асуудал байвал шийдээд явъя. Ажлаа эрчимжүүлэхийн тулд мэргэжлийн Байнгын хороодтойгоо илүү ойрхон хамтарч ажиллая л гэдэг санал санаачилга хуулийн хүрээнд гараад явж байгаа л гэж ойлгож байна.

Л.Энхнасан: Тодруулах уу? Ганхүлэг гишүүн асууна.

М.Ганхүлэг: Саяын өгсөн чиглэлийн дагуу Их Хурлын гишүүд Байнгын хороодын явж байгаа энэ ажлуудтайгаа та аль болох уялдуулах чиглэлээс нь ажиллах хэрэгтэй байна аа. Тэгээд яг үндсэндээ Үндэсний хорооны яг явж байгаа энэ ажил үйл ажиллагаануудыг гишүүд болон бид нарын хувьд ч гэсэндээ төсөөлөлгүй байгаад байна л даа. Тэгэхээр хяналт шалгалтын энэ процессын энэ үр дүнд гарсан энэ үр дүнг тэр хариуцлага тооцох, түүнтэй холбогдолтой хариу арга хэмжээ авах энэ байдлууд нь маш ойлгомжтой тодорхой байж байж олон нийт тэндээс тодорхой хүмүүст нь хариуцлага тооцоод ингээд явж байж үндсэндээ энэ асуудлууд шийдэгдэнэ ээ. Тэгэхгүйгээр бид нар ингээд яг тухайлаад Байнгын хороо болгоноор нь асуудлаа яриад яриад гүйцэгдэхгүй байх гэж бодож байна. Ер нь маш их асуудал. Бид бүхний дунд тэгэхээр системийн хувьд энэ бүх процессууд нь ил тод болгох энэн дээр тал талаасаа хамтран ажиллах чиглэлийн энэ агуулга дээрээ Үндэсний хороо сайд маань нэлээн гол анхаарлаа хандуулаад ажиллах чиглэл рүүгээ та яг үндсэн гол одоо.

Л.Энхнасан: Ганмаа гишүүн асуултаа асууна. Хариулах уу? 4 дүгээр микрофон Одбаяр.

Э.Одбаяр: Ганхуяг гишүүний асуултад гүйцээгээд хариулчихъя.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд дээр тухайлах юм бол Лувсанжамц гишүүнээр ахлуулсан үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох ажлын хэсэг, Энхтүвшин гишүүнээр ахлуулсан хяналт шалгалтын чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хэсэг, Анар гишүүнээр ахлуулсан процессын дахин инженерчлэлийн асуудлыг боловсронгуй болгох энэ ажлын хэсгүүдтэйгээ Их Хурлын гишүүдийнхээ тэр мэргэжлийн чиглэлийн байгуулагдсан ажлын хэсгүүдтэй Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар болоод Хяналт үнэлгээний үндэсний хорооны зүгээс хамтарч ажиллаад Их Хурал руу өргөн барих хууль тогтоомжийн төслүүд дээрээ бодолгоо нэгтгээд олон улсын үнэлгээний цогц систем буюу DM-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Их Хурал Засгийн газрын хэмжээнд ойлголтоо нэгтгээд Их Хурлынхаа гишүүдийн манлайллын авч, хамтарч ажиллах санал гаргаад ажиллаад хамтраад явж байгаа гэдгээ хэлье ээ. Баярлалаа.

Л.Энхнасан: Ганмаа гишүүн асуултаа асууна аа.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Мэдээлэл танилцуулж байгаа ажлын хэсгийнхэнд баярлалаа. Маш товчхон л 2 асуулт. Тэгээд 1 санал хэлье. Энэ салбар дундын үйл ажиллагааг тайлагнаагүй гэсэн юм ихэвчлэн гарч ирээд байна. Энэ танилцуулга дээр. Мэргэжлийн хяналтыг санагалзсан асуудлууд их гардаг. Тэгэхдээ мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг явуулж байхад харж байхад байцаагч тус бүрдээ салбар тус бүр дээр яг шийдэгдчихсэн сургагдчихсан мэдчихсэн хүмүүс нь их ховортой. Тэгэхээр дунд нь их ерөнхийлсөн юмнууд мэдээ мэдээлэл нэгтгэсэн дүгнэлтүүд гаргадаг. Тэрнээсээ болоод ур чадвар их тааруухан байсан. Энэнтэй холбоотой энэ Одбаяр сайдын яг салбар дундын үйл ажиллагааг жишээлбэл тайлагнаагүй тохиолдолд энэ уялдааг нь хангуулахын тулд нийгэм, эрүүл мэнд ч юм уу, боловсрол ч юм уу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч юм уу эдгээр дээр ямар байдлаар яг процедурын хувьд үйл ажиллагаагаа явуулж яаж энэ дүгнэх асуудлыг шийдэж байгаа вэ гэдэг асууд л 1 дүгээрт байна. Энэ процедурыг нэлээн детальтай тайлбарлаад өгвөл их сайн байна. Тэгээд саналаа асуултын дараа.

Л.Энхнасан: Одбаяр сайд хариулна уу? 4 дүгээр микрофон.

Э.Одбаяр: Ганмаа гишүүний асуултад хариулъя аа. Юуны хувьд процедурын хувьд тайлан мэдээ боловсруулах, үнэлэх, хяналт шинжилгээ хийх процесс нь бүтнээрээ нэг журмаар зохицуулагддаг байсан юм. Саяын энэ 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан урт нэртэй хууль гэдэг шиг урт нэртэй журмаар. Тэгээд энийг ажил авснаас хойш өнгөрсөн хугацаанд 3 журам болгож салгаад манай Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс тайлагнах, үнэлэх, хяналт шинжилгээ хийх гээд процессын хувьд 3 салгаад энэ журам маань Засгийн газраас батлагдаад 5 сарын 1-ээс эхлээд хэрэгжиж эхлээд явж байгаа. Тэгэхээр саяын ялангуяа таны дурддаг тэр салбар дундын асуудлуудыг тайлагнахдаа салбарын яамдуудаас тайлан, мэдээ ирүүлэх, холбогдох төрийн албан хаагчтай холбоотой хариуцлага эргэх холбооны асуудлыг тэр журмаар нэлээн нарийвчилж зохицуулсан.

Дээрээс нь бид нарын хувьд нөгөө Төрийн албаны тухай хуулийн дагуу нэг удаа, 2 удаа тайлангаа хугацаандаа ирүүлээгүй яагаагүй бол ирүүлээгүй тайлагнаагүй бол нөгөө сахилгын арга хэмжээ гэдэг тэр нийтлэг заалтууд маань явж байгаа. Процессыг бид нар нөгөө арга хэмжээ авна, шийтгэнэ гэхээсээ илүүтэйгээр процессыг боловсронгуй болгохын төлөө бас холбогдох тэр журмуудаа саяын

хэлдгээр нарийвчлаад 3 нарийвчилсан журам болгоод батлуулаад явж байгаа гэдгээ танд хэлэх гэж байна.

Л.Энхнасан: Ганмаа гишүүн тодруулна уу?

Д.Ганмаа: Тодруулах уу? Саналаа хэлчихдэг юм уу? Энэ эрүүл мэндийн салбарын оруулсан хэд хэдэн 3 ажлын тайлан байх ёстой байсан юм байна. Нэг нь ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ЭМЯ-ны хамтын ажиллагааг тэгээд салбар дундын үйл ажиллагаа тайлагнаагүй. Дараачийнх нь хүчирхийлэлд өртөж болзошгүй үнэлгээг боловсруулах мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол ЭМЯ-ны сайдын. Энэ дээр мөн л 3 байгууллага заалтын хүрээнд хамаарах ажил нь хэрэгжүүлээгүй, тайлагнаагүй.

Гурав дахь нь Архи, тамхи согтууруулах ундаатай холбоотой ажил мөн тайлагнаагүй хэрэгжүүлээгүй гээд явчихсан. Тэгэхээр зүгээр яах вэ миний санал бол бид нар нэгэнт ингээд мэргэжлийн Байнгын хороо учраас эдгээр асуудлуудыг хэлэлцэхийн тулд хугацааг нь хойшлуулбал яасан юм бэ гэсэн санал оруулж байна. Ер нь энэ дүн шинжилгээний тайланг оруулж ирдэг болсон нь бол маш чухал. Харин харамсалтай нь энэ тайланг харахад биелэлтийг тайлагнасан 75 хуулийн 269 хэсэг заалтын биелэлт нь бол 58-хан хувь байна. Биелэлтийг тайлагнаагүй 145 хуулийн 148 хэсэг, заалтыг хэрэгжээгүй гэж тооцвол 30 хувь болж байна, 20 хувь болж байна.

Тэгэхээр энэ Одбаяр сайдаас асуух гээд байгаа юм л даа. Энэ биелэлтийг тайлагнаагүй шалтгаан нь юу байна. Энд хэдэн удаа тайлангаа явуул гэсэн тийм шаардлага тавьсан юм. Ер нь бол тайлангаа тайлагнаагүй тайланг авсны дараа энийг хэлэлцүүлбэл илүү ажил хэрэгч болох юм болов уу гэж бодож байна.

Харин тийм. Яг үнэн энэ тайланг тайлагнасан, ирүүлсэн энэ байдлын тайлан нь бол маш их. Ингээд удааширсан болон тасарсан заалтууд зөндөө их байна. Тэгээд удаа дараа тайлан ч ирүүлж байгаа ч тэгээд баталсан журмын мөрдөлд хангалтгүй байгаа. Хууль тогтоомжийн хэрэгжилт нь бол хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг сайжруулах, хариуцуулах шаардлагатай байна гэсэн байна.

Тэгэхээр энэ тайлагнаагүй байгаа тайланг ирүүлж энэ тайланг 7 хоногоор байх уу 2 долоо хоногоор хойшлуулъя. Тэгвэл Ганмаа гишүүний саналаар горимын саналаар ажлын тайлангийн хугацааг хойшлуулъя гэсэн санал хураалт явуулъя.

Тайлагналтыг нь авъя л даа энэ чинь тайлангаа ирүүлээгүй байна шүү дээ. Хураачихъя тиймээ. Санал хураалт хийчихье.

Санал хураалт.

2024 оны Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн энэ биелэлтийг тайлагнаагүй байгаа. Хэрэгжилт хангалтгүй байгаа энэ заалт энэ хэсгүүдийг дахиж тайлангуудыг нь авч ирүүлнэ үү Байнгын хороод.

Өнөөдөр бол зүгээр хэлэлцээд дуусах юм яах вэ. Дараа нь тогтоол тэгэхлээрээ харин энэ дээр бид нар улам тайлагнаагүй тайланг, биелэлтүүдийг нь авч байж дахиж хэлэлцсэн нь зүйтэй юм уу гэсэн бодолтой байсан юм.

Одбаяр сайд тайлбар хэлнэ үү.

Э.Одбаяр: Энэ ойлголтын зөрөө гэдэг юм уу, яах вэ нэг талаасаа хэдүүлээ ингээд Улсын Их Хурлын гишүүд маань энэ тайлан мэдээтэй холбоотой асуудал дээр ингээд ажил хэрэгч саналууд гаргаад ялангуяа энэ мэргэжлийн Байнгын хороод дээрээ салбарын яамдуудынхаа тайланг ингээд нарийвчлаад авч үзэж явъя гэдэг санаачилга гаргаж байгааг би дэмжиж байгаа юм. Одоо хэдүүлээ нөгөө асуудал, нөгөө ужиг асуудал байх юм бол хол явчихаас нь өмнө засаад чиглүүлээд явъя гэдэг дээр. Гэхдээ энэ дээр процессын хувьд зөрөөтэй ойлголт яваад байна. Тайлагнаагүй гэсэн асуудал ерөөсөө байхгүй. 2 сарын 28 байна уу? 19-ний өдөр Улсын Их Хурлын Тамгын газар Засгийн газрын зүгээс Хэрэг эрхлэх газрын даргын гарын үсэгтэй тайлангаа бүгдээрэнг нь албан ёсоор ирүүлчихсэн байгаа. Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар өөрийн дотоодын хяналт, шинжилгээ үнэлгээнийхээ нэгжээр дүн шинжилгээ хийлгээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод гишүүдэд тарааж өгөөд тэр тайланг хойноос нь бид нар Засгийн газрын зүгээс дотоод үнэлгээгээ хийгээд та бүхэнд танилцуулж байгаа. Ирэх жилээс одоо энэ тайлан танилцуулах энэ процессыг дэгийн хувьд яаж явуулбал илүү ажил хэрэгч байна вэ гэдэг дээр ТББХ болоод бусад мэргэжлийн Байнгын хороотойгоо энэ тайлан хэлэлцүүлэх процессын хувьд Засгийн газрын зүгээс хамтарч ажиллах хэрэгтэй юм байна гэдэг ойлголт авч байна. Ер нь бол хуучин бол зүгээр тайлан хүргүүлээд явчихдаг байсныг нь хэлэлцүүлээд Байнгын хорооны гишүүддээ танилцуулга тавиад ингээд явж байгаа юм аа. Одоо энэ дээр дараа жилээс хэдүүлээ тайлангаа яаж илүү ажил хэрэгч байдлаар хэлэлцэх вэ гэдэг дээр наана нь салбарын сайд нар бид нарын хийж байгаа ажил маань 1 дүгээрт кабинет дотроо Ерөнхий сайдад дүгнэгдэнэ.

Нөгөө талаас мэргэжлийн Байнгын хороон дээрээ орж дүгнэгдэж байгаа шүү гэдэг дээр дотооддоо ч гэсэн бас кабинет дотроо дүгнэлт хийгээд явах нь зөв байх. Манай энэ хяналтын чиг үүрэгтэй газар Хяналт үнэлгээний үндэсний хорооны хувьд бол энэ тайлан мэдээнүүдийг яг байгаагаар нь холбогдох журмын дагуу үнэлээд л та бүхэнд танилцуулж байгаа. Тэгээд яг процессын талаар дэлгэрэнгүй тайлбарыг Өнөрбаяр дарга бас тодруулах нь зүйтэй байх гэж ойлгож байна.

Л.Энхнасан: Гуравдугаар микрофон Өнөрбаяр дарга.

Ч.Өнөрбаяр: Байнгын хорооны дарга гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ бол яг процессын хувьд урьд нь бол Засгийн газарт манай Хяналт хэрэгжүүлэх газар тайлан хүргүүлдэг. Тэгээд тайлан бол системээрээ яамд тайлангаа ирүүлээд бид нар тэр нотлох баримт дээр нь суурилад сайдын түрүүний хэлдэг 2020 оны 206 дугаар журмын дагуу үнэлдэг юм аа. Ингээд Засгийн газрын хуралдаанд танилцуулаад ЗГХЭГ-аас Учрал сайд гарын үсгээ Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн 2 сард.

Тэгэхээр тайлан бүүр зүгээр ингээд дуусчихдаг байсан энэ процесс. Энэ жилээс бол яах вэ тэгээд энэ тайлан дээр нь Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийх ёстой байдаг. Энэ дүн шинжилгээ хийх журам нь хараахан батлагдаагүй байгаа юм байна лээ. Их Хур Хурлын дарга батлах хуультай. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар бол тэгээд ингээд явж байгаа. Энэ анх удаагаа ямар ч байсан нэг зөв жишиг нь бол ямар ч байсан Засгийн газар үнэлсэн тайлангаа Их Хурлын Байнгын хороодтой танилцуулдаг байя бас энэ Монгол Улс парламентын засаглалтай учраас гаргасан шийдвэрийнх нь биелэлтийнх нь бодит

байдлыг үнэлээд дараагийн удаа энийг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгөөд явдаг байя гэсэн ийм байдлаар явж байгаа шүү гэдгийг хэлье.

Тэгэхээр эндээс ямар нэгэн тогтоол бол Булгантуяа дарга аа гарахгүй юм аа. Үндсэн байнгын хороо нь Төрийн байгуулалтын байнгын хороо. Байнгын хороонд бол мэдээллийг сонсоод Төрийн байгуулалтын байнгын хороо түрүүлээд эцэслэн хуралдаад энэний дагуу яах вэ гэдэг тогтоол гаргах ийм хуультай шүү. Дарга, гишүүд ээ. Баярлалаа.

Л.Энхнасан: Тэгэхлээр энэ тохиолдолд сонсчихоод тэгээд явах юм байна тиймээ. Ер нь бол манайх ялангуяа манай Байнгын хороотой холбоотой салбарын нөгөө биелэлтүүд тун хангалтгүй байгаа учраас харин энэ дээр яагаад биелэлтүүд нь тэгвэл хангалтгүй байна гэсэн тайлбар эс үгүй бол шалтгаануудыг нь авах юм уу? Тэгж байж дараачийн Байнгын хороо руугаа саналаа явуулахгүй бол энэ чинь яг хоосон ямар ч саналгүй Байнгын хороо руугаа явах гэж байна шүү.

Л.Энхнасан: Гишүүд асуулт асууж дууслаа.

Ингээд тайлантайгаа холбоотой тайлан 2 яам нөгөө тайлагнаагүй болон яагаад тасалдаж байгаа талаар шалтгаануудыг нь явуулаад тэгээд Байнгын хороондоо бичгээр ирүүлнэ үү. Өнөөдөр ингээд тайланг хэлэлцээд дууслаа.

17.28 цагт

Дахиад нэг асуудал байгаа шүү дээ. Хүний эрхийн комиссын тайлан Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тайланг сонсоно.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл санал, дүгнэлтээ ХЗБХ-нд хүргүүлэх юм байна. Манай Байнгын хороогоор бол 4 дүгээр бүлэгт заасан цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл, мөн 5 дугаар бүлгийн эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийн эрхийн зарим асуудал гэсэн бүлгүүдийг бол санал, дүгнэлтийг сонсох юм байна. Энэ чинь биш биз дээ. Ажлын хэсэг шүү дээ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хунан ХЭҮК-ын гишүүн, Мөнхзул ХЭҮК-ын гишүүн, Э.Мөнхзул ХЭҮК-ын хүний эрхийн боловсрол хариуцсан ахлах референт, Мөнхтулга ХЭҮК-ын Төсөл хөтөлбөр, дотоод хамтын ажиллагаа хариуцсан референт, Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга, Рэгзэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга, Гэрэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, Ойнбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хамгааллын ерөнхий газрын Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Гантуяа Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга, Пүрэвжаргал ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын шинжээч, Анхболд СЭМҮТ-ийн захирал, Отгонбаяр ЭХЭМҮТ-ийн захирал, Оролзодмаа Нийгмийн эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний хэлтсийн дарга, Отгонгэрэл Хүүхдийн тусламжийн 108 утасны

захирал, Отгонцэцэг 108-ын дэргэдэх хүүхдийн түр хамгаалах байрны дарга, Дөлгөөн Жендерийн үндэсний хорооны мэргэжилтэн, Энхбаяр Жендерийн үндэсний хорооны дарга.

Эдгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна аа.

Монгол Улсын ХЭҮК-ын гишүүн Мөнхзул, Хунан нар танилцуулга хийнэ ээ.

3 дугаар микрофоныг нээнэ үү?

Ж.Хунан: Эрхэм Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье ээ.

ХЭҮК-ын 24 дэх илтгэлийн 5 дугаар бүлэг буюу Эрүүгийн хэрэг хянан шийдэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудлыг Улсын Их Хуралд ХЭҮК-оос санал зөвлөмжийг танилцуулсан байгаа. Үүнийг дэлгэрэнгүй та бүхэнд танилцуулъя.

Улсын Улсын Их Хурал Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хэлэлцсэн. Энэ хүрээнд ХЭҮК-оос дараах саналыг танилцуулж байна.

Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулахаар нэгд насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан дэлгэрэнгүй хийх, судалгааны үр дүнг үндэслэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг шинэчлэх гэдэг эхний саналыг бол танилцуулж байна.

Хоёрт нь бол энэ пидофил буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж таашаал авдаг гаж зан үйлийн эмгэгтэй гэмт хэрэгт холбогдогчид сэтгэцийн шинжилгээ хийх журам, энэ төрлийн эмгэгийг оношлох, эмчлэх, эмгэгтэй хүнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Гуравт нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалсан дахин хохирохоос урьдчилан сэргийлсэн тусгай журмыг ЭХХШТХ-д тусгайлан бий болгох.

Дөрөвт нь насанд хүрээгүй болон бага насны хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг мэргэжлийн бэлтгэгдсэн сэтгэл зүйч, эсвэл нийгмийн ажилтнаар ярилцлага хийлгэх замаар дагнан нэг удаа чанартай шуурхай явуулж, үүнийг дуу дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцох хуулийн зохицуулалтыг бий болгох.

Тавд нь хүүхдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн газраас өөр, тайван, хүүхдэд аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орчинд авах зохицуулалтыг хийх.

Зургаад нь ЭХХШТХ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалтыг сэргээх.

7-д нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд учирсан хохирлыг заавал тодорхойлж тогтоох. Тэр дундаа нөхөн сэргээх сэтгэл заслын зардлыг хэргийн хамт шийдвэрлэдэг болох, хохирлыг эхний ээлжид төрөөс гаргаж төр гэм буруутай этгээдээс дараа нь гаргуулдаг байх зохицуулалтыг хийх. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Хүүхэд хамгааллын тогтолцооны хамтарсан баг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын оролцоог нэмэгдүүлэх.

Сүүлд нь насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт гагцхүү мэргэшсэн тусгайлан бэлтгэсэн хууль, ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, мөрдөгч, прокурор, шүүгчийг оролцуулдаг байх. Ийм санал зөвлөмжийг гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан болно.

Санал зөвлөмжтэй холбоотой асуулт байвал хариулахад бэлэн байна. Танилцуулж дууслаа.

Л.Энхнасан: Мөнхзул Танилцуулах уу? Мөнхзулын танилцуулгыг сонсож байгаад асуултаа асууя. 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн асуудлаар ХЭҮК мөн илтгэлээ танилцуулсан байгаа. Энэ дээр энэ цахим хөгжлийн сүүдэртэй нэг тал нь бол цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл болж байгаа. Тэгэхээр энэ сүүлийн жилүүдэд ялангуяа энэ технологио дагаад энэ гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл хүн худалдаалах гэмт хэрэг гээд энэ жендерт суурилсан хүчирхийллийн арга хэлбэрүүд улам нарийсаж, цахим орчинд ялангуяа охид эмэгтэйчүүдийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Тэгэхээр дэлхийн улс орнууд НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс бол улс орнуудыг энэ чиглэлээр хууль тогтоомжоо өөрчлөх, энэ цахим хүчирхийлэл, дарамтад өртөж байгаа асуудал дээр хариу арга хэмжээ авах, тогтолцоогоо бэхжүүлэх, энэ хохирогчийн сэтгэл санааны хохирол хохирогчид чиглэсэн тусламж үйлчилгээг сайжруулахыг бол уриалж байгаа. Тэгэхээр энэ яг ийм шинэ нөхцөлд Монгол Улсын Эрүүгийн хууль болон энэ Зөрчлийн тухай хууль энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд хэр бэлэн байна. Гэмт хэргийг мөрдөн шалгах хохирогчийг хамгаалах зөрчигдсөн эрхийг сэргээх тогтолцоо байна уу үгүй юу гэдэг дээр энэ ХЭҮК-ын энэ удаагийн илтгэл чиглэсэн чиглэсэн байгаа.

Ингээд бид нар ер нь энд би түрүүнд хэлсэн. Энэ Монгол Улсад төдийгүй дэлхий дахинаа энэ цахим технологийн хөгжлөө дагаад энэ охид эмэгтэйчүүд хүүхдийн энэ цахим орон зай дахь аюултай байдал улам дэвэргэх энэ нэг талбар болж байгаа. Тэгэхээр бол энэ дэлхийн 145 улсад хийсэн ингээд судалгаанаас үзэхэд бол цахим орчны хүчирхийлэлд эмэгтэйчүүдийн 38 хувь нь өртөж байна гэж ийм тооцоолол байгаа. Ийм учраас НҮБ-аас хүний эрхийн байгууллагуудаас энэ асуудалд онцгойлон анхаарал хандуулахыг улс орны төр засгууд зөвлөөд байна аа. Монгол Улсын хувьд ч гэсэн нөхцөл байдал анхаарал татаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Цахим хэрэглээ ялангуяа хүүхэд залуучуудын дунд маш их тэгээд хяналт сул байгаагаас энэ цахим гэмт хэргийн хохирогч болох жендерт суурилсан хүчирхийллийн хохирогч болох асуудлууд нэлээдгүй байна аа.

Хамгийн сүүлд л гэхэд энэ НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс Монгол залуучуудын дунд цахим орчны дарамт энэ судалгаанаас харахад бол энэ судалгаанд оролцогч хүүхдүүдийн 51.3 нь энэ цахим орчинд гүтгэлэг гүтгэлэг, доромжлолд өртөж цахим дээрэлхэлтэд өртөж байна гэсэн ийм судалгаа гарсан байна аа.

Тэгэхээр энэ хүрээнд манай хууль эрх зүйн орчин ямар байна вэ гэдэг дээр ХЭҮК бас энэхүү илтгэлээрээ дүгнэлт хийсэн байгаа. Олон улсад жендерт суурилсан хүчирхийллийн 30 гаруй ийм шинэ нэр томъёог ашиглагдаж байна. Энэ нэр томъёонуудыг ингээд хараад үзэхэд бол Монгол Улсын хуульд тусгагдсан ч асуудал байна. Огт тусгалдаагүй ч асуудлууд байна. Тусгагдсан ч бүрхэг байдлаар тусгагдсан ийм зүйлүүд бол байна аа. Тухайлбал онлайн груминг гээд энэ хүүхдийг бэлгийн сэдлээр хүүхэдтэй ингээд холбоо тогтоох ийм асуудлууд ямар нэгэн байдлаар эрх зүйн зохицуулалтгүй байгаад байна. Тухайлбал энэ хохирогчтой ингээд юу цахим орчноор холбоо тогтоогоод итгэлийг нь олох замаар өөртөө дасгах, өөрийнхөө бэлгийн сэдлээ халхавчлан дотно дүр эсгэгч улмаар бэлгийн хүчирхийлэлд оруулах ийм асуудлууд цөөнгүй бүртгэгдэж байна аа.

Тэгэхээр энэ практикт хохирогч өөрөө ингээд зөвшөөрөөгүй гэдгээр эдгээр төрлийн хэргийг хэрэгсэхгүй болгох гэж байгаа тохиолдлууд байна. Цахим троллинг буюу бусдыг өдөөн хатгах, зохион байгуулалттайгаар нэр төрд нь халдах харлуулах асуудлууд байна. Мөн ди пек буюу бусдын зураг, бичлэгийг өөрчилж ингээд нэр төрд нь халдах ийм асуудлууд бол Монгол Улсад бас нэлээдгүй бүртгэгдсэн байна аа.

Тэгэхээр 1 асуудал нь болохоороо мөн энэ цахим орчин дахь жендерт суурилсан хүчирхийллийн хэлбэр болох энэ амиа хорлох, нөхцөл байдалд хүргэх, ялгаварлан гадуурхах, гэр бүлийн хүчирхийлэл, заналхийлэх мөрдөн мөшгих зэрэг ингээд хэргүүдийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд авч үзэж тооцох асуудал зайлшгүй шаардлагатай байна. Яагаад гэвэл энэ төрлийн хэргүүд нь хохирогчдод маш сэтгэл санааны хүнд дарамтыг учруулдаг, урт хугацааны сэтгэл санааны дарамтыг учруулснаас амиа хорлоход хүргэдэг ийм нөхцөл байдалд бол хүргэж байна аа.

Тийм учраас бол энэ хууль эрх зүйн орчноо бид нар яаралтай эргэн харж энэ олон улсын жишигт нийцүүлэх ийм шаардлагатай байна. Нөгөө талаар энэ урьдчилан сэргийлэх асуудалд бол маш анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байна аа. Ялангуяа энэ эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт үүрэг хүлээгчдийн ойлголтыг энэ чиглэлийн ойлголт мэдээллийг бол дээшлүүлэх гээд зайлшгүй шаардлагатай байна. Энэ төрлийн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа бол шинэ тутам байгаа. Энэ дээр бол бас энэ мөрдөн шалгах аргачлалуудыг бий болгуулах сургалтыг бий болгох асуудлаар бол саналаа оруулсан байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Тайлантай холбоотой асуулт асуух хүн байвал нэрсээ өгнө үү. Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууна.

А.Ариунзаяа: Сүүлийн 5 жилийн хугацаанд шүүх шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон гэх үндэслэлээр нийт 4161 хүүхэд үзлэгт хамрагдсанаас эрэгтэй хүүхэд 263, эмэгтэй хүүхэд 3898. Эдгээр хүүхдүүдийг насны хувьд авч үзвэл 0-6 насны 350, 7-оос 13 насны 1395, 14-өөс 15 насны 1558, 16-аас 17 насны 858 хүүхэд байна аа.

Сүүлийн 5 жилийн хугацаанд бага насны хүүхэд 98, насанд хүрээгүй 11878 хүүхэд төрсөн байна. 2020-2024 онд 10-аас 14 насны нийт 215 хүүхэд төрсөн. Хүүхэд гаргасан гэсэн үг 98 хүүхэд үр хөндүүлсэн. 15-аас 19 насны 2950 хүүхэд өөрсдөө хүүхэд төрүүлсэн. 11878 хүүхэд үр хөндүүлсэн эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гарсан тоон мэдээлэл. Бид хүүхдүүдээ бэлгийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байгаа үнэнийг хэлье. Бэлгийн хүчирхийлэгчдийг ч бид нар олон нийтэд зарлахгүй байгаа. Хүүхдийн хохирогч, хүүхдийн талаар л бид нар олон нийтэд мэдээлээд байгаа болохоос биш тухайн хэргийг үйлдэж байгаа хүнийг харин ч эсрэгээрээ хамгаалаад яваад байгаа шүү дээ. Чуулган дээр асуудал орж ирэхэд би тэдгээр хүмүүсийг ер нь тарьдаг бол яасан юм бэ гэж ярьсан. Хүмүүс бол тариад унтуулах юм шиг ойлгосон. Би бол нөгөө бэлгэ эрхтэн нь ажиллагаагүй болгодог олон улсад хэрэглэгддэг энэ тариаг бол хэлсэн. Давтан хэрэг үйлддэг хүмүүсийн бүртгэл байдаг уу? Та хэд мэдэх үү? Хэнд энэ мэдээлэл байна. Тухайн орчин тойронд нь ийм бэлгийн хүчирхийлэгч байна шүү гэдгийг яагаад мэдээлэхгүй байна.

Яагаад гэвэл эдгээр хэргүүдийн 70 орчим хувь нь ойр тойрных нь хамаатан садан найз нөхдийн хүрээнд явагддаг учраас. Хүүхдээ хамгаалахаас илүүтэй бид нар нэр төрөө хамгаалж байна. Хүүхдээ хамгаалж чадахгүй байна, яах вэ? Яаж эрх зүйн орчноо өөрчлөх вэ? Нийтэд зарладаг больё. Тариа хийе гэхээр нөгөө хүчирхийлэгчийн эрхийн талаар яриад байх шиг байна лээ. Би бол олон улсын тэр жишгийг л хэлсэн. Нөгөө талдаа бага насны хүүхдүүд буюу насанд хүрээгүй хүүхдүүд хоорондоо үерхэж байна. 39 хүүхдээс 17 хүүхэд нь яг сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн гээд хоригдож байна. Энэ 17 хүүхэд. Гэтэл яг судлаад үзэхлээр эдгээр хүүхдүүд хоорондоо зүгээр найзлаад л үерхээд л бэлгийн энэ.

Л.Энхнасан: Нэмэгдэл минутыг нь өгнө үү.

А.Ариунзаяа: Бэлгийн харилцаанд орсон нь цөөнгүй байгаад байна аа. Тэгэхээр яг энэ гэмт хэрэг нь хэлбэрийн болоод агуулгын шинж ердөөсөө харгалзаж үзэхгүйгээр холбогдогч этгээдэд буюу эрэгтэй хүүхдийг нь шууд хорьчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол нөгөө талдаа буруу гэж бодоод байна. Яагаад гэвэл хүүхэд учраас хүүхдүүд хоорондоо үерхээд эрэгтэй хүүхдийг нь очиж хориод байгаа нь өөрөө буруу шүү дээ. Хүүхдүүдийн өмнө томчууд бид нар хариуцлага хүлээж байгаа. Бид нар мэдээллээ дутуу өгсөн байна. Тухайн хүүхдүүдэд бид нар арай зөөлөн арга хэмжээ авах ёстой гэж би үзэж байна.

Тэгэхээр энэн дээр бол ялгамжтай байх хэрэгтэй байна. Цахим дээр бол би бас уг нь хэдэн зүйл асууя гэж бодсон. Цахим дээр бол нэр нүүрээ өөрчилсөн хуурамч хаягуудаар энэхүү гэмт хэргүүд үйлдэгдээд байна. Цахимыг тухайн иргэн дээр нь тухайн иргэний бүртгэлтэй нь холбох хэрэгцээ шаардлага бол байна аа.

Энэ зөвхөн хүүхэд гэлтгүй нийтээрээ нийт хүмүүсийг гүтгэн доромжилдог хүмүүс бол дандаа хуурамч хаягаар.

Ажлын хэсгээс 3 дугаар микрофон. ХЭҮК-ын гишүүн.

Ж.Хунан: Ариунзаяа гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр бэлгийн хүчирхийлэл давтан үйлдэж байгаа тоо бол цагдаагийн байгууллагаас бол гарах байх гэж харж байна. Тэгэхээр санал нэг байгаа. Үндсэндээ энэ бэлгийн хүчирхийлэл болж байгаа, бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа хүүхдүүдийн тоо бол үнэхээр сэтгэлд эмзэглүүлэн байгаа. Ялангуяа энэ тоо бол 2, 3 дахин бодит байдлаасаа 2, 3 дахин, бүртгэгдсэнээсээ 2, 3 дахин илүү байх магадлал аягүй өндөр байна.

Та түрүүн хэллээ. Шүүхийн шинжилгээний ерөнхий газар, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр үзлэг хийлгэсэн хүүхдүүдийн тоо бол 2, 3 дахин илүү байгаад байгаа юм. Энэ яагаад илүү байгаа гэдгийг бол бид нар судлах хэрэгцээ, шаардлага байгаад байгаа. Тийм учраас ХЭҮК-оос мөн энэ саналыг гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа шалтгаан нөхцөл энэ хэргийг үйлдэх болж байгаа, үйлдэж байгаа хүмүүс үйлдээд энэ хэргийг шийдвэрлэгдэж байгаа энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маань өөрөө бүрэн дүүрэн судлагдаагүйн улмаас энэ чиглэлээр бид нар урьдчилан сэргийлэх арга хэмжээг бас хангалтгүй дутуу аваад байгаа гэдэг ийм дүгнэлтийг хийсэн учраас бид нар энэ чиглэлээр бүх талын одоо энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдтэй ажилладаг хүмүүсийг оролцуулсан байдлаар маш нарийн дэлгэрэнгүй судалгааг хийгээч гэдэг ийм санал зөвлөмжийг бол өгч байгаа.

Та түрүүн хэллээ. Энэ химийн аргаар тайган болгох энэ арга хэмжээг бол бусад улсад авдаг юм байна лээ. Солонгос Улс бол жишээ нь 2011 онд анх нэвтрүүлсэн байдаг. АНУ-д 1996 оноос бол энэ аргыг бол танилцуулсан. Үүнээс гадна мэс заслын аргаар бас тайган болгох энэ арга хэмжээг бол авдаг. Мэс заслын аргаар бол цөөн улс бол арга хэмжээ авдаг юм байна лээ. Мадагаскар, Чех, Нигер зэрэг улсууд бол мэс заслын аргаар бол тайган болгох арга хэмжээг авдаг. Энэ үйлдэж байгаа хүмүүс давтан үйлдээд байгаа, үйлдэж болзошгүй, үйлдэх магадлал өндөр гэдэгтэй бол санал нэг байгаа. Өөрөөр хэлбэл бид нар энэ хүмүүст хяналт тавих тогтолцоогоо бид нар боловсронгуй болгох ёстой гэдэг. Тийм ч учраас ХЭҮК-оос энэ бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох ийм гаж зан үйлтэй хүмүүсийг илрүүлдэг, тогтоодог, эдгээрийг эмчилдэг, эдгээрт хяналт тавьдаг зохицуулалтыг бий болгох санал зөвлөмжийг бол гаргаж гаргасан байгаа.

Тийм учраас энэ асуудлыг бид нар шийдэх юм бол одоо хүүхдүүд дахин хохирохоос энэ төрлийн гэмт хэргийг хүмүүс дахин үйлдэхээс бол урьдчилан сэргийлэх ийм боломжтой болно гэж харж байгаа.

Дээрээс нь энэ судалгааг бид нар маш дэлгэрэнгүй хийх шаардлагатай байгаад байгаа юм. Үндсэндээ бол энэ төрлийн гэмт хэргийн гарах болж байгаа шалтгаан энэ нөхцөлийг бол судалдаг, байгууллагууд бол судалдаг. Цагдаагийн байгууллага прокурорын байгууллага, эрдэмтэн судлаачид мөн өөрийнхөө хэмжээнд бол судалж гаргадаг. Тэгэхдээ эдгээрийн хэрэглээ, эдгээрийн үр дүнг бол бодит арга хэмжээ болгох ажил хангалтгүй байгаад байгаа. Хоорондын уялдаа байхгүй.

Дээрээс нь хязгаарлагдмал түвшинд энэ судалгааны үр дүнгүүд ашиглагдаж байгаа учраас энэ бол үр дүнгүй байгаад байгаа. Тийм учраас бид нар энийг бол судлах ийм хэрэгцээ шаардлага байна. Бүх хуулийн байгууллагууд оролцоод маш нарийн криминологийн судалгааг хийсний ард бол энэ тэмцэх урьдчилан сэргийлэх бол арга хэлбэрээ өөрчилж үр дүн гарна гэж бол харж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Тодруулах уу гишүүн. Мөнхзул уу? Мөнхзул 4 дүгээр микрофон хариулна уу.

Х.Мөнхзул: Байна уу? Ариунзаяа гишүүн маш чухал асуудлыг хөндлөө. Тэгэхээр одоогоор Монгол Улсын яг энэ интернэтийн дэд бүтэц нь бол энэ нөгөө нэг IP хаягаас олон хэрэглэгч дундаа ингээд хэрэглэдэг байдлаас шалтгаалан гэмт этгээдүүдийг тухайн цаг хугацаанд нь ямар IP хаягийг ашиглан энэ мэдээллийг түгээж байгаа талаар мэдээлэл гаргуулах боломж бол хязгаарлагдмал байдаг юм байна лээ. Ер нь бол энэ бага насны хүүхдүүд болон энэ өсвөр үе залуучуудын дунд гарч байгаа энэ бэлгийн хүчирхийлэл эд нарыг ингээд харахад дандаа нэрээ нууцалсан IP хаягаас энэ хэргүүдийг үйлддэг. Тэгэхээр энэ төрлийн гэмт хэрэгтэй мөрдөн шалгах энэ төрлийн гэмт хэрэг нь харьцангуй шинэ тутам үйлдэгдэж байгаа ийм асуудлууд байгаа учраас бол энэ гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах гэмт этгээд.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 4 дүгээр микрофон гүйцэд хариулна уу.

Анхаарлаа хандуулах бол зайлшгүй шаардлагатай байгаа. Тийм учраас бол бид нар энэ дээр энд асуудал дээр одоо бие даасан цахим технологи ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх энэ аргачлалуудыг бас боловсруулах, энэ төрлийн мөрдөн байцаагч нарын чадавхыг бэхжүүлэх энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх хамтын ажиллагааг сайжруулах гэдэг энэ саналуудыг бас энэ хүрээнд оруулж ирсэн байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Тодруулга Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Иргэн фэйсбүүкийн хуурамч аккаунт нээгээд өсвөр насны 84 охинтой танилцсан харилцаа тогтоож тухайн охидыг сүрдүүлж ятгах гуйх зэрэг байдлаар өөрсдийнх нь нүцгэн зураг бичлэгийг нь хийлгүүлэн авч улмаар уулзаж тухайн дүрс бичлэгийг олон нийтэд түгээнэ гэж сүрдүүлж барьцаалж бэлгийн харилцаанд орсон. 2023 онд.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 43 хувь нь цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар бодсон. Судалгаанд 18 мянган хүүхэд оролцсоноос 1226 хүүхэд цахим орчинд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох онлайн гроумингийн хохирогч болсон. Хэдий болтол бид хүүхдүүдээ ийм хүчирхийллийн ийм гэмт хэргийн хохирогч болгох юм бэ? Энэ хуурамч хаягуудыг цэгцэлж болохгүй юу гэдэг ийм асуулт надаа байгаад байгаа байхгүй юу. Хүн болгон нэг аккаунттай бай. Өөрийнхөө нэр нүүрээр, өөрийнхөө иргэний үнэмлэхээр, регистрийн дугаараар хэцүү байна. Харамсалтай байна.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу. Мөнхзул гишүүн хариулна уу. 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Дэмжиж байгаа тэгэхдээ яг ийм технологийн хувьд бас болох уу үгүй юу гэдгийг Харилцаа, холбооны зохицуулах хороо холбогдох байгууллага нь хариулах байх гэж бодож байна.

Л.Энхнасан: Харилцаа холбооноос өнөөдөр төлөөлөл байхгүй байна. Энэ ер нь бол энэ троллинг гээд байгаа шүү дээ тиймээ? Энэ нэр нь ихэвчлэн нэргүй, нийгмийн сүлжээнд хуурамч хаяг нээчихсэн, энэ өөр хүний зурагтай энийг хянаж болох уу гэсэн. Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Хүний эрхийн комисс дэмжиж байгаа юм бол хэдүүлээ энэ шийдвэр гаргуулахаар өгч байгаа саналдаа ч гэсэн энийг оруулмаар байгаа байхгүй юу. Энэ зөвхөн хүүхдийн асуудал биш энэ ер нь аливаа этгээдийн гүтгэлэг доромжлол бол дандаа энэ хуурамч хаягуудаар явж байгаатай холбоотой. Бид нар нийгмийн сэтгэл зүйг эрүүл байлгая л гэж байгаа бол энэ цахим орчныг бол цэгцлэх ёстой. Энэ боломжтой юу үгүй юу гэдэг асуулт бол угаасаа боломжтой.

Энэ бол бусад улс орнууд ч гэсэн энийг зохицуулсан байгаа. Австрали бол хүүхдүүдийг бүүр сошиал орчинд оруулахгүй байх хуулийг гаргасан байна лээ. Гэхдээ манай улсын хувьд яг одоо энэ хүүхдийн эрхийг зөрчих үү үгүй юу гэдэг асуудал байгаа учраас зөвхөн хүүхдүүдээ хамгаалчхаад бусад нь бол хамаагүй гэж орхигдуулж болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бол яг одоо энэ цахим орчныг цэгцлэх хуулийг гаргах тал дээр бол бид нар хамтдаа саналаа өгөөд, хамтдаа шаардаад явах нь зүйтэй. Учрал гишүүний өргөн барьж байсан хууль бол уг нь яг л энэ асуудал байсан шүү дээ. Тэгэхээр энэн дээр бол анхаарч явахгүй бол би саяын дурдсан зөвхөн хүүхдийн хүчирхийлэл ийм байгаа бол томчуудын өртөж байгаа асуудал бүүр ч энэнээс ч их байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу?

С.Эрдэнэбат: Энэ хуурамч тролл энэ сошиал орчин маань бас манай улсад хэт задгай байдлаас болоод л бараан сүүдрүүд нь яг явж явж хүүхдүүдэд энэний цаана зөндөө ч юу байгаа? Албан ёсоор бүртгэгдсэн мэдээллийн цаана ийм байгаа юм чинь энэний цаана бол энэний цаана өшөө илүү олон юм нуугдаж байгаа болов уу гэж бодож байгаа.

Тийм учраас хүний эрхийн комисс нэлээн чухал асуудлыг нь бол хөндсөн асуудал байна. Та бидний хүүхдүүд энэ цахим орчинд хэнтэй яаж харьцаж байгаа гэдгээ бид нар хянах арга байхгүй болчихоод байгаа.

Тэгэхээр энэ бол маш том аюулын дохиог бид нарт өгч л байна л даа. Тийм учраас 1 дүгээрт бол би түрүүний Ариунзаяа гишүүний хэлсэн саналтай үнэхээр зарим нь энэ тролл орчинд хүүхдүүдийг тэр 14 нас хүртэл нь ядаж фэйсбүүк энэ сошиал орчинд оруулахыг нь шууд хориглох ийм юмыг л санаачлаад хийвэл яасан юм бэ, нэг.

Хоёрдугаарт энэ цахим орчинд ажилладаг цагдаа нар гэж байна уу? Яг ингээд тэрний хүүхдүүдийг хүчирхийлэх гээд байгаа өөрийнхөө аргад оруулах гээд байгаа юманд нь дунд нь уулзах манайд тийм нэгж байна уу? Цагдаа нар гэхээр мэдээж ийм орчинд өртчихсөн хүний араас л хөөцөлдөөд байгаагаас биш ийм үйлдэл гаргах гээд байгаа нөхдүүдийг мөрдөн мөшгөх өөрсдөө дунд нь орж илрүүлэх тэр хандлага юун дээр нь үнэлэлт дүгнэлт гэдэг дээр хийдэг ажил албан тушаалтан, мөрдөн байцаагч, тэр цахим орчин, цагдаа гээд ийм хүмүүс байдаг уу?

Албан ёсны манай энэ хүүхдийн эрхийг хамгаалах залуучуудын ер нь бол иргэдийн эрхийг хамгаалах тал дээр байна уу? Би өмнө бол хэд хэдэн удаа тэр хуурамч троллоос янз янзын юм эвлүүлээд гүтгүүлж ингэж байсан цагдаад хандаж үзэж байсан. Манай цагдаагийнхан бол энийг бүрэн илрүүлэх энэ тал дээр үнэхээр техник технологи болон хүн хүчний хувьд дутагддаг юм байна лээ. Үндсэндээ яах ч боломжгүй л гэдэг юм байна лээ. Тэгээд үндсэндээ манай улс төрчид ч гэсэн ер нь хоорондоо энэ тролл олон хаягуудыг өөрсдөө хэрэглэдэг, ашигладаг, бие биеэ гүтгэдэг ийм зүйл бүр ороод ингээд нийгэм даяараа ингээд бид бүхэн чинь бараг өвчилчихсөн, нийгмийн өвчин болчихоод байна л даа нэг талаар.

Нөгөө талаар энэ олон нийтийн оролцоотой энэ компанит ажлуудыг хийж болдоггүй юм уу? Тухайлбал энэ хүүхдүүдийн орчинд, хүүхдүүдтэй хамгийн ойр байдаг магадгүй тэр сурагчдын зөвлөл байдаг юм уу тэр оюутны зөвлөл байдаг юм уу тэр багш нар нь байдаг юм уу яг энэ тал дээр яг яах ёстой юм бэ гэдэг дээр эцэг, эхүүдэд зөвлөдөг тийм юмнууд дээр яг тодорхой хийсэн ажлууд байна уу? Энэ хүүхдийн эрхийн байгууллагууд болон энэ хууль хүчний байгууллагууд. Тэгээд энэ тал дээр би тодруулга зүйлийг асуумаар байна аа.

Л.Энхнасан: Хунан гишүүн хариулах уу? 3 дугаар микрофон.

Ж.Хунан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асууж байх шиг байна. Бид нарт мэдэгдэж байгаа мэдээллээр бол цагдаагийн байгууллагын энэ хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг мөрддөг нэгж бол үнэхээр одоо бүрэн хүчин чадлаараа ажиллаад ажлаа дийлэхгүй, ачааллаа дийлэхгүй байгаа гэдэг ийм мэдээлэл байгаа.

Тэгэхээр яг нарийн мэдээллийг бол цагдаагийн байгууллагаас авах нь зөв байх. Тэгэхдээ энэ төрлийн гэмт хэрэг өөрөө цахим технологийг ашиглаж үйлдэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл урхидаж байгаа энэ асуудал бас өөрөө хяналт байхгүй. Энийг хянах боломжгүй байгаа учраас үнэхээр тэр хэдийгээр гүйцэтгэх ажил байна уу аль эс үгүй бол далд ажлаараа энийг илрүүлдэг боловчиг дахиад л өөр шинэ хаяг гараад ирдэг. Маш богино хугацаанд гарч ирдэг.

Тэгэхээр энийг бол гүйцэх ийм хэмжээний нөөц хүний нөөц бол хязгаарлагдмал байгаа гэж ойлгож байгаа. Энэ онд бол цагдаагийн байгууллагаас энэ хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч.

Дээрээс нь эмэгтэй мөрдөгч ажиллуулах ийм чиглэлийг өгсөн гэдэг ийм мэдээлэл байгаа. Гэхдээ үнэхээр ачаалал нь бол их тэр болгон ажиллаж байгаа, хүрч ажиллаж байгаа, дийлж байгаа ачааллаа дийлж байгаа хэсэг нь бол асуудалтай хэвээрээ байгаа гэж ойлгож болж байгаа.

Тодорхой арга хэмжээ ямар ажлууд хийж байгаа юм бэ гэхээр ХЭҮК-оос бол яг энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдтэй холбоотойгоор нэг зүйлийг бол санал болгож байгаа. Энэ нь юу вэ гэхээр энэ бэлгийн бойжилт эрт эхэлж байгаатай холбоотойгоор бид нар хүүхдүүддээ энэ мэдлэг мэдээллийг бол бага наснаас нь олгож эхлэх хэрэгцээ шаардлага байна гэдэг ийм зүйлийг бол зөвлөж байгаа.

Өөрөөр хэлбэл түрүүн бас Ариунзаяа гишүүний энэ мэдээлэлд бас яригдсан 14-өөс доош насны хүүхдүүд үерхээд бие биедээ хайртай болоод бэлгийн харилцаанд орж байгаа ийм тохиолдол. Энийг нарийн судлах хэрэгцээ шаардлага

байгаад байгаа юм. Энэ хүрээндээ бол энэ мэдлэг боловсролыг олгох өөрийгөө болон бусдыг хэрхэн яаж хамгаалах талаар сургалт мэдээллийг бол эрт өгч эхлэх ийм хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм. МУИС-ийн Жендер судлалын төвөөс хийсэн судалгаагаар бол 6 дугаар ангийн хүүхдүүд бол энэ би цахим бэлгийн хүчирхийлэлд бол өртдөг нь тодорхой болсон. Өөрөөр хэлбэл энэ талаар мэдлэгтэй болсон, мэдээлэлтэй болсон. Нэг асуудал анхаарал татсан нь юу вэ гэхээр 6 дугаар ангийн багш нар бол манай хүүхдүүд тийм юм мэдэхгүй гэдэг ийм хандлагаар хандаж байсан.

Өөрөөр хэлбэл багш нар нь энэ 12 настай хүүхэд буюу 6 дугаар ангийн хүүхдүүдэд бэлгийн боловсрол олгох энэ асуудлыг бол дэмжихгүй байгаа ийм хандлагатай байсан. Тэгэхээр энийг бол бид нар эргэж харах ёстой. Ер нь энэ бэлгийн бойжилт эрт эхэлж байгаатай холбоотойгоор бэлгийн боловсролыг мөн эрт өгч сэрэмжлүүлж өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг ур чадварыг суулгах ийм хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм.

ХЭҮК ЦЕГ-тай хамтраад хүн бүр хүүхэд хамгаалагч гэдэг арга хэмжээг бол хийгээд явж байна. ХЭҮК-оос үүнээс гадна бол хүүхэд бүр ялагч, хүүхэд бүр хамгаалагч.

Дээрээс нь манай ангид хүний эрхийн түгээмэл тунхаглал гэдэг ийм тогтмол арга хэмжээнүүдийг зохион байгуулах замаар хүүхэд багачуудын хүний эрхийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг бол тогтмол хийж байгааг дуулгая аа.

Л.Энхнасан: Бейсен гишүүн асуултаа асууна уу.

Б.Бейсен: Энэ бага насны хүүхдийн эрүүл мэндэд ноцтой хохирол учраад амь нас хохирсон тохиолдолд хилээр гарахыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээ авдаг. Гэтэл шүүхээр Цагдаагийн байгууллагаар мөрдөн байцаалт хийлгэгчээд шүүхэд шилжих шатдаа прокурорын байгууллагын, цагдаагийн, хууль хүчний байгууллагын хариуцлагагүй байдалтай холбоотой гуйвуулаад хил гаргаад явуулчихдаг. Хүний амь нас хохирч байдаг хохирлоо нөхөн төлүүлж чаддаггүй ийм тохиолдол байгаа. Энэ Баян-Өлгий аймагт гарсан.

Тэгэхээр ийм хариуцлагагүй хуулийн тэр прокурор, цагдаад нь хариуцлага тооцсон тохиолдол бий юу, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, энэ бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой 2024 оны байдлаар цагдаад бүртгэгдсэн нийтдээ 1139 хүүхэд байдаг юм байна. Энийг 318 нь хүсэлт гаргаад шинжилгээ хийлгэсэн байна.

240 хүүхэд нь сэтгэгцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосон байна. Бусад нь ямар учраас энэ дутуу шалгаад байна вэ Цагдаагийн байгууллага энэ дээр хяналт хийж үзсэн үү.

Бэлгийн хүчирхийлэлд 2024 онд 598 насанд хүрээгүй хүүхэд өртсөн байна. Тэгээд 908 хүнд үзлэг шинжилгээнд хамаарагдсан байна л даа. 2024 оны байдлаар насанд хүрээгүй хүүхэд төрүүлсэн 1931 хүүхэд байдаг юм байна. Үр хөндүүлсэн 499 хүүхэд. Тэгэхээр энэний шалтгааныг судалж үзсэн үү, 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ ялаар шийтгүүлсэн хүн нийтдээ 202-хон хүн байна гээд энэ тайлан дээр дурдсан байна. Энэний 5 нь бэлгийн хүчирхийлэл үйлдчихээд ял авчхаад хугацаанаас өмнө 5 нь суллагдсан байх юм. Ямар шалтгаанаар суллагдсан хүний ерөнхий комисс энэ дээр үзсэн үү? 3 нь яах вэ өвчний өвчний учир гэсэн байна.

Хоёр нь Монгол Улсын Дээд шүүхийн цагаатгалаар цагаатгасан байна. Тэр бас заримдаа хэлмэгддэг асуудал гардаг л даа. Энэ талаар тодорхой дүгнэлт хийж шалгаж өгсөн үү? Тэрийг асуух гэсэн юм.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс Хунан гишүүн хариулна. 3 дугаар микрофон.

Ж.Хунан: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Нэгд тэр хилээр гарах хориг тавигдсан хүмүүс хилээр гарч байгаа асуудлыг бол цагдаагийн байгууллага бусад холбогдох хуулийн байгууллагуудаас мэдээлэл нь гарах байх. Тэгэхээр ХЭҮК дээр яг энэнтэй холбоотой бол мэдээлэл байхгүй байна. Гэм буруутай этгээд хилээр гарч хохирлоо барагдуулахаас зайлж байгаа нь бол яах аргагүй хүний эрхийн ноцтой асуудлыг бол бий болгож байгаа. Өөрөөр хэлбэл хохирлоо барагдуулах энэ асуудал бол орхигдох ийм нөхцөл байдлыг бол бий болгож байгаа гэдгийг хэлье ээ. Энэ бага насны хүүхэд үр хөндүүлж байгаа төрж байгаа тоо бол энэ эрүүл мэндийн байгууллагаас өгсөн мэдээлэл. Тэгэхээр энэ шалтгаан нөхцөлийг бол бид нар судлаагүй, нарийвчилж судлаагүй энэ талаарх бол мэдээлэл байхгүй байгаа.

Тэгэхээр энийг бол эрүүл мэндийн байгууллагаас нарийн дүн шинжилгээ хийсэн эсэх талаарх мэдээллийг бол авах нь зөв байх. Бидний хувьд бол энэ тоо өөрөө маш өндөр байна аа. Тийм учраас энэ дээр бид нар нарийн судалж дүн шинжилгээ хийх шаардлага байна. Энэ дээр дүн шинжилгээ хийсний ард тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байгаа гэдгийг бид нар хэлж байгаа.

14 наснаас доошоогоо хүүхэд төрсөн үр хөндүүлсэн асуудал бол энэ бол өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар бол бүгд гэмт хэрэг. 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт тооцогдож байгаа. Тэгэхээр энэ тохиолдол бүр дээр бол эрүүгийн хэрэг нээгдээд шалгагдаад явсан байх ёстой явсан байгаа гэж бодож байна аа.

Хохиролтой холбоотой асуудал ХЭҮК-оос энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хохирол барагдуулах эрхийн хүрээнд бол 40 хэрэгт дүн шинжилгээ хийж ажилласан байгаа. 40 хэргээс бол 17 хэрэгт нь бол хохирол нэхэмжилсэн байгаа. 10 хэрэгт нь хууль ёсны төлөөлөгч, 7 хэрэгт нь өмгөөлөгч хохирол барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Нэхэмжилсэн хохирлын хувьд бол 8 хэрэгт нь сэтгэл санааны хохирлыг нэхэмжилсэн, 9 хэрэгт нь бусад төрлийн хохирлоо дэмжсэн. Энэ нь бол нөгөө захиргааны зардал бие махбодод учирсан хохирол гэж үзэж байгаа.

Харин шүүхээс хохирол нэхэмжилсэн 17 хэргээс 7 нэхэмжлэлийг нь бол хэрэгсэхгүй болгосон байгаад байгаа. Өөрөөр хэлбэл хохирол нэхэмжилсэн 10 нэхэмжлэлийг бол хангаж шийдвэрлэсэн. Тэгээд нийт 50 гаран сая төгрөгийн хохирлыг бол шүүгдэгчээс гаргуулсан ийм мэдээлэл байгаад байгаа. Тэгэхээр

бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хохирол барагдуулах ажиллагаа бол хангалтгүй гэж дүгнэх ийм мэдээлэл гэсэн үг. Сэтгэцэд учирсан хохирлыг тогтоох ажиллагаа бол саяхнаас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бол тоо нь бага байхыг үгүйсгэхгүй. Уг нь бол энэ сэтгэцэд учирсан хохирлыг бол хэрэг бүр дээр бол тогтоох ийм хуулийн зохицуулалттай.

Харамсалтай нь энд бас нэг асуудал яригдаж байгаа нь хууль, ёсны төлөөлөгчөөр ихэвчлэн хохирогч хүүхдийн эцэг эх нь томилогддог. Эцэг эх нь томилогдсон тохиолдолд хохирол байхгүй, хохирол нэхэмжлэхгүй байх явдал түгээмэл байгаад байгаа юм.

Тийм учраас ХЭҮК-оос энэ асуудлыг өөрчлөх шаардлагатай юм байна аа. Бид нар зарим тохиолдолд эцэг эхээс нь хүүхдийг хүртэл хамгаалах ёстой тийм учраас заавал өмгөөлөгчтэй ордог энэ зохицуулалтыг сэргээе гэдэг.

Л.Энхнасан: Нэмж хариулах уу болсон уу? Бейсен гишүүн нэмж асууна.

Б.Бейсен: Энэ өөр нэг асуудал. Энэ өр шилжүүлэн суулгахтай холбоотой хүүхдүүдийн эрх зөрчигдөж байгаа асуудал байна уу? Нөгөө талаар энэ хүүхэд тээгч эмэгтэйчүүд бий болсон. Өөр хүнийг хүүхэд тээж төрүүлж өгдөг. Жилдээ нэг 200 эхэд тэгж хүүхэд төрүүлээд өгдөг юм байна. Энэнтэй холбоотой тэр хүүхдийн эрх зөрчигдөх асуудал дээр танай байгууллага ер нь хяналт хийж байсан уу? Түрүүн бид нар энэ нөгөө эд, эс шилжүүлэн суулгахтай холбоотой асуудал дээр бас яригдсан энэ асуудал. Энэ дээр бас судалгаа хийж үзсэн үү?

Л.Энхнасан: Хунан гишүүн 3 дугаар микрофон.

Ж.Хунан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үр шилжүүлэн суулгахтай холбоотой хүүхдийн эрхийн асуудлыг одоогоор бол судалсан шинжилсэн зүйл бол байхгүй байгаа.

ХЭҮК энэ жил эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн дүн шинжилгээг бол хийхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээндээ бол үр шилжүүлэн суулгахтай холбоотой зохицуулалт. Үүнээс үүдэлтэй гарах боломжтой, гарах болзошгүй хүүхдийн эрхийн асуудлыг бол давхар судлаад явна гэдэг мэдээллийг өгье.

Л.Энхнасан: Нэмж тодруулна уу Бейсен гишүүн.

Б.Бейсен: Сая нөгөө өөр хүний хүүхэд төрүүлэх асуудал. Хүүхэд тээгч эх байна шүү дээ. Төрүүлээд гэрээ хийгээд хэдээр гэрээ хийдэг юм тэгээд хүүхдийг нь төрүүлж өгдөг тийм асуудал байдаг гэсэн. Зарим нь одоо ингээд төр жирэмсэлчхээд хүүхдийг нь өгдөггүй тийм асуудал гардаг гэнэ ээ. Бид нар түрүүн нөгөө энэ хуультай холбоотой ХНХЯ-ны хүүхдийн асуудлын улсуудтай хамтраад энэ судалгаа хийгээд тэд нарыг танилцуулахдаа ийм асуудал гарсан байхгүй юу. Өөр хүний хүүхэд төрүүлж өгөөд мөнгө авдаг асуудал. Энэ дээр ямар эрх зөрчигдөх вэ? Тэр талаар асууя.

Л.Энхнасан: 3 дугаар микрофон. Хунан гишүүн. Биологийн эхийн, хүүхдийн эрхийн асуудал бол одоогоор бол комисс дээр ирээгүй байгаа. Өөрөөр хэлбэл энэнтэй холбоотой гомдол комисс дээр ирээгүй байгаа. Олон нийтийн сүлжээ болон иргэд хооронд бол энэ яриа бол гардаг.

Өнөөдөр Монгол Улсад үр шилжүүлэн суулгах эмнэлгүүд бол үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд энэ бэлгийн эсийг хадгалдаг энэ практик бол нэлээн түгээмэл болсон. Тэгэхээр энэтэй холбоотой яг нарийвчилсан судалгаа хийсэн зүйл байхгүй байгаа учраас энэ дээр бол яг ийм эрхийн зөрчил гарч байсан. Гардаг гэдэг талаарх мэдээллийг бол өгөх боломжгүй байна аа.

Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу?

М.Ганхүлэг: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг танилцуулж байна. Их Хурлын түвшинд хүний эрхийн асуудлыг жил болгон эхний улиралд багтааж танилцуулаад хэлэлцдэг ийм бас уламжлал тогтоож явж байгаад би талархалтай байна. Энэ тодорхой хэмжээний дэвшил бий болоод явж байгаа юм аа.

Ерөнхий асуултууд нэлээн давхардлаа. Тийм учраас ер нь өмнөх илтгэлүүдээ дүгнэх талаас нь яг хэрэгжихгүй. Хэрэгжсэн энэ асуудлууд дээр тодорхой дүгнэлтүүд хийгээд, ингээд үзэхэд, бас энэ танилцуулсан илтгэлүүд, ялангуяа Их Хурлын гишүүдийн зүгээс хууль тогтоогч нарын зүгээс гол үүсэж байгаа сөрөг талууд байдаг юм уу ийм асуудлууд нь яг хэлбэл ямар зүйлүүд байна вэ гэдэг дээр та бүхэн дүгнэлтүүд гаргасан зүйлүүд байна уу? Маш чухал асуудлуудыг бас хөндсөн байгаа. Гишүүдтэйгээ ер нь санал нэг байгаа.

Шинэ парламентаар 126 гишүүнтэй болоод ингээд явж байгаа. Харьцангуй бас хүний эрхийн мэдрэмжтэй салбар салбарын гишүүд орж ирсэн болов уу гэж бодож байгаа. Тэр утгаараа бол энэхүү илтгэлийн хэрэгжилт цаашдаа гаргаж байгаа шийдвэрүүд дээр нэлээн өөр үр дүн гаргаад явах болов уу гэсэн ийм байр суурьтай байна аа.

Детальчлаад яах вэ асуух юм тэр сонгуулийн зардалтай холбогдолтой асуудал дээр яг ямар үндсэндээ зөвлөмжийг та бүхэн өгч байгаа вэ? Яг үнэндээ бүсийн хэмжээний сонгуульд шинэ залуу нэр дэвшигч нар өрсөлдөнө гэдэг нэлээн том сорилт болсны нэг нь энэ сонгуулийн тогтолцоо, зардалтай холбогдолтой асуудал байсан. Тэгэхээр энэ зардлыг бууруулах чиглэл дээр тодорхой ямар зөвлөмжүүд байна вэ гэдгийг дэлгэрүүлээд нэг ярьчих нь зөв болов уу гэж бодож байна.

Хоёрт нь хүүхдийн байгууллагын 100 жилийн ой яг одоо тохиож байна. Монгол Улсын хувьд бол энэ хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, түүнтэй холбогдолтой асуудал дээр ер нь хүүхэд хүүхдэдээ зөвлөдөг хүүхдийн оролцоогоор дамжуулж бий болгодог олон сайн туршлага зүйлүүд байгаа гэдгийг би цохож хэлье.

Хувь хүнийхээ хувьд ч тэр хүүхдийн байгууллагын чиглэлээр бас ажиллаж ирсэн ийм туршлагууд надад байдаг. Тэр утгаараа хүний эрхийг яг хүүхдээр дамжуулж, нийгэмд бий болгох энэ хамгааллын энэ чиглэл дээр тодорхой бас арга хэмжээг авах, хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжих чиглэл дээр бид юу хийж болох вэ? Энэ ярьж байгаа энэ гол асуудлууд дээр тодорхой энэ оролцоог нь хангах, мэдээллээр хангах энэ чиглэл дээр бол бас энэ талын ажлууд илүү хамгийн үр дүнтэй бас зохицуулагдах боломжууд байна гэж ингэж үзэж байна. Цахим орчинд тэр үйлдэгдэж байгаа тэр хэргүүд дээр тодорхой яг ийм хуулийн өөрчлөлтүүд дээр

ямар ямар хуулиуд яг гацаа болж байна? Тэрэн дээр ажиллаж байдаг юм уу саналаа хүргүүлсэн яг тодорхой ямар саналууд байна вэ?

Үнэхээр насанд хүрээгүй хүүхдүүд үндсэндээ хаяг нээж байгаа энэ асуудлууд, мөн нууц энэ хаягууд нээж байгаа асуудлуудыг.

Л.Энхнасан: 3 дугаар микрофон Хунан гишүүн.

Ж.Хунан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлийг 2020 оноос хойш Улсын Их хурал ХЗБХ болон нэгдсэн чуулганаараа заавал хэлэлцдэг ийм хуулийн зохицуулалт хэрэгжиж явж байгаа. Энэ хүрээндээ 2020 онд томилогдсон шинэ бүрэлдэхүүн бол 5 дахь илтгэлээ бол Улсын Их Хуралд танилцуулж байна.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хуралд танилцуулаад чуулганы нэгдсэн хуралдаанаар бол хэлэлцүүлсэн гэсэн үг. Илтгэл болгоны араас бол санал зөвлөмжийн саналаа бол танилцуулдаг байгаа. Энэ санал зөвлөмжийн саналыг үндэслээд Улсын Их Хурлаас тогтоол гардаг. Харамсалтай нь тогтоолын хэрэгжилт бол төдийлөн хангалттай биш байдаг. Тэгээд тогтоолын хэрэгжилтийг сайжруулах, үр дүнтэй болгох, ажил хэрэг болгох тал дээр бол Улсын Их Хуралтай бол хэд хэдэн удаагийн санал солилцсон асуудлыг бол ярилцаж байгаа. Энэ удаагийн Улсын Их Хуралтай ч мөн адил энэ асуудлыг ярьсан хөндсөн. Энэ хүрээндээ бол ХЭҮК-оос өгч байгаа санал зөвлөмжүүдийг бас ангилж гаргах ийм хэрэгцээ шаардлага байгаа юм байна гэдэг ийм зүйлийг бол бид нар ярилцсан байгаа. Энэ дээр бол санал нэгдсэн. Өөрөөр хэлбэл богино хугацаанд хэрэгжиж болох санал зөвлөмжүүд урт хугацаанд хэрэгжих боломжтой санал зөвлөмжүүд гэж бас ангилж гаргая.

Тэгээд хэрэгжилтийг нь бол ирэх намрын чуулганд танилцуулдаг ийм хуулийн зохицуулалттай. Тэгэхээр энэ хугацааг бас эргэж харах тэгээд дээрээс нь мөн энэ ХЭҮК-оос өгч байгаа энэ санал зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг шийддэг болох ийм хэрэгцээ шаардлага бол байгаа.

Тийм учраас энэ дээр бол бас анхаарал хандуулах, ялангуяа төсөв хэлэлцэх явцад энэ дээр тодорхой төсөв мөнгийг тавьдаг байх ийм практикийг бол нэвтрүүлэх шаардлагатай гэж харж байгаа. Энэ Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд 24 дэх илтгэлээс 2 асуудлыг бол танилцуулаарай гэж чиглэл Улсын Их Хурлын дарга өгсөн байгаа. Энэ нь бол нөгөө цахим орчин дахь цахим технологийг ашиглан үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийлэл, тэгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхдийн зарим эрхийн асуудал гэдэг энэ хүрээндээ бол 2 асуудлыг танилцуулж байгаа. Сонгох сонгогдох эрхийн хүрээнд та түрүүн асуусан сонгуулийн зардалтай холбоотойгоор тэгэхдээ ХЭҮК-оос өгсөн зөвлөмжийг бас танд танилцуулъя.

Энэ нь бол сонгуулийн зардлыг бууруулах, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, залуучууд зэрэг нийгмийн олон бүлгээс сонгуульд нэр дэвших боломжийг дэмжих төр тусгай арга хэмжээг хуулиар тодорхойлох гэдэг ийм саналыг бол яг сонгуулийн зардалтай холбоотойгоор өгсөн байгаа гэдгийг дуулгая аа.

Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой болж байгаа. Энэ хүрээндээ хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх хүүхдийн дуу хоолойг сонсох ийм ямар

арга хэмжээг авбал зүгээр юм бэ гэж байгаа. Тэгэхээр Хүүхдийн эрхийн тухай хуулиар Монгол Улс бол хүүхдийн аливаа асуудал, ялангуяа энэ хөгжлийн процесст оролцох эрхийг бол тунхаглаж өгсөн.

Тийм учраас энэ хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэрт бас хүүхдийн дуу хоолойг сонсдог байх энэ механизм бүтцийг бол хэвшүүлэх энийг бол үр дүнтэй болгох.

Л.Энхнасан: Хоёрдугаар микрофоныг нээнэ үү. Жендерийн үндэсний хорооны дарга Энхбаяр нэмж хариулна.

Д.Энхжаргал: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрдэнэбат гишүүн болоод дараа асуусан гишүүний асуултад тодруулаад үндэсний хорооноос нэг мэдээлэл өгье гэж бодсон юм. Энэ хүрээнд Жендерийн үндэсний хороод түүний ажлын алба, бүх нийтийн жендерийн боловсролыг дэмжихэд бол илүү нөгөө компанит үйл ажиллагаа өрнүүлдэг. Тэгэхээр сүүлийн 2 жилийн жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болоод Монгол цэргийн өдрийг угтаад харилцан хүндэтгэе сарын аяны хүрээнд сүүлийн 2 жилд бид нар яг ерөнхий боловсролын нэг 40 орчим сургуулийн ахлах ангийн болоод өсвөр насны хүүхдүүдэд ер нь жендерийн хэвшмэл ойлголтоос үүдэлтэй асуудлаар ингээд тодорхой ажлуудыг зохион байгуулахад 2 асуудлуудыг дийлэнх хүүхдүүд гаргаж байгаа.

Нэгдүгээрт нь аав ээжүүд угаасаа завгүй шүү дээ. Бид нартай ярилцдаггүй. Угаасаа тэд бол дандаа ажилтай байдаг.

Хоёрдугаарт нь болохоор би өнөөдөр өсвөр насны хайр дурлал.

Л.Энхнасан: Нэмж хариулъя 2 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Ямар нэгэн асуудлуудыг зөвхөн үе тэнгийн охидуудтайгаа хөвгүүдтэйгээ нэг бол ангиараа тодорхой найзалж байгаа хүүхдүүдтэйгээ ярилцдаг гэдэг асуудлуудыг л хөндөөд байгаа. Тэгэхээр дийлэнх судалгаа дандаа хүүхдүүдээ үл хайхрах хүчирхийлэлд бид өртүүлээд байна. Эцэг гэх анхаарахгүй байна гээд. Энэ дээр Үндэсний хорооноос гаргаж байгаа санал бол бид нар Монгол Улсынхаа түвшинд Улсын Их Хурлаасаа, Засгийн газраасаа ажил ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг дэмжих чиглэлд анхаарах зайлшгүй шаардлага байна аа.

Ажлын бус өдөр баяр ёслолын үеэр ажлын бус цагаар үр хүүхдүүддээ бид нар цаг гаргах тэр боломж угаасаа байхгүй байхад хүүхдүүддээ анхаарахгүй байна гэдэг нь өөрөө логикгүй болоод байгаа юм. Тэгэхээр ер нь бүх түвшиндээ бид нар ажлын бус цагаар ажиллах бүх нийтийн амралтын өдрүүдээр амралтын өдрүүдийг гэр бүл, хүүхдүүддээ гаргах гэдгийг дээрээсээ эхлээд бид нар уриалга гаргаад энэ дээр нь ингээд анхаараад.

Хоёрдугаарт нь өсвөр насны хүүхдүүдтэй аав ээжүүд, яаж хүүхдүүдтэйгээ ярилцах юм бэ?

Л.Энхнасан: Нэмж хариулъя. 2 дугаар микрофон. Энхбаяр дарга.

Д.Энхжаргал: Хүүхэд хамгааллын тухай хуулиараа бид нар чинь нөгөө эцэг эхийн зөвлөлөө байгуулчихсан. Байгууллага болгон хүүхэд хамгааллын бодлогуудаа батлаад явж байгаа. Тэгэхээр өнөөдөр байгууллагаараа дамжуулаад өсвөр насны хүүхдүүдтэй аав ээжүүд яаж хүүхдүүдтэйгээ ярилцах юм, хамтарч ажиллах юм гэдэг магадгүй тэр сургалтууд аав ээжид бол дутагдалтай байгаа байхгүй юу. Нөгөө сэтгэл зүйчтэй ярилцах дутагдалтай байгаа шиг. Тэгэхээр энэ талаарх сургалтуудыг бид нар ажил олгогч нар байгууллагынхаа түвшинд хийж болно шүү дээ энэ чинь мэдээллийн цагууд байнга хийгдэж байгаа.

Тэгэхээр шийдвэрлэх арга зам дээр уг нь энгийн бөгөөд тодорхой бас ингээд төсөв хөрөнгө зарцуулахгүйгээр энэ ажлуудыг мөрдөөд явах нь жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын гол үнэ цэн байдаг. Тэгэхээр энэ бодлогын хэлэлцүүлгийг саяхан бас Улсын Их Хурлын Ариунзаяа гишүүн, Баасанжаргал гишүүн нар тэргүүлээд хүний эрхийн дэд хорооноос жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийг салбарын яамдууд дээр нь аймаг, нийслэл, дүүргээр нь бид нар хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцсан.

Тэгэхээр энэ бас ингээд тодорхой гарц шийдлүүд байгаад байгаа. Гол нь дээд байгууллагууд амралтын өдөр ажлын бус цагаар ажиллаж байгаад ямар ч нөгөө гарц шийдэл байхгүй. Бүгдээрээ.../минут дуусав/.

Л.Энхнасан: Тодруулга Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Маш чухал асуудлын тухай хэлж байна аа. Санал нэг байна. Детальчлаад нэлээн ажиллаад явна гэсэн бодолтой байна. Илтгэлтэй холбогдолтой яах вэ асуудлуудаас гадна тэр ер нь яах вэ жендерийн тухай нийгмийн ойлголт их тийм өөр болж хувирах гээд байна л даа. Бид нар эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудлыг л жендер гэж ойлгоод ингээд явдаг байсан. Дэлхий нийтийн хувьд ч гэсэн ийм асуудал болох гэж байх шиг байна.

Тэгэхээр хүний эрхийн энэ тодорхой илтгэлүүд дээр бусад энэ асуудлууд тэр дундаа энэ Монгол эрчүүдийн тухай асуудлыг бас ер нь аль талаас нь хардаг юм? Энэ чиглэлийн ажлуудыг нэг тодруулчихъя гэж би зүгээр бодсон юм аа. Яагаад гэвэл эрчүүдийн хувьд бол амь амиа хорлолтоос авхуулаад сэтгэл зүйн хувьд асуудлууд улам л их болоод байна. Боловсролын хувьд ялгаа маш их болоод байна. Тэгээд орон нутгаар нэлээн явахад энэ залуу малчдын асуудал дандаа л эрчүүд байгаа ийм асуудлууд үүсээд байна л даа.

Л.Энхнасан: Маш зөв асуудал. Би яг Жендерийн үндэсний зөвлөлийн даргаас асуух гэж байсан. Энэ эрчүүдтэй холбоотой ер нь бид нар боловсрол тэгээд үе тэнгийн дээрэлхэлт, мөн насжилттай холбоотой эрчүүд маань эмэгтэйчүүдээсээ хойно үлдсэн байна. Тэгэхээр энэ дээр хороо ямар бодлого баримталж байгаа вэ анхаарч байгаа юу? 2 номер Энхбаяр.

Д.Энхжаргал: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Жендерийн үндэсний хороо монгол эрэгтэй, эмэгтэй хүний жендерийн тэгш бус асуудал үүсэж байгаа дээр тодорхой жендерийн үнэлгээ мониторинг хийгээд улс орны хэмжээнд үндэсний хэмжээний үнэлгээ хийж танилцуулдаг. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.4-өөр Жендерийн хуулийн хэрэгжилтийн Засгийн газрын тайланг 2 жил тутамд Улсын Их Хурал сонсдог 2023 онд Нийгмийн бодлого, Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу сонссон. 2025 онд энэ жил бол

2 жилийн үйл ажиллагааны тайланг сонсох жил байгаа. Ганхүлэг гишүүнтэй мэдээлэл хуваалцахад. Тэгэхээр энэ тайланг бид нар эхний хагас жилд яг тайлан боловсруулагдаад Засгийн газрын хуралдаанд 6 сард танилцуулаад тайланг үргэлжлүүлээд намрын чуулганд Улсын Их Хурлын хамтарсан Байнгын хороод болон Их Хуралд танилцуулах ийм төлөвлөгөөтэйгөөрөө ажиллаж байна аа.

Монгол эрэгтэйчүүдийн асуудлаар 2019 онд ҮСХ-той бид нар хамтраад 19-өөс 25 насны 10 мянган цэргийн насны залуучуудад судалгаа хийсэн. Судалгаа бол яагаад дундаж наслалтыг.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 2 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Судалгаа хийх үндсэн шалтгаан нь бол монгол эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрөө 9.7 жил. Олон улсын туршлагаар бол нэг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ 4-өөс 5 жилээр илүү насалдаг. Дэлхийн бүх улс орнуудын 4 жилд гапыг барьж явдаг байхад манайхад бүр 9.7 буюу 2 дахин өндөр байгаа. Тэгээд юунаас шалтгаалж байгаа вэ гэдэг үндэсний судалгаагаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрэгтэйчүүд 1.5 дахин амбулаторийн үзлэгт ерөөсөө урьдчилж өвдөхөөс өмнө хамрагддаггүй.

Хоёрдугаарт нь халдварт бус өвчлөл буюу тамхи, архины хэрэглээ, стресс тайлж байгаа хэлбэрүүд дандаа энэнтэй шууд холбоотой. Үйлдвэрийн осолд 100 хувь эрэгтэйчүүд өртдөг. Мөн зам тээврийн осолд дандаа нөхөн үржихүйн насны эрэгтэйчүүд өртөж хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа асуудлууд гээд ингээд маш тодорхой шалтгаанууд гарсан. Таны хэлж байгаа амиа хорлолт хүртэл бүгд 2 дахин орчим өндөр байгаа. Тэгэхээр энэ чиглэлд хороо зөвхөн 2019 онд судалгаа хийгээд орхиогүй. 2020-оос 2022 онд Жендерийн үндэсний хороог Монгол Улсын ерөнхий сайд тэргүүлдэг.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. 2 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Хорооны хурлаар төлөвлөгөө баталсан. Одоо яг таны хэрэгжүүлж байгаа салбар дундын төлөвлөгөө. Тэгээд энэ төлөвлөгөөг 2022 онд бид нар хэрэгжүүлээд дахиад цаашаа яг энэ эрэгтэйчүүдийн чанартай урт наслалтыг дэмжих төлөвлөгөө байх нь зүйтэй юм гэж үзээд сая 2024 онд өнгөрсөн жилийн сонгуулийн өмнө 5 сард дахин төлөвлөгөө бүх яамдын оролцоотойгоор боловсруулагдаад одоо 27 он хүртэл хэрэгжих төлөвлөгөө байгаа. Тэгээд энэ төлөвлөгөөн дээр нөгөө эрэгтэйчүүдийг тэр дундаа нөхөн үржихүйн насны тэр дундаа яг хөдөө байгаа малчин эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, үзлэгт хамрагдалтын асуудал, үйлдвэрийн осол, дээр нь тэр нөгөө ажлын байрны мэдрэмжтэй бодлого, эрэгтэйчүүдэд ээлтэй байх гэсэн асуудлуудаар төлөвлөгөө гаргаад жил болгон энийг тайланг нь аваад хорооны хуралд тайлагнаад явж байгаа.

Тэгээд сүүлийн 4 жилийн хугацаанд 9.7 жилийн зөрөө бол 9.2 жилд орж ирсэн байгаа гэдэг ийм мэдээллийг хэлээд цаашид энэ үйл ажиллагааг тогтвортой явуулна гэж хороо харж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: 4 дүгээр микрофон нэмж хариулах уу.

Х.Мөнхзул: ХЭҮК-оос энэ эрэгтэйчүүдийн жендерийн асуудал дээр анхаарал хандуулж энэ эрэгтэйчүүдэд чиглэсэн жендерийн энэ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ямархуу бодлогын асуудал байна. Энэ чиглэлээр хууль тогтоомжууд болон энэ бодлогын хэрэгжилт ямар байна гэдэг дээр бид нар энэ жил бие даасан судалгаа хийж дараа жилийн хүний эрх чөлөөний илтгэлдээ оруулахаар ингээд бэлтгэл ажлаа хангаад явж байна.

Баярлалаа.

Л.Энхнасан: Булгантуяа гишүүн асуултаа асууна уу.

Х.Булгантуяа: Би энэ удаагийн тайлангаас манай Цахим хөгжил, харилцаа холбооны яам, ХЗДХЯ хамтран хуулиуддаа өөрчлөлт оруулах асуудлыг ер нь нэлээн сайн хийгээсэй гэж бодож байна. Энэ удаагийн тайланд ялангуяа энэ цахим орчин дахь хүний эрхийн асуудал, тэр тусмаа энэ жендерт суурилсан хүчирхийллийн асуудлыг нэлээдгүй бичсэн байна. Тэгээд үүний нэг жишээ бол та бүгдийн тайлан дээр бичсэн байна. Ажил үйлс ажлынхаа онцлогоос шалтгаалаад улс төрч эмэгтэйчүүд болон сэтгүүлчид үүнд хамгийн их өртдөг өө гэж. Сонгуулийн үеэр ч гэсэн эмэгтэй улс төрчдийг хамгийн их дайрдаг мэдээллийг түгээдэг.

Сүүлийн үед бүүр ди фэйкээр дамжуулаад худал хуурмаг мэдээллүүдийг хамгийн их сайн хийдэг. Үүний нэг тод ч жишээ бол сүүлийн үед манай Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд рүү бүүр эрээ цээргүй эвлүүлж байгаад худал мэдээлэл тараадаг асуудал боллоо. Би энүүнийг бүүр магадгүй дараагийн удаагийн хүний эрхийн комиссын тайлангийн судалгаан дээр оруулаасай гэж хүсэж байна.

Саяхан Улсын Их Хурлын гишүүн Баярмаа руу, намар ингээд Мөнхсоёл, Баярмаа 2 руу унаач хүүхдүүдийн асуудлыг ярьснаас болж Баасанжаргал, Саранчулуун нарын гишүүд рүү өнгөрсөн намаржингаа л манай дөнгөж чуулган эхэлж байхад Цэнгүүн гишүүн рүү дуудаад л. Тэгээд л Номин сайд руу, Энхтуяа гишүүн рүү сүүлийн үед Нарантуяа-Нара, Мөнхтуяа гээд ерөөсөө үүнд өртдөггүй хүн гэж байхгүй болсон. Өнгөрсөн парламентад манай цөөхөн эмэгтэйчүүдийг ар гэр, амьдрал, дээрээс нь нэмээд өмссөн зүүсэн үс гээг бүгдээрэнг нь шүүмжилсээр л байсан. Энэ нь ингээд даамжирсаар байгаад хэдэн хүн ч байсан бүгдээрэнг нь шүүмжлээд л дуусах юм байна.

Тэгэхээр ийм байдалтай байгаа цагт бид нар жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хамгийн ил тод харагдаж байгаа хүмүүсийг нь хайр найргүй балбаад байхад энэ хүүхдүүдэд нөгөө талдаа үзүүлж байгаа том жишээ. Хүүхдүүд бид нар яг энэ цахим орчин дахь хүний эрхийн асуудал ингээд үе тэнгийн дээрлхэлтийн асуудлыг ярихад урдаас ингэж хэлж байна л даа. Үгүй та нар бие биеэ аймаар дээрэлхдэг юм байна лээ шүү дээ. Хайр найргүй та нар муулдаг юм байна лээ шүү дээ. Томчууд та нар бие биеийнхээ өөдөөс харж байгаад л хэлэх хэлэхгүй үгээр бие биеийгээ хэлдэг юм байна лээ шүү дээ. Тэгээд та нар яахаараа бид нар дээрээ ирэхээрээ бие биеийгээ хайрла хүндэтгэ гээд байдаг юм. Та нар бид нарт энэ үлгэр жишээг тогтоож байгаа шүү дээ гэдэг шиг ханддаг юм байна лээ. Тэгэхээр үүн дээр энэ юун төлөө холбогдох Байнгын хороотой боллоо, юун төлөө холбогдох яамтай боллоо. Энэ хууль эрх зүйн орчныг сайжруулах дээр өөрийн эрхгүй ажиллах хэрэгтэй байна. Дараачийн асуудал нь саяхан хүний эрхийг хамгаалах энэ багц хуулийг Улсын Их Хурал, Засгийн газраас өргөн барьсан. Үүн дээр энэ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай бид нар болоод гэр бүлийн хүчирхийлэлтэй

нэлээн хатуугаар тэмцэхгүй бол гэр бүлийн хүчирхийлэл бүүр гаарлаа гээд оруулж ирсэн чинь одоо сэтгэл зүй, санхүүгийн болон ер нь бусад хүчирхийлэлд үзүүлж байгаа хуулийн зохицуулалтыг нь ер нь зөөлрүүлээд оруулаад ирчихнэ.

Захиргааны аргаар тэгээд 1 зөрчлийн, торгуулийн аргаар. Ингэх юм бол хүн дуудах ч үгүй. Яагаад гэвэл бөөн юм болоод дуудаад ирээд нэг 300 мянган төгрөгөөр торгуулна гэж байна. Тэр мөнгийг нь бодвол нөгөө муу хүчирхийлэлд өртсөн хүн л олж ирэх байх. Чамаас болж 300 мянгаар торгууллаа гээд.

Хэрвээ ийм байх юм энэ хүчирхийлэлтэй яаж.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Яамнаас хариулах уу? 1 дүгээр микрофон. Албан тушаалаа хэлээрэй.

М.Цогтбаатар: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга Цогтбаатар байна аа. Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ саяын хүний эрхийн хуульд бол тодорхой зохицуулалтуудыг оруулсан ийм зохицуулалтууд орж байгаа юм. Энэ жендерийн тэгш бус байдлын талаар тодорхой арга хэмжээг авах энэ цаг үеийн зохицуулалт хийх цаг үе нь болсон байна гэдэг нь бол энэ тоон судалгаанууд дээр бүгдээрэнд нь гарсан байгаа. Тэгэхээр өнөөдөр харамсалтай нь энэ Хууль зүй, дотоод хэргийн яам болон ЦЕГ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн энэ цахим хөгжлийн яамныхан маань орж ирж хариулт өгсөн бол гэж бодож байна. Өмнө нь тэр хүүхдийн оролцооны чиглэлээр нэмээд хариулчихъя.

Ганхүлэг гишүүн өчигдөр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хуралдсан. Ерөнхий сайдын ахалдаг. Тэгээд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс сурагчдын зөвлөл болон энэ хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжихээр олон нийтийн үйл хэрэг болгохоор энэ тогтоол шийдвэр гарч байгаа.

Бид бүхэн энийг энэ Засгийн газраар баталгаажуулахаар энэ тогтоолын төслийг бэлдэж байна. Мөн энэ жилээс анх удаа Монгол Улс маань хүүхдийн хөгжил оролцоонд 4.9 тэрбум төгрөг зарцуулахаар ингээд төсөвлөсөн.

Ингээд Сангийн сайд болон Боловсролын сайдтай хамтарч 3 сайдын тушаалаар хүүхдийн хөгжил оролцоог дэмжих энэ норм нормативыг батлахаар бид бүхэн холбогдох 2 яамандаа санал хүргүүлэн ажиллаж байна.

Л.Энхнасан: Мөнхзул гишүүн хариулт өгье 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Булгантуяа гишүүн маш чухал асуудлыг хөндлөө. Үнэхээрийн энэ цахим орчинд ялангуяа охид эмэгтэйчүүдийн нэр төрд нь халдах, гүтгэх, доромжлох цахим D-PACK буюу зураг дүрсийг нь өөрчлөн нэр төрд нь халдах ийм асуудлууд ялангуяа сонгуулийн үеүдэд дээр маш их гарсан байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бол эмэгтэй улс төрчдийг бол илүү шүүмжлэх ийм хандлага бол байна аа.

Тэгэхээр ХЭҮК-ын энэ илтгэлээр хөндсөн асуудлын гол асуудал энэ эрх зүйн орчныг өөрчлөх асуудал байгаа. Тэгэхээр энэ дэлхий нийтээр энэ цахим жендерт төрүүлсэн хүчирхийлэлтэй холбоотой 36 төрлийн ийм нэр томьёонууд гарчихсан

байгаа. Энэ нэр томьёонуудыг бид нар харж энэний агуулга нь манай хууль тогтоомжид тусгагдсан байна уу, тусгагдаагүй байна уу? Ялангуяа энэ троллингийн асуудал энэ ди фек буюу бичлэг зургийг өөрчилж байгаа асуудал. Эд нарыг бид нар энэ эрх зүйн орчны хүрээндээ зохицуулах шаардлагатай.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Мөн энэ сүүлийн жилүүдэд энэ гэр бүлийн хүчирхийллийн асуудал эд нар өөрөө цахим орчинд үйлдэгдэж байгаа нь илүү хохирогчдод хоруу чанарыг авчирдаг. Амиа хорлохоос аргагүй байдалд хүргэдэг иймэрхүү асуудлууд бий болоод байгааг анхаарах шаардлагатай байна. Мөн энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой яригдаж байгаа энэ асуудлын хүрээнд торгуулийн энэ хариуцлага тооцохоор ингээд яригдаж байна. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс эсрэг байр суурьтай байдаг. Яагаад гэвэл энэ торгууль улам тухайн гэр бүлийн санхүү хохирогчийн төлөх ийм нөхцөл байдалд хүргэдэг учраас бол энийг бид нар анхаарч үзэж энэ гэр бүлийн өвөрмөц онцлог хэрэгцээнд нь нийцсэн шаталсан хариуцлагын тогтолцоог бий болгох явдал санал болгож байгаа.

Л.Энхнасан: 2 дугаар микрофон Энхбаяр дарга хариулна уу?

Д.Энхжаргал: Улс төрч эмэгтэйчүүд цахим хүчирхийлэлд өртөж байгаа талаар яг ямар ямар асуудлууд хөндөгдөж гарч байгаа вэ гэдэг судалгаа бол үндэсний судалгаа бол алга байна. Тэгэхээр энэ асуудал дээр Жендерийн үндэсний хороо яг энэ чиглэлийн судалгааг хийхийг хэвлэл мэдээллийн байгууллагуудад тухайлбал санал тавиад энэний үр дүнд хэвлэл мэдээллийн зөвлөл яг одоогоор Улсын Их Хурлын сонгууль болоод аймаг нийслэл, ИТХ-ын сонгуульд нэр дэвшиж дэвшиж байсан 370 эмэгтэйг асуулгаар, 20 эмэгтэйтэй тухайлан ярилцлагаар, яг 8 зорилтот бүлгийг очиж 40-өөс 50 минутын ярилцлага хийсэн. Судалгааг бол яг хийж байгаа гэдэг мэдээллийг өгөөд. Үүнийг тархаах, танилцуулах чиглэлд нь төсөв байхгүй гэдэг асуудлаар Үндэсний хороонд хандсан.

Энийг Үндэсний хорооны ажлын албанаас ямар ч гэсэн боломжтой байдлаар нь бид нар үндэсний хэмжээнд танилцуулах улс төрч эмэгтэйчүүд, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас гадна яг сошиал хүрээнд хэрхэн гүтгэгдэж ямар асуудлууд илүүтэй өртөөд байгаа вэ гэдэг дээр энэ судалгааны үр дүн.

Л.Энхнасан: Нэмж хариулах уу? 2 дугаар микрофон.

Д.Энхжаргал: Танилцуулахад нь хамтарч ажиллах гэж байгаа. Тэгээд энэ судалгааны үр дүнг танилцуулахад нь Улсын Их Хурлын зөвхөн эмэгтэй гэхгүй, эрэгтэй эмэгтэй бүх гишүүддээ урилга хүргүүлэе ээ. Энэ талаарх арга хэмжээг холбогдох байгууллагуудыг нь оролцуулж төрийн холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргэж авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжүүд судалгааны үр дүнд суурилагдаж өгөгдөнө өө гэж харж байна аа.

Л.Энхнасан: Баярлалаа. Булгантуяа гишүүн тодруулна уу. Энэ жендерийн үндэсний хороо ХЭҮК гэх мэтчилэн байгууллагууд уг нь асар их мэдээлэл зөвлөмжүүд гарч байгаа юм шиг байгаа юм. Тэгээд энүүнийг ерөөсөө 1 ийм хуульд тусгадаггүй. Энд бид нарт нэг авчирч ирж танилцуулсан болоод тэрүүнийг тусгах нь бараг хамгийн сүүлд бид нарын ажил болоод хууль тогтоомжийн хуулиар Засгийн газар ямар ямар хууль өргөн барина тэрнээс авч бид нар цар хүрээгээр тэнд зүйл,

заалтыг нь өөрчилж болдоггүй. Ингээд л ер нь ацан шалаанд орчхож байгаа юм яг үнэнийг хэлэхэд.

Тэгэхээр энэ бүгд дээр бид нар нэг жоохон арай өөрөөр ажиллахгүй бол болохгүй байна аа. Одоо бид нар ер энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх энэ санкцыг яагаад бууруулсан юм бэ гэсэн чинь гэр бүлийн хүчирхийлэл хэтэрхий их байгаа болохоор гэж хэлж байгаа юм. Хамгийн гайхалтай нь. Гэр бүлийн хүчирхийлэл хэтэрхий их байгааг эсрэгээрээ үүнийг чинь хариуцлагыг нь чангатгаж байж тэмцдэггүй юм уу?

Яахаараа зөөлрүүлэхээр гэр бүлийн хүчирхийлэл буурна гэж үзээд байгааг би бол хувь хүнийхээ хувьд ерөөсөө 1 дүгээрт ойлгохгүй байна. Үүн дээр манай та бүхэн зөвлөмжөө хүргүүлсэн үү? ХЗДХЯ руу энэ асуудлаар хүний эрхийн.

Л.Энхнасан: 6 дугаар микрофон.

Д.Энхжаргал: ХЭҮК-ын гишүүн Энхболд гишүүн яг энэ ажлын хэсэгт нь ороод ажиллаж байгаа. Тэгээд бид нар бол өөрсдийн тусгайлсан саналыг бол энд оруулж саналаа өгсөн байгаа.

Л.Энхнасан: Булгантуяа гишүүний энэ санал нэлээн чухал санал шүү. Тэгэхээр энийг саналдаа оруулж зөвлөмждөө оруулах шаардлагатай.

1 дүгээр микрофон Цогтбаатар дарга хариулна уу.

М.Цогтбаатар: Саяын асуудалтай холбогдуулан ХЗДХЯ-аас тухайн саналыг оруулж ирсэн. Хуулийн танилцуулга дээрээ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн гэсэн ийм танилцуулга хийгдсэн байна лээ. Тэгээд манай яамны зүгээс албан ёсоор хандсан тэр ХЗДХЯ-ан дээр энэ санкцыг ингэж бууруулах санал манайхаас хүргүүлээгүй ээ. Та бүхэн албан бичиг ийм юм хүргүүлсэн бол бид нар хүргүүлээгүй. Тэгээд Мандхай гэдэг хүнтэй би өөрөө холбогдож асуусан. Тэгээд тэндээс буцаж холбогдоно гээд холбогдоогүй л байгаа. Би нэг ганц 2 асуулт асуучихъя.

Л.Энхнасан: Энэ жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчийн онцлог хэрэгцээнд нийцсэн нийгэм, сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээ бол хангалтгүй байна гэж энэ тайлан дээр гарсан байна. Тэгэхээр энэ яг сэтгэл зүйн зөвлөгөө өгөх энэ ажил дээр ямар та нар санал оруулж байгаа вэ? Энэ дээр бас хүчирхийллийн хохирогчид урт хугацааны сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл заслын эмчийн хэрэгцээг нэмэгдүүлэх хохирогч төвтэй тусламж үзүүлдэг ийм сайжруулах шаардлагатай байна гэж тусгажээ.

Энийг яагаад зөвлөмждөө оруулаагүй юм бэ? Энийг оруулах оруулахгүй юм уу?

Хоёрдугаарт болохлоор энэ цахим орчин дахь энэ хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгаа энэ тэрийг харахад энэ эцэг эхчүүд өөрсдөө 73 хувь нь хүүхдүүдийнхээ цахим хэрэглээг хянадаг, 91 хувь нь бол өөрийн хүүхдийнхээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй гэж боддог боловч хүүхдийн судалгаанаас харахад тэдний 87 хувь нь бол цахим орчны хандлагад өртөж байсан гэсэн ийм судалгааны дүн гарчээ. Мөн энэ эцэг эхчүүд цахим орчин дахь хүүхдийн аюулгүй

байдлын суурь судалгаанд орсон. Эцэг эхчүүдийн 98.6 хувь нь хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад тусалдаг аппликэйшний тухай огт мэдэхгүй, яаж тохиргоог нь хийхээ мэдэхгүй, ямар хамгаалалт хийхээ мэддэггүй гэж бичиж. Тэгэхээр эд нар энэ эцэг эхчүүдийг бас энэ хүүхдүүддээ интернэтийн энэ хэрэглээг зохицуулахад тулгарсан асуудал дээр анхаарах шаардлагатай юм уу? Энэ дээр ямар ажил хийгдэж байгаа вэ? Энийг ер нь анхаарч байгаа юу?

Мөнхзул дарга хариулна уу?

Х.Мөнхзул: Энэ ерөнхийдөө нөгөө зөвхөн цахим орчинд үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл биш ерөнхий жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдод зөвлөгөө үйлчилгээ тусламж үйлчилгээ үзүүлэх ийм тогтолцоо бол Монгол Улсад байгаа. Харин энэ бол нэг цэгийн үйл үйлчилгээ, хамтарсан баг, хамгаалах байруудаар дамжуулан Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас болон ингээд холбогдох байгууллагаас хууль, эрх зүйн орчны хүрээнд тогтолцоо бүрдээд ингээд ажиллаж байгаа. Харин энэ дээр энэ бол нэг цэгийн үйлчилгээ түр хамгаалах байрны энэ хүний нөөцийн асуудал хомсдолтой, үйлчилгээ үзүүлж байгаа орчин нөхцөл нь стандартад нийцээгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмадад гээд ийм төрөлжсөн ийм үйлчилгээ байхгүй. Мөн энэ хохирогчид үзүүлж байгаа энэ сэтгэл заслын үйлчилгээ, сэтгэл засалч эмчийн хүрэлцээ маш хангалтгүй байгаа асуудлыг энэ удаагийн илтгэлээр бид нар хөндсөн байгаа. Мөн цахим технологи жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдын сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудлууд бол хангалтгүй байна гээд. Тэгээд бид нар уг нь бол энэ илтгэлдээ энэ сэтгэл санааны хохирлыг асуудлыг нөхөн төлүүлэх энэ сэтгэлд учирсан гэм хорыг нөхөн төлөх тогтолцоог бэхжүүлэх, энэ тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээгээ сайжруулах талаар зөвлөмж өгсөн байгаа. Гэвч Их Хурал руу яг ингээд хандсан энэ зөвлөмждөө яг энийг оруулаагүй байгаа.

Яагаад гэвэл нөгөө комиссоос орж байгаа нөгөө илтгэл болгоны зөвлөмж нь маш их юу байгаа учраас бид нар энийг заавал Их Хурлын тогтоолд оруулахгүйгээр холбогдох байгууллагуудынх нь шугамаар шийдвэрлэх боломжтой юм уу гээд харсан байгаа.

Л.Энхнасан: Асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн үгээ хэлнэ үү?

А.Ариунзаяа: Хүүхдийн байгууллагын 100 жилийн ой гэж би түрүүн хэлсэн тиймээ. 1.2 сая хүүхэд. Тэгээд хүүхдийн өмнө хэн хариуцлага хүлээгээд байгаа юм бэ? Хэн үүрэг хүлээгээд байгаа юм бэ гэхээр дан ганц Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч биш дан ганц эмэгтэй гишүүд ч биш ер нь бол 2.3 сая иргэн, том хүн насанд хүрэгчид үүрэг хүлээж байгаа. Тэгээд энэ сүүлийн 5 жилийн гэдэг юм уу 2019-өөс 2023 оны Монгол Улсад бүртгэгдсэн осол гэмтлийн тархацын судалгаа байгаа юм. Гантуяа дарга сууж байна. Энэ мэдээлэл дээр суурилоод ер нь хүүхдийн амьд явах эрх хангагдаж байна уу үгүй юу гэдэг дээр бид нар дүгнэлт хиймээр юм байна гэж харагдсан.

Тэгэхээр хүний эрхийн 25 дахь илтгэл нь хүүхдийн амьд явах эрх хангагдаж байна уу үгүй юу гэдэг дээр дүгнэлт хийгээсэй гэж би бодож байна. 0-14 насны хүүхдүүдийн энэ осол гэмтлийн зөвхөн 2023 оны тоон мэдээллийг би та бүхэндээ хэлье. Амьгүй механик хүчинд өртөх нэг жилд 9131, зам тээврийн осолд өртөх 5111. Үүнээс 51 хүүхэд нас барсан 0-14 насны.

Хүчирхийллийн шалтгаант өвчлөл буюу эрүүл мэндийн байгууллагад хандсан 0-14 насны 1338 хүүхэд, 0-4 насны 3300 хүүхэд түлэгдсэн, 5-аас 9 насны 637 хүүхэд түлэгдсэн, 10-аас 14 насны 343 хүүхэд түлэгдсэн, 0-4 насны 12 хүүхэд амиа хорлосон. Зөвхөн 2023 онд. Тэр жаахан амьтад ямар учир шалтгаан байна вэ? Ер нь энэ Монгол Улсын энэ тулгамдсан асуудлуудын гол учир шалтгаан нь энэ хүчирхийлэл болоод энэ архи, тамхины хэрэглээ, архины хэрэглээ, архи согтууруулах ундааны хэрэглээ маш өндөр байгаад байгаа. Тэгэхээр энэ 25 дахь илтгэл бол яг энэ хүүхдийн амьд явах эрх, томчуудын үүрэг оролцоо. Бид нар зөвхөн хүчирхийлэл бэлгийн хүчирхийлэл яриад зогсохгүй. Энд бол үнэхээрийн хүүхдүүдээ бид нар өдөр тутамдаа маш их эрсдэлд оруулж байна. Тэгээд хэн нь буруутан бэ гэхлээр томчууд бид өөрсдөө. Ээж аавууд нь өөрсдөө хүүхдээ зодоод хэтрүүлээд тухайн хүүхэд нь гэмтэл аваад гэмтэлд хандаж байна шүү дээ 2023 оны хувьд. 1338 хүүхэд 0-14 насны. Тэгээд өөрсдийгөө нэгнийгээ ч маш ихээр томчуудын нийт хүчирхийллийн шалтгаант осол гэмтлийн энэ шалтгаан 18 мянган том хүн эрүүл мэндийн байгууллагад энэ хүчирхийллийн улмаас хандсан байгаа. Зам тээврийн осолд нийт 23548 хүн өртсөн байгаа байхгүй юу. Тэгээд амьд явах эрхийг маань хангахгүй байна гээд яагаад зөвхөн энэ 126, Засгийн газарт, сайд нарт буруу өгөөд байгаа юм. Энэ чинь бидний өөрсдийн хүний өөрийнх нь энэ харилцаа хандлага зан үйлтэй холбоотой асуудлууд байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд өөрсдийгөө зохицуулдаг юм байжээ гэж өөрсдөд нь үлдээлээ гэхэд хүүхдийн өмнө бид нар хариуцлага хүлээж байгаа. Тэгэхээр хүүхдийн өмнө бид нар энэ асуудлыг зөвхөн Нийгмийн бодлогын байнгын хорооны асуудал биш гэдэг нь эдгээр тоон дээр харагдаж байгаа байхгүй юу. Зам тээврийн осол бусад хүчирхийллийн асуудлууд. Цахим дээрэлхэлтийн асуудал. Тэгэхээр энэн дээр л хэдүүлээ бодитой дүгнэлт хийж яалт ч үгүй бүхий л шатанд 1 дүгээрт хүүхдийг тавимаар байна. Бид нар дандаа 1 дүгээрт одоог хүртэл Засгийн газар ч тэр төсөв Улсын Их Хурал бүхий л бодлогуудаа макро түвшний эдийн засаг мөнгөн дээр л хамаг анхаарлаа хандуулж байна. Гэтэл хүний хөгжил нөгөө хүүхэд маань яах билээ? Хүүхэд бидний ирээдүйд л гэж байгаа юм бол бид нар өнөөдөр хүүхдүүдээ хамгаалахгүй бол ямар сайхан орчин, ямар сайхан хөгжил байх юм. Хэнд хэрэгтэй юм энэ хөгжил чинь.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ үү.

С.Эрдэнэбат: Бид хэдийг ингээд л юм яриад сууж байхад шууд зөрүүлээд л манай зарим хэвлэл мэдээллийн байгууллагууд шал өөр өнцгөөр нь ингээд л нөгөө хэвлэл мэдээлэл сошиалыг чинь хаах гээд эд нар яриад байна гээд л. Ингээд л яриад эхэлчхэж хүүхдийн асуудал ярьж байгаа шүү дээ энэ дээр. Энэ тоон мэдээллүүдийг ингээд нөгөө хүний эрхийн статистик тоонуудыг харах ёстой. Таны хүүхэд магадгүй цаана ямар орчинд, хэнтэй яаж харьцаад, ямар эрсдэлд ороод байгааг бид нар таашгүй болчхоод байна аа. Хэт задгай байна манай энэ сошиал орчин. Манай улс шиг томчууд нь жоохон хүүхдүүдтэйгээ хамт нэг сувгаар хоорондоо хэрүүл хараал бие биеийнхээ үзэн ядалт элдэв янзын ялгаварлан гадуурхалт руу ингээд дунд нь байж байдаг тийм улс орон ер нь байдаг юм уу? Тэр АНУ, Европын улс орнууд чинь хязгаарладаг л юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр бид нар чинь үндсэндээ хэвлэл мэдээлэл сошиал бүр хэт ийм талаар харин тэр үзэл бодлоо нээлттэй, ажил хэрэгч байдлаар, эрүүл саруул ухаанаар, баримттай, нотолгоотой шүүмжлэх яах эрхийг хасах тухай огт энд сайн

яриагүй энд байгаа хүмүүс. Харин энэ дундуур хүүхдүүд маань ирээдүйд бид хэдийг хажуунаас ажиглаж байгаа. Эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг гэдэг шиг бид хэдийн нийгэмд хандаж байгаа хандлага, санаатай санамсаргүй Их Хурлын чуулган хүртэл нээлттэй явдаг. Энэ дээр янз янзын бие биеийгээ гүтгэх, доромжлох, дээрэлхэх ийм асуудал маань нийгэмд шууд тусгал болж очоод ёс зүй, хүмүүжил сошиал орчинд байгаа тэр тролл хаягууд чинь яг үнэндээ хэнийг яаж онилох вэ? Хамгийн эмзэг хэсэг рүү л дайрдаг. Гадаадаас ч гэсэн дотоодоос баригдах аргагүй.

Тийм учраас энэ дунд хүүхдүүдээ яаж хамгаалах вэ? Эмэгтэйчүүдээ яаж хамгаалах вэ? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаатай байдалтай хүмүүсээ яаж хамгаалах вэ гэдэг тал дээр өнөөдөр манайхан ярьж байгаа учраас энэ дээр би зориуд хэлэх гэсэн юм. Дөнгөж сая бид хэдийн ярьсан асуудлыг эд нар нийлж суучхаад тэгээд ямар юу гэнэ вэ янз янзын тэр юугаар нь бид нарыг тавиад ингээд л ярьж л байна л даа. Харамсаж байгаа юм.

Тийм учраас манай энд хэрвээ үзэж байгаа бол хэвлэл мэдээлэл олон нийт бид нар зөв эрүүл санал шүүмжлэлийг бол харин хязгаарлахгүй. Харин энэ хүүхэд хүчирхийлэх гээд түрүүн ярилаа шүү дээ. 1 хүн 84 хүүхдийг хуурамч хаягаар өөрийнхөө эрхэд оруулаад, эдийн засгийн болон санхүүгийн болон бэлгийн хүчирхийллийг чинь хийчихсэн байна аа. Яг ийм зүйл бидний үр хүүхдүүдэд хэнийх нь ч хажууд маш ойрхон явж байхыг үгүйсгэх арга байхгүй. Энийг л өнөөдөр бас тавьж үзэж одоо энэ төсөв, санхүү, хөрөнгө хэлэлцэж байгаа үе дээр хүчээ энэ байгууллагууд маань нэгтгэж ажиллах ёстой байх. Цэрэг, цагдаа хууль хүчний байгууллагууд. Мөн одоо иргэд ч гэсэн өөрсдөө олон нийтийн байгууллагууд гээд. Тэгээд энэ утгаар нь л бид бүхэн бие биеийгээ нэг үзэн ядахын дон тусчихсан нэг улсад цөөхүүлээ ийм байдалтай байгаад байхад эргээд ингээд бодоход зөв бурууг нь ялгаж энэ нийгэм дундаас чинь зөв дүгнэлт хийхэд тун хэцүү тэгээд дундуур нь хүүхдүүд ороод ирчихсэн. Тэгээд л энэ зүйлийг үгээ хэлэх эрх чөлөө гээд байдаг. Нэг хүний эрх, нөгөө хүний эрхээр хязгаарлагдана шүү дээ. Тэгээд бүүр хүүхдийн эрх гэдэг нэг номерт. Тэр утгаар нь бол хэлж байгаа юм шүү. Энийг шууд дамжуулж байгаа бас хэвлэл мэдээллийнхэн маань зөвөөр ойлгоорой. Энд хүний эрхийн факттай, тодорхой мэргэжлийн байгууллагуудын, олон улсын стандартын дагуу үнэлээд дүгнэчихсэн тоо, тухай статистик яримаар байна.

Ер нь хаалттай бас зарим асуудлыг нь яривал илүү их тод юмаа бид нар ярьсан тиймээ. Нээлттэй хамаагүй ярьж болохгүй, улам сэдэл төрүүлээд байдаг хүртэл асуудал байдаг л юм байна л даа.

Тийм учраас энэ тал дээр бол цаашдаа зарим тэр ноцтой асуудлын хүрээнд бол Байнгын хороо хаалттай хэмжээнд нэг яривал илүү асуудлуудыг илүү ухаж, тэр мөрдөн байцаалт, хяналт, цэрэг, цагдаа, прокурор, тагнуултай холбоотой асуудлуудыг хүртэл ярих хэрэгтэй юм байна л гэж бодож байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Хуралдаанд асуулт асууж, үг хэлсэн Улсын Их Хурлын гишүүдийн саналыг тусган санал, дүгнэлтээ ХЗБХ-нд хүргүүлнэ.

Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дүгээр илтгэлийн 4, 5 дугаар бүлэгтэй холбоотой тайланг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ болон ажлын хэсэгтээ баярлалаа.

18.55 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА